



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.12.18 № ЗГ-1/139
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай**

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

000254006199



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.12.18 № НХ / 3562
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт ¹²² хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

• 000255019446

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“2.ХЭЛЭЛЦСЭН нь: Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025 12 17 № 1/2804

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР
ТАНАА

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн
төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан
боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль
тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8
дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн
мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.


Б.ЭНХБАЯР

151603677
А5.файл.2025



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.12.18 № 01/11048
танай 2025.12.17-ны № 01/3392 -Т

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР ТАНАА

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн
төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад
хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн
20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг
үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002377

БАТЛАВ.

БАТЛАВ.

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН
САЙД

Ж.ЭНХБАЯР

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

2025 оны 12 дугаар сарын 16 ны өдөр

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050”¹ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “...эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэсэн зорилгыг дэвшүүлж, “бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх” замаар 2030 он гэхэд хүрэх зорилтыг тавьсан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”²-ийн “Эдийн засгийн бодлого” гэсэн 3 дугаар бүлэгт “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ.” гэж, 3.1-д заасан “Эдийн засгийн эрх чөлөө” хэсгийн 3.2.2.1-д “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2020 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

² Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2024 оны №35 дугаарт нийтлэгдсэн.

Бизнес, худалдаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангасан нэгдсэн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, эдийн засгийг зохицуулахтай холбоотой 200 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд аж ахуйн үйл ажиллагааны явцад төр болон аж ахуй эрхлэгчийн хооронд баримтлах, эдийн засгийн үйл ажиллагаа чөлөөтэй байх, тогтвортой байдлыг бий болгоход чиглэсэн ерөнхий зарчмуудыг тогтоож нэгтгэсэн хууль одоогоор байхгүй байна.

Олон улсын туршлагаас харахад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх чөлөөг хуульд тусгаж, төрийн оролцоог хязгаарлах нь бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад эерэг нөлөө үзүүлж, төр болон хувийн хэвшлийн албан ёсны зөвшилцлийн тогтолцоотой, бодлогын тодорхой зарчимтай байх нь төрөөс эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд иргэд, олон нийт болон бизнес эрхлэгчдийн итгэлийг төрүүлж, залгамж чанартай, урьдчилан тооцоолох бололцоотой, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, эдийн засаг, хөрөнгө оруулалтын өсөлтийг хангаж, тогтвортой байдлыг хадгалахад чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Манай улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай адил төстэй орнуудад эдийн засгийн эрх чөлөөг хамгаалж, хэт их хяналт, баримт бичгийн шаардлагыг багасгаж, төр, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хамтын ажиллагааг хуульчилж, хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улс, Гүрж Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс болон Бүгд Найрамдах Эстони Улс эдийн засгийн эрх чөлөөг хангах бие даасан хууль, эрх зүйн зохицуулалттай байна.

Эдийн засгийн эрх чөлөөг зөвхөн Үндсэн хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болох хүний салшгүй эрх бөгөөд үүнд аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, хэлцэл хийх, эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах зэрэг эдийн засгийн үйл ажиллагаатай холбогдох эрх чөлөөг хамруулсан өргөн ойлголт юм.

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн нэгдсэн бодлого, төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох асуудал хамаардаг.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн

өмчийн халдашгүй байдлыг хангах, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл, түүнийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

1.2 Практик шаардлага

Дэлхийн өв уламжлалын сангаас “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг засаглалын үр ашиг, Засгийн газрын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээл гэсэн нийт 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлтийг ашиглан тооцдог бөгөөд Монгол Улс 2024 онд нийт дүнгээрээ 176 улсаас 60.6 оноотойгоор 76 дугаар байранд эрэмбэлэгдсэн ба V түвшинд байна.

Бүлэг	Шалгуур үзүүлэлт/дэд хүчин зүйлс	Оноо	Онооны ангилал	Байр
Засаглалын үр ашиг	Өмчийн эрх	48.8	муу	92/176
	Шүүхийн үр ашиг	34.8	бага	71/176
	Төрийн зарчимт байдал	55.0	муу	117/176
Засгийн газрын хэмжээ	Татварын ачаалал	84.0	бүрэн	59/176
	Засгийн газрын зарлага	62.0	дунд	113/176
	Төсвийн сахилга бат	64.3	дунд	83/176
Зохицуулалтын үр ашигтай байдал	Бизнесийн эрх чөлөө	68.0	дунд	79/176
	Хөдөлмөрлөх эрх чөлөө	67.5	дунд	24/176
	Мөнгөний эрх чөлөө	67.9	дунд	117/176
Нээлттэй зах зээл	Худалдааны эрх чөлөө	74.4	сайн	72/176
	Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал	50	бага	119/176
	Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал	50	бага	96/176

Шалгуур үзүүлэлтүүдийн оноогоор нийт 176 орноос “өмчийн эрх”-ийн үзүүлэлтээр 92-т эрэмбэлэгдэж “муу”, “төрийн зарчимт байдал” үзүүлэлтээр 117-д эрэмбэлэгдэж “муу”, “бизнесийн эрх чөлөө” үзүүлэлтээр 79-т эрэмбэлэгдэж “дунд”, “хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал” үзүүлэлтээр 119-т эрэмбэлэгдэж “бага” гэж үнэлэгдсэн байна. Үүнээс үзэхэд иргэдийн эд хөрөнгө өмчлөх, эзэмших эрх чөлөөг хангах, төрийн албаны авлигатай тэмцэх, бизнесийн үйл ажиллагаанд аливаа төрөөс тавьсан хязгаарлалтыг бууруулах, хөрөнгө оруулалтын эрсдэлийг багасгах зэрэг шаардлагатай байгааг харуулж байна.

Энэ хүрээнд бизнес, хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой 7 чиглэлээр дүн шинжилгээ хийж, дараах хэрэгжүүлэх шаардлагатай цогц арга хэмжээг тодорхойлсон.

1. Бизнес эхлүүлэхтэй холбоотой хуулийн этгээд байгуулах, эрчим хүчинд анх

холбогдох, өмчийн бүртгэл хийлгэх, тусгай зөвшөөрөл олгох процессын шат дамжлага, үйл ажиллагааг хялбарчлах;

2. Зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, татварын хувь хэмжээг салбар харгалзан бууруулах;

3. Гадаад худалдааг хялбарчлах хүрээнд бүрдүүлэх баримт бичигт хугацааг бууруулах, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх;

4. Гадаадын хөрөнгө оруулагчдыг эрх тэгш авч үзэх, хөрөнгө оруулалтын зохицуулалт, үр ашиг сул байдал, хүнд суртлыг бууруулах, хөрөнгө оруулалтын баталгааг хангах;

5. Маргаан шийдвэрлэлттэй холбоотой шүүхийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, авлигын эрсдэлийг бүрдүүлж буй тогтолцооны гажуудлыг арилгах;

6. Төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх хугацааг багасгах;

7. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрийг хангах.

Монгол Улсын эдийн засагт 1994 оноос хойш уул уурхайн салбарын эзлэх хувь тэлж, уул уурхайн бус салбар, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь агшжээ. Тухайлбал, уул уурхайн салбарын нийт ДНБ-д эзлэх жин өнгөрсөн 30 жилд 10 хувиас (1994) 27 хувь болж (2024) өссөн бол хөдөө аж ахуйн салбарын жин 27 хувиас 7 хувь болж буурчээ. Барилга, бүтээгдэхүүний цэвэр татвараас бусад үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь 1994 онд 35 хувийг эзэлдэг байсан бол 2024 онд 44 хувь болж өссөн байна.

Гадаад талаас сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэл өөрчлөгдөж байгаа энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлсэн. Улмаар энэ нь манай улсын экспортын орлого буурах, инфляц өсөх, гадаад санхүүжилтийн өртөг, зардал нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна. Иймд урт хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсад 1990 оноос 2025 оны II дугаар улирал хүртэл нийт 49.65 тэрбум ам.долларын гада адын хөрөнгө оруулалт орж ирснээс 74 хувь нь уул уурхайн олборлолт, 10 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 16 хувийг эзэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байна. Уул уурхайн олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор сүүлийн 10 жилийн дунджаар

гадаадын шууд хөрөнгө оруулалтын 42 хувийг “Оюутолгой” ХХК дангаар бүрдүүлж байгаа ба 2024 оны гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 хувь нь уул уурхайн салбарт хамаарч байна.

Аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрээр ялгаварласан, үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан зохицуулалт болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, хүсэлтээ шийдвэрлүүлэх хугацаа, төлбөр хураамжийг ялгамжтай тогтоосноос шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хараат болон охин компани, компанийн нэгдлийг байгуулж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодит үр өгөөжийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлоход хүндрэл үүсгэсээр байна.

Түүнчлэн Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж, хориглосон, эсхүл гадаадын иргэн, хуулийн этгээдэд нэмэлт шаардлага тавьсан нийт 40 гаруй хууль байх бөгөөд эдгээрээс зүй ёсны буюу байх ёстой шаардлагыг тогтоосон хуулиудаас гадна гадаадын иргэн, хуулийн этгээдийг Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулах боломжийг хязгаарласан, хориглолт тогтоосон, ач холбогдолгүй нэмэлт шаардлагыг бий болгосон хэд хэдэн хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн өмчлөх эрхийг хамгаалах, аж ахуйн үйл ажиллагаагаа чөлөөтэй, саадгүй явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг цогц байдлаар шинэчлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан аж ахуй эрхлэгчдийн эрхийг бодитой, үр дүнтэй хамгаалах, хөрөнгө оруулагч болон төр хоёрын өөр өөр ашиг сонирхлыг харилцан тэнцвэртэйгээр хамгаалан зохицуулах нь чухал байна.

Хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж буй бас нэг томоохон хүчин зүйл нь төрийн шийдвэр гаргалттай холбоотой үйл явц юм. Монгол Улс хуулийн хэрэгжилтийг хангах, асуудлыг шийдвэрлэх талаарх болон эрх ашиг нь хөндөгдөх этгээдэд сонсох ажиллагааг хангалттай хийдгүйгээс хөрөнгө оруулагч нарт асар их зардал чирэгдэл учирч байна. Иймээс хөрөнгө оруулагч нарын зүгээс аливаа эрх ашигт нь хамаарах бодлогын шийдвэрийн талаар мэдэх эрхийг хангах, саналаа өгөх боломжийг бүрдүүлдэг байх нь чухал юм. Хэдийгээр Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд энэ талаар тусгасан ч хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх хязгаарлалтын заалтууд холбогдох хуулиудад байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд шинээр хөрөнгө оруулалт татахаас гадна, нэгэнт хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, үүссэн асуудлыг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой. Олон улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын 50 орчим хувийг дахин хөрөнгө оруулалтын орлого бүрдүүлдэг байна.

Монгол Улсын хувьд зарим төрийн болон нутгийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд, албан тушаалтнуудын хариуцлагагүй үйлдэл, эс үйлдлээс үүдэн Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэхгүй байх, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах, цаашлаад манай улсын хөгжлийн зорилтод чухал хувь нэмрээ оруулдаг гадаад түнш орнуудтай харилцах харилцаанд ноцтой үр дагавар учруулах болзошгүй тохиолдлууд гарах эрсдэлийг бий болгож байна.

Одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхээр орон тооны бус зөвлөлтэй байхаар тусгасан боловч гомдлын төрөл, гомдлыг шийдвэрлэх процесс тодорхойгүй байснаар хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг. Түүнчлэн төрийн байгууллага, албан хаагчийн хууль бус үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгө оруулагчийн эрх ашиг хохирох тохиолдолд төрийн албан хаагчийн буруутай үйлдэлд хариуцлага тооцох шаардлагатай байна.

Мөн дээр дурдсан нөхцөл шалтгаануудыг харгалзан “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал, зохицуулалтын үр ашигтай байдлыг сайжруулах, хөрөнгө оруулагчийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх ачааллыг багасгах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл, түүнийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог багасгаж, төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх талаар төрөөс баримтлах зарчмыг тогтоох, экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, бизнес эрхлэх орчныг сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төслийг дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагад үндэслэн дараах агуулгаар боловсруулсан болно:

Нэгдүгээр бүлэгт. Хуулийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, эдийн засгийн эрх чөлөөг хангахад баримтлах зарчим буюу аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, ашиг олох, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн өмчийн халдашгүй байдлыг хангах, шударга өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх, хөрөнгө оруулах, бизнес эрхлэх орчныг тогтвортой байлгах, төрийн үйл ажиллагааны ил тод болон мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах, үндэсний үйлдвэрлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зарчмыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт. Эдийн засгийн эрх чөлөөг хангах үйл ажиллагаа буюу төрөөс аж ахуйн үйл ажиллагаанд зохицуулалт хийх, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээс бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх, аж ахуйн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг давхардалгүй хийх, төрийн байгууллагууд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчээс мэдээллийг дахин дахин шаардаж хүндрэл үүсгэхгүй байх, өргөдөл, гомдол гаргах эрхийг баталгаажуулах, төр болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хооронд байнгын ажиллагаатай зөвлөлдөх тогтолцоо бүрдүүлэх, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой төрийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг тусгана.

Гуравдугаар бүлэгт. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тусгана.

Гурав. Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Энэ хуулийн төсөл батлагдсанаар дараах эдийн засаг, нийгэм, хууль зүйн эерэг үр дагаврыг бий болгоно:

1/Иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог бууруулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн эдийн засгийг бүрдүүлж, аж ахуй эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах суурь зарчмыг бий болгоно;

2/Иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаанд төрөөс оролцох буюу тэдгээрийг дур зоргоороо шийдвэр гаргах боломжийг хязгаарлана;

3/Уул уурхайн салбараас хэт хамааралтай, гадаад зах зээлийн савлагаанд мэдрэмтгий эдийн засагтай Монгол Улсын хувьд тогтвортой, өрсөлдөх чадвартай, ил тод эдийн засгийн тогтолцоонд шилжиж, зах зээлд суурилсан урт хугацааны өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчин, итгэлцлийг нэмэгдүүлнэ;

4/Зах зээлийн өрсөлдөөн, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ;

5/Бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгана;

6/Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагчийн хууль ёсны баталгааг хангах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, түүнийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар улсын төсөвт ачаалал үүсгэхгүй болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

--oOo--

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал, зохицуулалтын үр ашигтай байдлыг сайжруулах, хөрөнгө оруулагчийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх ачааллыг багасгах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн дараах агуулгаар боловсрууллаа.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Тус бүлэгт хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хангахад баримтлах үндсэн зарчмуудыг тусгасан. Үүнд:

- хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг хуулийн дагуу чөлөөтэй эрхлэх;
- өмчийн халдашгүй байдлын зарчим;
- аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн тэгш эрхийн зарчим;
- шударга өрсөлдөөний зарчим;
- оролцоог хангах зарчим: аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай, тогтвортой орчныг бий болгох зорилгоор төрийн бодлого, хууль, эрх зүйн шинэчлэлийг хийхдээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн саналыг сонсох, оролцоог хангана;
- хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх зарчим.

Хоёрдугаар бүлэг. Эдийн засгийн эрх чөлөөг хангах үйл ажиллагаа

Хуулийн тус бүлэгт эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, төрийн байгууллага, албан тушаалтанд хориглох үйл ажиллагаа, Эдийн засгийн бодлогын зөвлөлийн талаар тусгасан.

- Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эрх чөлөөг баталгаажуулах, төрийн оролцоог багасгах, хууль тогтоомжийг тодорхой, ойлгомжтой болгох, олон нийтийн оролцоог хангах, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэгдсэн. Мөн төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, зөвшөөрөл олголтыг цахим хэлбэрээр явуулах, мэдээллийг нээлттэй байлгахад чиглэсэн эдийн засгийн эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтыг тусгасан.

- Төрийн байгууллага, албан тушаалтнуудад эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах, хууль бусаар өмчийг хураах, хуульд заагаагүй хяналт шалгалт хийх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг гүтгэх, эд хөрөнгийг сүйтгэх, нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараах зэрэг үйл ажиллагааг хориглосон.

- Эдийн засгийн бодлогын зөвлөл нь төр, хувийн хэвшлийн хооронд байнгын зөвлөлдөх тогтолцоог бүрдүүлж, хууль тогтоомжийг боловсруулахад оролцоог хангах, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллахаар эрх үүргийг тодорхойлсон. Тус зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд ахалж, бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувьд хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

Гуравдугаар бүлэгт. Бусад зүйл

Тус хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгаж, төрийн байгууллага албан тушаалтны хариуцлагыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Уг хуулийн төсөлтэй холбогдуулан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Тус хуулийн төсөл батлагдсанаар гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагчийн хууль ёсны баталгааг хангах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлнэ.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль нь төрийн оролцоог бууруулж, өрсөлдөөнт зах зээлийг бүрдүүлэх, аж ахуй эрхлэгчдийн эрхийг хамгаалах суурь зарчмыг тогтоож, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжиж, өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн эдийн засаг бүрдэнэ.

--oOo--

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогод “...эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэсэн зорилгыг дэвшүүлж, “бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх” замаар 2030 он гэхэд хүрэх зорилтыг тавьсан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Эдийн засгийн бодлого” гэсэн 3 дугаар бүлэгт “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ.” гэж, 3.1-д заасан “Эдийн засгийн эрх чөлөө” хэсгийн 3.2.2.1-д “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, эдийн засгийг зохицуулахтай холбоотой 200 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд аж ахуйн үйл ажиллагааны явцад төр болон аж ахуй эрхлэгчийн хооронд баримтлах, эдийн засгийн үйл ажиллагаа чөлөөтэй байх, тогтвортой байдлыг бий болгоход чиглэсэн ерөнхий зарчмуудыг тогтоож нэгтгэсэн хууль одоогоор байхгүй байна.

Олон улсын туршлагаас харахад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх чөлөөг хуульд тусгаж, төрийн оролцоог хязгаарлах нь бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад эерэг нөлөө үзүүлж, төр болон хувийн хэвшлийн албан ёсны зөвшилцлийн тогтолцоотой, бодлогын тодорхой зарчимтай байх нь эдийн засаг, хөрөнгө оруулалтын өсөлтийг хангаж, тогтвортой байдлыг хадгалахад чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан.

Тус хуулийн төсөл батлагдсанаар төрийн оролцоог бууруулж, өрсөлдөөнт зах зээлийг бүрдүүлэх, аж ахуй эрхлэгчдийн эрхийг хамгаалах суурь зарчмыг тогтоохын

зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалтыг татах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ. Хууль батлагдсанаар улсын төсөвт ачаалал үүсгэхгүй бөгөөд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчид төрийн үйлчилгээг шуурхай авах, санал хүсэлт, эрх ашгаа хамгаалуулах тогтолцоо бий болж, зардлаа хэмнэх, үйл ажиллагаагаа саадгүй явуулах нөхцөл бүрдэнэ.

Уг хуулийн төсөлтэй холбогдуулан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4-т заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн санал авахаар 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яамны цахим хуудсанд, 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем тус тус байршуулж нээлттэй санал авсан.

Түүнчлэн хуулийн төслийн эхний хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын төлөөлөл оролцуулсан бөгөөд мэргэжлийн холбоодтой уулзалтууд хийсэн.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд, мөн Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн хуралдаанд тус тус танилцуулсан.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд Монгол Ардын Намын бүлгийн гишүүд, Засгийн газрын гишүүд, холбогдох төрийн байгууллага, олон нийтийн саналыг авч тусган, эцэслэн боловсруулаад байна.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл

№	Бүлэг	Зүйл	Тайлбар
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 2 дугаар зүйл. Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 4 дүгээр зүйл. Нэр томъёоны тодорхойлолт 5 дугаар зүйл. Эдийн	1/ Энэ зүйлд хуулийн зорилтыг тодорхойлсон. Энэ хуулиар иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, аж ахуйн үйл ажиллагаанд төрөөс баримтлах зарчмыг тогтоох, төр оролцоог багасгаж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. 2/ Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаас бүрдэнэ. Монгол

		засгийн эрх чөлөөг хангах зарчим	Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. Түүнчлэн, Монгол Улсын хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн актын хэм хэмжээ нь энэ хуулиар баталгаажуулсан эдийн засгийн эрх чөлөөг хангах хэм хэмжээг дордуулахыг хориглоно. 3/ Иргэн, аж ахуйн нэгж Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийн дагуу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд баталгаатай эдлэх эдийн засгийн эрхийг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно. . 4/ Төрийн байгууллага, албан тушаалтнаас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны акт, хэм хэмжээ батлах, хэрэгжүүлэхэд энэ хуулийг дагаж мөрдөнө. 5/ “Эдийн засгийн эрх чөлөө”, “аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч”, “аж ахуйн нэгж” гэх нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан. 6/Эдийн засгийн эрх чөлөөг хангах зарчим: -хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг хуулийн дагуу чөлөөтэй эрхлэх -өмчийн халдашгүй байдлын зарчим -аж ахуй үйл ажиллагаа эрхлэгчийн тэгш эрхийн зарчим -шударга өрсөлдөөний зарчим -оролцоог хангах зарчим: аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай тогтвортой орчныг бий болгох зорилгоор төрийн бодлого, хууль эрх зүйн шинэчлэлийг хийхдээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн саналыг сонсох, оролцоог хангана -хуулиар нууцад хамааруулахаас бусад мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх зарчим
2	Хоёрдугаар бүлэг. Эдийн засгийн эрх чөлөөг хангах үйл ажиллагаа	6 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого 7 дугаар зүйл. Төрийн байгууллага, албан тушаалтанд хориглох үйл ажиллагаа 8 дугаар зүйл. Эдийн засгийн бодлогын зөвлөл	6/ Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эдийн засгийн эрх чөлөөний баталгааг хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцохгүй, хохирол, саад учруулахгүй байхад чиглэнэ. Төрийн бодлого, хууль тогтоомж, захиргааны шийдвэр нь тодорхой, хоёрдмол утгагүй, нийтэд ойлгомжтой байна. Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, захиргааны шийдвэр гаргах тохиолдолд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч, мэргэжлийн холбоодод урьдчилан мэдэгдэх, оролцоог хангах, шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэлэлцүүлгийг нэгээс доошгүй удаа зохион байгуулна. Төрийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем, албаны цахим шуудан, нийтийн

		мэдээллийн системийг ашиглан, эсхүл нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр шуурхай үзүүлнэ Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, зөвшөөрөл олгох ажиллагааг хялбарчлах, гомдол шийдвэрлэлтийн талаар олон нийтэд нээлттэй үйл ажиллагааг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна. Төрийн хяналт, шалгалтыг биечлэн хийх шаардлагатайгаас бусад тохиолдолд цахим хэлбэрээр хийх нөхцөлийг бүрдүүлнэ. Төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд хяналт, шалгалт хийхгүй байх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн татгалзах эрхийг хүндэтгэнэ. Төрийн байгууллага, албан тушаалтанд хориглох үйл ажиллагааг тусгасан. Үүнд, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаас бусад зорилгоор төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлан гаргахыг хориглоно, хуульд заагаагүй төрийн хяналт, шалгалт хэрэгжүүлэх захиргааны шийдвэр гаргаж, дүрэм, журам батлахыг хориглоно, зарим аж ахуйн нэгжид давуу эрх олгосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлах, үйл ажиллагаа явуулах, эс үйлдэхүйг хориглоно, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулахыг хориглоно, өмч хөрөнгийг хууль бусаар хураан авах, дайчлахыг хориглоно, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараах, гутаан доромжлох, бие махбодод халдах, эд хөрөнгийг сүйтгэхийг хориглоно. Төр болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хооронд байнгын ажиллагаатай зөвлөлдөх тогтолцоог бий болгосон. Эдийн засгийн бодлогын зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд ахална. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална. Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувьд хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна. Зөвлөл нь үндсэн 3 чиг үүргийг заасан. Үүнд, төрийн бодлого, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахад ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодын саналыг хүлээн авах, холбогдох төрийн байгууллагад саналыг хүргүүлэх, санал хэрхэн тусгагдсан талаар эргэн мэдээлэх, хууль тогтоомжийн давхардал, хийдэл зөрчлийг арилгах чиглэлээр судалгаа хийх, төрийн байгууллагын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах талаар зөвлөмж гаргах, төрийн хүнд суртал, хууль бус үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын мэдээллийг нэгтгэн
--	--	--

			боловсруулж, шийдвэрлэх саналын хамт Засгийн газарт танилцуулах чиг үүрэгтэй ажиллана.
3	Гуравдугаар бүлэг. Бусад зүйл	9 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

№	Бүлэг	Зүйл	Тайлбар
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.13 дахь заалт 5 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын хэлбэр 5.1.6 дахь заалт	1/ "Хөрөнгө оруулагчийн гомдол" нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан. Тайлбар оруулсан. 2/ Хөрөнгө оруулалтын хэлбэрт дараах хэлбэрийг нэмж тусгасан. "5.1.6. үйлдвэр, машин, тоног төхөөрөмж, техник, технологи дамжуулалт, барилга байгууламж зэрэг үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулах".
2	Хоёрдугаар бүлэг. Хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгаа	6 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгаа 6.4, 6.6, 6.7, 6.12, 6.12, дахь хэсэг 7 дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг 7.1.8 дахь хэсэг	3/ Хөрөнгө хураан авах, түүний нөхөх олговрын талаарх хэсгүүдийг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөн найруулж, хэсэг нэмсэн. -6.3 дахь хэсэгт "... шууд болон шууд бус хэлбэрээр" хураан авахыг хориглох гэж нэмсэн. -6.4 дэх хэсгийг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөн найруулсан: "6.4. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, үл ялгаварлаж, хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээний нөхөх олговортойгоор хураан авч болно" -6.6, 6.7 дахь хэсэгт шинэ хэсэг нэмсэн. "6.6. Энэ хуулийн 6.5-д заасан нөхөх олговор нь бүрэн хөрвөх, чөлөөтэй шилжүүлж болохуйц байна." "6.7. Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин зэрэг нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлсэн зохицуулалтын арга хэмжээ, эсхүл хөрөнгө оруулалтын буруутай үйл ажиллагааны эсрэг авч буй хариу арга хэмжээг шууд бус хураан авалт гэж тооцохгүй." 6.12-т хэлэлцээ хийх журамд тусгах агуулгыг оруулсан. 4/ Хөрөнгө оруулагч, төрийн байгууллага хоорондын хөрөнгө оруулалтын харилцаанаас үүссэн маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, хэлэлцээ хийх журам, журамд тусгах агуулга хэсэг

			шинээр нэмсэн. 5/ 6 дугаар зүйлийн хэсгийн дугаарыг өөрчилсөн. 6/ Хуулийн “7.1.8.төрийн үйлчилгээг эрх тэгш хүлээн авах” хэсэгт нэмэлт оруулж, “төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тухай гомдол гаргах” эрхийг тусгасан.
3	Гуравдугаар бүлэг. Хөрөнгө оруулалтын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх	8¹ дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх 9¹дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 9²дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл	7/ Засгийн газрын бүрэн эрхийг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд тусгаагүй байдаг тул 8¹ дүгээр зүйл нэмсэн. Хуулийн төсөлд Засгийн газраас батлах журам болон хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын санал тавих, нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулахтай холбоотой хэсэг нэмсэн. 8/ Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тул 9¹ дүгээр зүйл нэмсэн. 9/ Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөлийн чиг үүргийг 9² дугаар зүйлээр нэмсэн. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсэгт заасан чиг үүргийг хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр тусгасан тул хүчингүй болсонд тооцсон.
4	Тавдугаар бүлэг. Хөрөнгө оруулалтын орчныг тогтворжуулах	18 дугаар зүйл. Тогтворжуулах гэрчилгээ олгох 18.5 дахь хэсэг	10/ Тогтворжуулах гэрчилгээ олгоход одоогийн хуулиар хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах орон тооны бус зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн өгдөг. Хуулийн төсөлд Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах гомдол шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд тогтворжуулах гэрчилгээ олгоход дүгнэлт гаргах ажлыг салбарын онцлогоос хамаарч тухай бүр ажлын хэсэг байгуулж шийдвэрлэхээр тусгасан. “18.5.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлаар холбогдох салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран ажлын хэсэг байгуулна.”
5	Зургаадугаар бүлэг. Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалт хийх	21 дүгээр зүйл. Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалт хийх 21.2, 21.3, дахь хэсэг	12/ Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд нийт хувьцааны 33 хувь түүнээс хувийг эзэмшиж буй хуулийн этгээд уул, уурхай, банк, санхүү, хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх бол зөвшөөрөл авна. Хуулийн төсөлд энэхүү зөвшөөрлийг авахдаа хөрөнгө оруулалтад хяналт /investment screening/ хийсний үндсэн

			дээр олгохоор тусгасан бөгөөд хяналт хийх журмыг Засгийн газар батална. Мөн хуулийн төсөлд Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд нийт хувьцааны 33 хувь түүнээс дээш хувийг шууд бусаар эзэмшиж буй тохиолдолд зөвшөөрөл авахаар тусгасан. Ингэснээр гадаадын төрийн өмчит компани охин компани байгуулах замаар шууд бусаар хуулийн этгээдийг эзэмших тохиолдолд зөвшөөрөл авах үндэслэл бий болно. “21.2.Энэ хуулийн 21.1-т заасан зөвшөөрлийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн хөрөнгө оруулалтад хяналт тавьсны үндсэн дээр олгоно. 21.3.Энэ хуулийн 21.1-д заасан зөвшөөрөл олгох эсэх талаар мэдээллийг зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдэд шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн хугацаанд мэдэгдэнэ.”
6	Долоодугаар бүлэг. Бусад зүйл	23 дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх	23 дугаар зүйл шинээр нэмж хөрөнгө оруулагчийн гомдлыг хянах ажиллагааг тусгасан.

Уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

№	Хууль	Зүйл	Тайлбар
1	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1 дүгээр зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “Монгол Улсын” гэснийг тус тус хассугай.	“Хүүхэд харагч” гэж эрх бүхий байгууллагаас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан Монгол Улсын иргэнийг ойлгоно гэсэн нэр томъёоны тодорхойлолтын Монгол Улсын гэснийг хассан. Мөн 6.4.-т “Хүүхэд харагч нь бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой, бага насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах, асрах, хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, зөв хооллох, бие бялдар, оюун ухааны хөгжлийг дэмжих хүүхэд харах үйлчилгээний тусгай сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, бага насны хүүхэдтэй харилцах арга зүй эзэмшсэн, халдварт болон сэтгэцийн өвчингүй, эрүүл, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, 18-аас 65 насны Монгол Улсын иргэн байна.” Гэж заасны Монгол Улсын гэснийг хассан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, аж ахуйн үйл ажиллагаанд төрөөс баримтлах зарчмыг тогтоох, төрийн оролцоог багасгаж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Монгол Улсын хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн актын хэм хэмжээ нь энэ хуулиар баталгаажуулсан эдийн засгийн эрх чөлөөг хангах хэм хэмжээг дордуулахыг хориглоно.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Иргэн, аж ахуйн нэгж Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийн дагуу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд баталгаатай эдлэх эдийн засгийн эрхийг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

3.2.Төрийн байгууллага, албан тушаалтнаас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны акт, хэм хэмжээ батлах, хэрэгжүүлэхэд энэ хуулийг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“эдийн засгийн эрх чөлөө” гэж иргэн, аж ахуйн нэгжийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой зөвхөн Үндсэн хууль, бусад хуульд заасан үндэслэлээр хязгаарлагдах эрх чөлөөг;

4.1.2.“аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч” гэж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, аж ахуйн нэгжийг;

4.1.3.“аж ахуйн нэгж” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.1-д заасныг;

5 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах зарчим

5.1.Төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хангахад дараах зарчмыг баримтална:

5.1.1.хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг хуулийн дагуу чөлөөтэй эрхлэх;

5.1.2.өмчийн халдашгүй байдлын зарчим;

5.1.3.аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн тэгш эрхийн зарчим;

5.1.4.шударга өрсөлдөөний зарчим;

5.1.5.оролцоог хангах зарчим: аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай, тогтвортой орчныг бий болгох зорилгоор төрийн бодлого, хууль, эрх зүйн шинэчлэлийг хийхдээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн саналыг сонсох, оролцоог хангана;

5.1.6.хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх зарчим.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого

6.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эдийн засгийн эрх чөлөөний баталгааг хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцохгүй, хохирол, саад учруулахгүй байхад чиглэнэ.

6.2.Төрийн бодлого, хууль тогтоомж, захиргааны шийдвэр нь тодорхой, хоёрдмол утгагүй, нийтэд ойлгомжтой байна.

6.3.Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, захиргааны шийдвэр гаргах тохиолдолд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч, мэргэжлийн холбоодод урьдчилан мэдэгдэх, оролцоог хангах, шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэлэлцүүлгийг нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

6.4.Төрийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем, албаны цахим шуудан, нийтийн мэдээллийн системийг ашиглан, эсхүл нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр шуурхай үзүүлнэ.

6.5.Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, зөвшөөрөл олгох ажиллагааг хялбарчлах, гомдол шийдвэрлэлтийн талаар олон нийтэд нээлттэй үйл ажиллагааг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

6.6.Төрийн хяналт, шалгалтыг биечлэн хийх шаардлагатайгаас бусад тохиолдолд цахим хэлбэрээр хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

6.7.Төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд хяналт, шалгалт хийхгүй байх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн татгалзах эрхийг хүндэтгэнэ.

6.8.Төрийн байгууллага хуулиар хязгаарлаж, хориглосноос бусад мэдээллийг зохих журмын дагуу нээлттэй өгөгдөл болгон олон нийтэд нээлттэй, үнэ төлбөргүй байршуулж, тогтмол шинэчилнэ.

6.9.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хүсэлт, гомдол, өргөдлийн хариуг хуульд заасан хугацаанд өгөх, шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг цахим хэлбэрээр харах боломжийг бүрдүүлнэ.

6.10.Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын гэрээнд орон нутагт эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар тусгаж, үр дүнг үнэлж дүгнэнэ.

7 дугаар зүйл.Төрийн байгууллага, албан тушаалтанд хориглох үйл ажиллагаа

7.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, шударга өрсөлдөөнийг дэмжих, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаас бусад тохиолдолд төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлан гаргахыг хориглоно.

7.2.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт, шалгалт хийх, хяналт шалгалтыг удаашруулахыг хориглоно.

7.3.Зарим аж ахуйн нэгжид давуу байдал бий болгосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлахыг хориглоно.

7.4.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулахыг хориглоно.

7.5.Хувийн өмчийг хууль бусаар шууд болон шууд бус хэлбэрээр хураан авахыг хориглоно. Зөвхөн нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, үл ялгаварлаж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу, нөхөх олговортойгоор хураан авч болно.

7.6.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг доромжлох, гүтгэх, бие махбодод халдах, эд хөрөнгийг сүйтгэх, нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараахыг хориглоно.

8 дугаар зүйл.Эдийн засгийн бодлогын зөвлөл

8.1.Төр болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хооронд байнгын ажиллагаатай зөвлөлдөх тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Эдийн засгийн бодлогын зөвлөл ажиллана.

8.2.Эдийн засгийн бодлогын зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд ахална.

8.3.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батлах ба Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувьд хараат бус хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

8.4.Зөвлөлийн ажиллах журам, хараат бус гишүүнд тавигдах шаардлага, нээлттэй сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.

8.5.Эдийн засгийн бодлогын зөвлөл дараах эрх, үүрэгтэй байна:

8.5.1.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахад ашиг сонирхол нь хөндөгдөх аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж болон мэргэжлийн холбоодын саналыг хүлээн авах, холбогдох төрийн байгууллагад саналыг хүргүүлэх, саналыг шийдвэрт тусгасан эсэх талаар эргэн мэдээлэх зэрэг шийдвэр гаргалтад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн оролцоог хангах;

8.5.2.аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай болон хууль тогтоомжийн давхардал, хийдэл зөрчлийг арилгах чиглэлээр судалгаа хийх, төрийн байгууллагын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах талаар зөвлөмж гаргах;

8.5.3.аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор төрийн хүнд суртал, хууль бус үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын мэдээллийг нэгтгэн боловсруулж Засгийн газарт танилцуулах;

8.5.4.энэ хуулийн 8.5.2-т заасан зөвлөмжийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллага эргэн мэдэгдээгүй тохиолдолд Улсын Их Хуралд тайлагнана.

8.6.Энэ хуулийн 8.5.2-т заасан зөвлөмжийн хэрэгжилтийг тухайн байгууллага Зөвлөлд эргэн мэдэгдэх үүрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

9 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/8' дүгээр зүйл:

8¹ дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх

8¹.1.Засгийн газар хөрөнгө оруулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8¹.1.1.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг хангах;

8¹.1.2.энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрх олгох;

8¹.1.3.хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах чиглэлээр шийдвэр гаргах.

8¹.1.4.хөрөнгө оруулагчдад Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төсөл хэрэгжүүлэх нээлттэй санал хүргүүлэх, төсөл хэрэгжүүлэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгох.

8¹.2.Засгийн газар хөрөнгө оруулалтын асуудлаар дараах журмыг баталж, мөрдүүлнэ:

8¹.2.1.энэ хуулийн 6.11-д заасан хэлэлцээ хийх журам;

8¹.2.2.энэ хуулийн 23.1-д заасан хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх журам;

8¹.2.3.Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам;

8¹.2.4.энэ хуулийн 8¹.1.4-т заасан төслийн санал хүргүүлэх, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах журам;

8¹.2.5.энэ хуулийн 21.2-т заасан хөрөнгө оруулалтад хяналт тавих журам."

2/9' дүгээр зүйл:

“9¹дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

9¹.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9¹.1.1.хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх, дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

9¹.1.2.хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, мэдээллээр хангах;

9¹.1.3.хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хөрөнгө оруулалт хийх, татах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, өргөтгөхөд мэдээлэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

9¹.1.4.хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх;

9¹.1.5.хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийг төв банк, төсөв, санхүү, хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, бүртгэл, гадаадын иргэн, харьяат, газар, чөлөөт бүс болон шүүхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас улирал, хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгдсэн статистик мэдээллийг гаргах, мэдээллийн санг хөтлөх;

9¹.1.6.хуульд заасан бусад.

9¹.2.Энэ хуулийн 9¹.1.5-д заасан мэдээллийн сан хөтлөх журмыг Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3/9² дугаар зүйл:

9²дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл

“9².1.Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9².1.1.хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг төрийн байгууллага, албан тушаалтан зөрчсөн эсэх талаарх гомдлыг хүлээн авч, хянах;

9².1.2.хөрөнгө оруулалтын орчинд тулгамдаж буй асуудал, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

9².1.3.хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тодорхойлох, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар санал, зөвлөмж гаргаж, Засгийн газар, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9².1.4.хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

9².1.5.энэ хуулийн 23.6-д заасан байгууллага хэрэгжилтийн талаар мэдэгдээгүй, эсхүл санал зөвлөмж биелүүлээгүй тохиолдолд энэ талаар Засгийн газарт танилцуулах.

9².1.6.хуульд заасан бусад.

9².2.Зөвлөл нь орон тооны бус 9 гишүүнтэй байх ба Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

9².3.Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.”

4/23 дугаар зүйл:

“23 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх

“23.1.Хөрөнгө оруулагч нь төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн талаарх гомдлыг Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлд гаргаж болно.

23.2.Зөвлөлийн ажлын алба нь энэ хуулийн 23.1-д заасан гомдлыг хянахдаа холбогдох төрийн байгууллагаас тайлбар, мэдээлэл авахаар гомдлыг хүргүүлнэ.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан төрийн байгууллага, албан тушаалтан ажлын 5 хоногт багтаан гомдолд дурдсан асуудлаар үндэслэл бүхий тайлбар, нотлох баримтыг Зөвлөлийн ажлын албанд хүргүүлнэ.

23.4.Зөвлөл хөрөнгө оруулагчийн гомдлыг хүлээн авснаас хойш энэ хуулийн 8¹.2.2-т заасан журмын дагуу хуанлийн 30 хоногийн дотор хянах ба шаардлагатай тохиолдолд 30 хоногоор сунгаж болно.

23.5.Гомдлыг хянан үзэхэд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаа тогтоогдвол Зөвлөл дээд шатны байгууллага, албан тушаалтанд шаардлагатай арга хэмжээ авах саналыг хүргүүлнэ.

23.6.Энэ хуулийн 23.5-т заасан дээд шатны байгууллага, албан тушаалтан Зөвлөлөөс ирүүлсэн саналын хэрэгжилтийн талаар эргэн мэдэгдэх, тайлагнах үүрэгтэй.

23.7.Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөлөөр гомдлыг шийдвэрлэх нь шүүх, арбитра нэхэмжлэл гаргах, хүсэлт гаргах эрхийг хязгаарлахгүй.”

5/6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 6.12 дахь хэсэг:

“6.6.Энэ хуулийн 6.5-д заасан нөхөх олговор нь бүрэн хөрвөх, чөлөөтэй шилжүүлж болохуйц байна.

6.7.Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин зэрэг нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлсэн зохицуулалтын арга хэмжээ, эсхүл хөрөнгө оруулагчийн буруутай үйл ажиллагааны эсрэг авч буй хариу арга хэмжээг шууд бус хураан авалт гэж тооцохгүй.

6.12.Энэ хуулийн 8¹.2.1-д заасан хэлэлцээ хийх журамд маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, хэлэлцээнд оролцох багийн бүрэлдэхүүн, хэлэлцээ хийх хугацаа болон шаардлагатай бусад асуудлыг тусгасан байна.”

6/18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг:

“18.5.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлаар дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулна.”

7/21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 дахь хэсэг:

“21.2.Энэ хуулийн 21.1-д заасан зөвшөөрлийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгох эсэхийг шийдвэрлэхдээ тухайн хөрөнгө оруулалтад хяналт тавина.

21.3.Энэ хуулийн 21.1-д заасан зөвшөөрөл олгох эсэх талаар мэдээллийг зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдэд шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн хугацаанд мэдэгдэнэ.”

8/3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалт:

“3.1.13.“хөрөнгө оруулагчийн гомдол” гэж хөрөнгө оруулагчаас Захиргааны ерөнхий хуулийн 5.1-д заасан төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзэж энэ хуулийн 9².1.-д заасан Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөлд гаргасан хүсэлтийг;

Тайлбар: “хөрөнгө оруулагчийн гомдол хянах ажиллагаа нь Захиргааны ерөнхий хуулийн 92-94 дүгээр зүйлд заасан урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагаанд хамаарахгүй.”

9/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалт:

“5.1.6.үйлдвэр, машин, тоног төхөөрөмж, техник, технологи дамжуулалт, барилга байгууламж зэрэг үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулах;”

2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “хууль бусаар” гэсний дараа “, шууд болон шууд бус хэлбэрээр” гэж, мөн зүйлийн 6.5 дахь хэсгийн “үнийн хамт” гэсний дараа “шуурхай” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “хүлээн авах” гэсний дараа “, энэ хуулийн 23.1-д заасан гомдол гаргах;” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “хувийг” гэсний дараа “шууд болон шууд бусаар” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“6.4.Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, үл ялгаварлаж, хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээний нөхөх олговортойгоор хураан авч болно.”

4 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийн “маргааныг” гэснийг “маргааныг талууд хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба хэлэлцээ үр дүнд хүрээгүй бол” гэж, 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн дугаарыг “6.8” гэж, 6.7 дахь хэсгийн дугаарыг “6.9” гэж, 6.8 дахь хэсгийн дугаарыг “6.10” гэж, 6.9 дэх хэсгийн дугаарыг “6.11” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “9.3-т заасан зөвлөлийн” гэснийг “18.5-д заасан ажлын хэсгийн” гэж, 23 дугаар зүйлийн дугаарыг “24” гэж, 24 дүгээр зүйлийн дугаарыг “25” гэж, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийн дугаарыг “24.1”, “24.2” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн дугаарыг “25.1” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын дугаарыг “5.1.7” гэж, 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн 6.7.1-6.7.5 дахь заалтын дугаарыг “6.9.1-6.9.5” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг, 9.2 дахь хэсгийн 9.2.4, 9.2.7, 9.2.8, 9.2.9 дэх заалт, 9.2.4.а, 9.2.4.б, 9.2.4.в, 9.2.4.г, 9.2.4.д, 9.2.4.е дэд заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “Монгол Улсын” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

АЖЛЫН ХЭСГИЙН НЭР

Эдийн засгийн эрх чөлөөний тухай
хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй
холбогдуулан боловсруулсан бусад
хуулийн төсөл

№	Нэр	Байгууллага	Албан тушаал	Утасны дугаар
1.	Ж.Энхбаяр	Эдийн засаг, хөгжлийн яам	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	-
2.	И.Батхүү	Эдийн засаг, хөгжлийн яам	Төрийн нарийн бичгийн дарга	99113569
3.	Б.Мөнх-Эрдэнэ	Эдийн засаг, хөгжлийн яам	Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга	88886495
4.	Л.Энх-Амгалан	Эдийн засаг, хөгжлийн яам	Макро эдийн засгийн бодлогын газрын дарга	80770972
5.	Б.Төгөлдөр	Эдийн засаг, хөгжлийн яам	Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга	94092818
6.	Э.Цацрал	Эдийн засаг, хөгжлийн яам	Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх	99081829
7.	Б.Ананд	Эдийн засаг, хөгжлийн яам	Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх	90101099
8.	С.Пүрэвсүрэн	Эдийн засаг, хөгжлийн яам	Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн	99087687

---oOo---



**ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2025 он

**ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ
СУДАЛГАА**

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	6
1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох	14
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох.....	14
1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл.....	15
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	20
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....	20
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ.....	24
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	31
ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	33
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ	37

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т “эдийн засгийн аюулгүй байдал”-ын хүрээнд олон тулгуурт, оновчтой бүтэц бүхий, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, эдийн засгийн бие даасан байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтлах”-аар заасан бөгөөд мөн үзэл баримтлалын 3.2.2-т “хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогын хүрээнд үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх”-ээр заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогод “...эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэсэн зорилгыг дэвшүүлж, “бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх” замаар 2030 он гэхэд хүрэх зорилтыг тавьсан байдаг.

Мөн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3-т эдийн засгийн бодлогыг “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ...” гэж тодорхойлсон. Мөн үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.2-д “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, мөн үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын эдийн засагт 1994 оноос хойш уул уурхайн салбарын эзлэх хувь тэлж, уул уурхайн бус салбар, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь агшжээ. Тухайлбал, уул уурхайн салбарын нийт ДНБ-д эзлэх жин өнгөрсөн 30 жилд 10 хувиас (1994 он) 27 хувь болж (2024 он) өссөн бол хөдөө аж ахуйн салбарын жин 27 хувиас 7 хувь болж буурчээ. Барилга, бүтээгдэхүүний цэвэр татвараас бусад үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь 1994 онд 35 хувийг эзэлдэг байсан бол 2024 онд 44 хувь болж өссөн байна.

Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагас жилд 5.6 хувьд хүрч, төсөөллийн орчимд байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байгаа ба уул уурхай, барилга, боловсруулах салбаруудын үйл ажиллагааны идэвхжил нэмэгдсэнээр эдийн засгийн нийт өсөлтөд үзүүлэх эерэг нөлөө нэмэгдлээ. Харин тээвэр болон худалдааны салбар агшилт хадгалагдлаа. Эрэлт талаас хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол барааны экспорт, төрийн хэрэглээ буурсан нь өсөлтийг саарууллаа. Ажиллах хүчний оролцооны түвшин 62 хувьд хүрч, нэрлэсэн орлого өссөн нь нийт өрхийн хэрэглээг

дэмжсэн ч үнийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн бодит орлогын өсөлт 5.8 хувьд хүрч саарсан байна.

Түүнчлэн “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” болон “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 149 хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төслүүд нь бүрэн хэрэгжсэнээр макро эдийн засгийн төрөлжүүлэх, төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөлөл үзүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой хэдий ч 22 төслийн нийт төсөвт өртөг 3.8 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай байна.

Дэлхийн өв уламжлалын сангаас 2025 онд хийсэн Эдийн засгийн индекс (The 2025 Index of Economic Freedom)-ийн судалгаагаар 176 улсын эдийн засгийн эрх чөлөөт байдлыг өмчийн эрх, шүүх засаглал, засгийн газрын зарчимт байдал, татварын дарамт, засгийн газрын зардал, санхүүгийн эрүүл мэнд, бизнесийн эрх чөлөө, мөнгөний эрх чөлөө, худалдааны эрх чөлөө, хөрөнгө оруулалтын эрх чөлөө, санхүүгийн эрх чөлөөг гэсэн 12 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн.

Уг судалгаагаар Сингапур Улс 84.1 оноогоор нэгдүгээр байр, Швейцар Улс 83.7 оноогоор хоёрдугаар байр, Тайван 79.7 оноогоор дөрөвдүгээр байрт тус тус эрэмбэлэгдсэн байна. Харин нийт улсын 50 орчим хувь нь эдийн засгийн эрх чөлөөний оноогоор хангалтгүй буюу 60-с доош үнэлгээ авсан байна. Судалгаагаар дэлхийн эдийн засаг маш эмзэг болсон тухай дүгнэлт гарсан бөгөөд үүнд, коронавируст цар тахлын эдийн засгийн буруу бодлогууд, өндөр инфляц, ОХУ-Украины дайн, Ойрх Дорнодын зөрчилдөөн, бусад орнуудын геополитик, эдийн засгийн хурцадмал байдал нөлөөлсөн гэж үзсэн.

Монгол Улс 62.6 оноогоор 74 дүгээр байранд эрэмбэлэгдсэн. Шалгуур үзүүлэлтүүдийг тоймлон үзвэл өмчийн эрх 92/176 “муу”, төрийн зарчимт байдал 117/176 “муу”, бизнесийн эрх чөлөө 79/176 “дунд”, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал 119/176 “бага” гэсэн үнэлгээ авсан.

Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой Дэлхийн банкны Doing Business-2020, MYXAYT-ын Монголын бизнесийн орчны үнэлгээ-2023, Economist Intelligence Unit, Дэлхийн эдийн засгийн форумын Өрсөлдөх чадварын индекс тайлангуудад дүн шинжилгээ хийхэд бизнес, худалдаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулж, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангасан нэгдсэн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, эдийн засагт нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг шийдвэрлэхийн тулд эдийн засгийг төрөлжүүлэх, бизнес, хөрөнгө оруулалтыг дэмжсэн таатай орчныг бүрдүүлэх нь чухал. Энэ хүрээнд аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгах, гарааны компаниудын бизнесийг дэмжих, экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр бодлого, зохицуулалтын арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Иймд хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулахад нь төрөөс эдийн засгийн баталгааг нь хангах, эрх ашгийг хамгаалах, төрийн оролцоог бууруулах нь чухал ач холбогдолтой тул Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, батлах хэрэгцээ шаардлага бий эсэхийг судлах шаардлагатай байна.

Судалгааны аргачлал

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлуудыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын¹ 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.Эдийн засгийн нөхцөл байдал

Монгол Улсын эдийн засагт 1994 оноос хойш уул уурхайн салбарын эзлэх хувь тэлж, уул уурхайн бус салбар, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь агшжээ. Тухайлбал, уул уурхайн салбарын нийт ДНБ-д эзлэх жин өнгөрсөн 30 жилд 10 хувиас (1994 он) 27 хувь болж (2024 он) өссөн бол хөдөө аж ахуйн салбарын жин 27 хувиас 7 хувь болж буурчээ. Барилга, бүтээгдэхүүний цэвэр татвараас бусад үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь 1994 онд 35 хувийг эзэлдэг байсан бол 2024 онд 44 хувь болж өссөн байна.

Хэдийгээр уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарууд нь ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр томоохонд орох боловч дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, байгалийн гамшиг, урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйлсээс өндөр хамааралтай тул, савлагаа өндөр. Үүнээс үүдэн манай улсын эдийн засгийн өсөлт өндөр савлагаатай байгаа тул илүү тогтвортой үйлдвэрлэл бүхий боловсруулах салбарт анхаарах нь зүйтэй байна.

Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагас жилд 5.6 хувьд хүрч, төсөөллийн орчимд байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байгаа ба уул уурхай, барилга, боловсруулах салбаруудын үйл ажиллагааны идэвхжил нэмэгдсэнээр эдийн засгийн нийт өсөлтөд үзүүлэх эерэг нөлөө нэмэгдлээ. Харин тээвэр болон худалдааны салбар агшилт хадгалагдлаа. Эрэлт талаас хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол барааны экспорт, төрийн хэрэглээ буурсан нь өсөлтийг саарууллаа. Ажиллах хүчний оролцооны түвшин 62 хувьд хүрч, нэрлэсэн орлого өссөн нь нийт өрхийн хэрэглээг дэмжсэн ч үнийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн бодит орлогын өсөлт 5.8 хувьд хүрч саарсан байна.

Инфляц 2025 оны 2 дугаар улиралд 8.2 хувьд хүрч, төв банкны зорилтоос өндөр түвшинд хадгалагдлаа. Эдийн засгийн дотоод идэвхжил суларч, эрэлтийн инфляцын дарамт буурахын зэрэгцээ нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт саарсан байна. Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалсан байна. Арилжааны банкнуудын зээлийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсээр байна. Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өссөн ч ашигт ажиллагаа тогтвортой хэвээр байлаа.

Монгол Улс 2025 оны эхний хагас жилийн байдлаар дэлхийн 145 улстай худалдаа хийж, худалдааны тэнцэл 1 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдий ч нийт бараа эргэлт 12.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Монгол Улсын экспорт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 6.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар буурсан

¹ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол. Нэгдүгээр хавсралт.

байна. Энэ бууралтад нүүрсний экспортын биет хэмжээ болон олон улсын зах зээл дээрх нүүрсний үнийн уналт голлон нөлөөлсөн.

2024 онд эдийн засгийн идэвхжил өндөр байж, өрхийн орлого, зээл олголт нэмэгдсэнээр иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирч импортын бараа, бүтээгдэхүүний урсгал өндөр байсан хэдий ч 2025 оны эхний хагас жилийн байдлаар импорт өмнөх оны мөн үеэс 150 сая ам.доллар буюу 2.8 хувиар өсөж, өсөлтийн хурд саарсан байна.

Гадаад талаас Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарч, худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал хумигдаж байгаа энэ үед дэлхийн улс төр, эдийн засгийн өрнөлд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна.

Дэлхийн тодорхой бус байдлын индексийн үзүүлэлтээр дэлхийн тодорхой бус байдал өнөөдөр цар тахлын дараах хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. Тодорхой бус байдал нэмэгдэхэд нэгд, АНУ-ын шинэ ерөнхийлөгчийн гаргаж байгаа шийдвэрүүд, хоёрт, БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, гуравт, Украинд болж байгаа дайн болон дөрөвт, Ойрх дорнодын нөхцөл байдал зэрэг геополитикийн хүчин зүйлс голлон нөлөөлж байна.

Худалдааны дайны цар хүрээ улам бүр өргөжиж байгаа нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх, бодлогын хүү удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Улмаар энэ нь манай улсын экспортын орлого буурах, инфляц өсөх, гадаад санхүүжилтийн өртөг, зардал нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна. Иймд урт хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Түүнчлэн мэдээллийн технологийн хурдацтай дэвшил, цахим шилжилтийн нөлөөгөөр дэлхийн эдийн засгийг өөрчилж, дижитал эдийн засгийг бий болгож, хиймэл оюун, их өгөгдөлд суурилсан контент, худалдааны нэгдсэн платформууд, өргөжиж, уламжлалт худалгааг өөрчилж байна. Монгол Улсын хувьд ЖДҮ, гарааны бизнесийг дэмжих замаар гадаад худалдааг нэмэгдүүлэх, өргөжүүлэх боломжтой.

ЖДҮ нь Монгол Улсад бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 77 хувь, нийт ажил эрхлэлтийн 72 хувийг эзэлж байгаа хэдий ч нийт экспортын дөнгөж 2.3 хувийг эзэлж байгаа нь дэлхийн зах зээлд интеграци хязгаарлагдмал байгааг харуулж байна. Монголын гарааны бизнесүүдийн хувьд финтек, хиймэл оюун ухаан, блокчэйн, боловсролын технологи, их өгөгдлийг анализ, цахим хядалдааны чиглэлээр ажиллах өндөр нөөц бололцоотой байдаг.

Гарааны бизнесүүдийн 75% нь орлого олж чаддаг бөгөөд орлого олж эхлэхэд дунджаар 1.8 жил, ашигтай ажиллахад 3.3 жил зарцуулдаг байна.² Гэсэн хэдий ч тэд авьяас чадвараа элсүүлэх, хөрөнгө босгох, үйлчлүүлэгчдийг олж авах, баг бүрдүүлэх, дэлхийн хэмжээнд өргөжин тэлэх зэрэгт хөрөнгө оруулалт, оруулалт бизнесийн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

² Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), Монголын гарааны бизнес эрхлэгчдийн экосистемийн судалгаа 2022

Гадаад, дотоод худалдаа эрхлэхтэй холбоотой төрийн зохицуулалтыг хялбарчилж, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хүрээнд хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчны шинэчлэлтийг хийж, хөрөнгө оруулалтыг хязгаарласан, хаасан зохицуулалтыг багасгаж, ялгамжтай байдлыг арилган, тэдгээрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах нь зүйтэй байна.

2. Олон улсын бизнес орны үнэлгээ

Дэлхийн өв уламжлалын сангаас “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг засаглалын үр ашиг, Засгийн газрын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээл гэсэн 4 бүлгийн хүрээнд 12 шалгуур үзүүлэлтээр тооцдог бөгөөд Монгол Улс 2024 онд нийт дүнгээрээ 176 улсаас 62.6 оноотойгоор 74 дүгээр байранд эрэмбэлэгдсэн байна. Шалгуур үзүүлэлтүүдийн оноо ангиллаар өмчийн эрх 92/176 муу, төрийн зарчимт байдал 117/176 муу, бизнесийн эрх чөлөө 79/176 дунд, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал 119/176 бага гэж үнэлэгдсэн байна. Эндээс харахад хувь хүмүүсийн өмч эзэмших эрх чөлөөг хангах, төрийн албаны авлига авах эрсдэлийг бууруулах, бизнесийн үр ашигтай үйл ажиллагааны хязгаарлалтыг бууруулах, хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Бүлэг	Шалгуур үзүүлэлт/дэд хүчин зүйлс	Оноо	Онооны ангилал	Байр
Засаглалын үр ашиг	Өмчийн эрх	48.8	муу	92/176
	Шүүхийн үр ашиг	34.8	бага	71/176
	Төрийн зарчимт байдал	55.0	муу	117/176
Засгийн газрын хэмжээ	Татварын дарамт	84.0	бүрэн	59/176
	Засгийн газрын зарлага	62.0	дунд	113/176
	Төсвийн сахилга бат	64.3	дунд	83/176
Зохицуулалтын үр ашигтай байдал	Бизнесийн эрх чөлөө	68.0	дунд	79/176
	Хөдөлмөрлөх эрх чөлөө	67.5	дунд	24/176
	Мөнгөний эрх чөлөө	67.9	дунд	117/176
Нээлттэй зах зээл	Худалдааны эрх чөлөө	74.4	сайн	72/176
	Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал	50	бага	119/176
	Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал	50	бага	96/176

Мөн Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-аас Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой Дэлхийн банкны Doing Business-2020, МҮХАҮТ-ын Монголын бизнесийн орчны үнэлгээ-2023, Economist Intelligence Unit, Дэлхийн эдийн засгийн форумын Өрсөлдөх чадварын индекс тайлангуудад дурдсан үнэлгээнд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх шаардлагатай нэгдсэн арга хэмжээнүүдийг тодорхойлсон байна.

1. Бизнес эхлүүлэх

- хуулийн этгээд байгуулах шат дамжлагыг цөөрүүлж, процессыг цахимжуулах;
- бүх төрлийн бизнесийн үйл ажиллагаанд БОНБУ хийлгэх үйлдвэр, үйлчилгээний төрлийг цөөлж, хүрээ, хязгаартыг тодорхой болгох, мэргэжлийн бус оролцогчдыг үнэлгээний үе шатнаас хасах (ИТХ, орон нутгийн удирдлагууд зэрэг);
- эрчим хүчинд анх холбогдох шат дамжлагыг цөөрүүлж, зарцуулах хугацааг багасгах;
- өмч бүртгүүлэхэд шаардагдаж буй үе шат, хугацааг багасгаж, зардлыг бууруулах;
- тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох;

2. Зах зээлийн боломж

- Монголбанкны алдагдлыг бууруулах, инфляцыг төв банкны зорилтот түвшинд хадгалах, инфляцын зорилтот түвшнийг үе шаттай бууруулах;
- зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, татварын хувь хэмжээг салбар харгалзан бууруулах, төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьчлалыг эрчимжүүлэх;
- зах зээл, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц арга хэмжээг хэрэгжүүлэхийн өмнө үе шаттайгаар зогсоох стратеги (exit strategy)-ийг гаргасны үндсэн дээр баталдаг болох, хүнс, хөдөө аж ахуйн салбарын үр ашиггүй татаас, дэмжлэгийн арга хэмжээнүүдийг зогсоох стратегийг тодорхойлох;
- үнэт цаасны зах зээл дэх төрийн оролцоог бууруулах;

3. Гадаад худалдаа

- бүрдүүлэх баримт бичигт хугацааг бууруулах;
- гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх;

4. Хөрөнгө оруулалт

- гадаадын хөрөнгө оруулагчдыг эрх тэгш авч үзэх;
- Хөрөнгө оруулалтын зохицуулалт, үр ашиг сул байдал, хүнд суртлыг бууруулах;
- тухайлсан салбарт хөрөнгө оруулах хязгаарлалт тогтоосныг арилгах;
- хөрөнгө дайчлан авах нөхцөл, хохирлыг барагдуулах харилцааг тодорхой зохицуулах;
- хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж, олон улсын жишигт нийцсэн нарийн зохицуулалтыг бий болгох (оролцогчдын эрх ашгийг хамгаалсан, ил тод, хариуцлагатай, тогтвортой);

5. Маргаан шийдвэрлэлт

- шүүхийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах;
- авлигын эрсдэлийг бүрдүүлж буй тогтолцооны гажуудлыг салбар бүрээр судлах;

6. Төлбөрийн чадваргүйдэл

- төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх хугацааг багасгах;

7. Хөдөлмөр

- хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрийг хангах.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 933 (эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар байршсан тоо) хуулиас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх (бизнес, хөрөнгө оруулалт, худалдаа г.м)-тэй шууд болон шууд бус холбоотой харилцааг зохицуулсан ойролцоогоор 368 хууль үйлчилж байна.

Түүнчлэн хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж, хориглосон, эсхүл гадаадын иргэн, хуулийн этгээдэд нэмэлт шаардлага тавьсан нийт 40 гаруй хууль байх бөгөөд эдгээрээс зүй ёсны буюу байх ёстой шаардлагыг тогтоосон хуулиудаас гадна гадаадын иргэн, хуулийн этгээдийг Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулах боломжийг хязгаарласан, хориглолт тогтоосон, ач холбогдолгүй нэмэлт шаардлагыг бий болгосон хэд хэдэн хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Эдгээр хууль нь тухайн салбарын харилцааг нарийвчлан зохицуулсан байх ба ингэхдээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарласан, хориглосон, нэмэлт шаардлага тавьсан, зайлшгүй шаардлагатайгаас бусад байдлаар зөвшөөрөл авахыг шаардсан зэрэг зохицуулалтууд нэлээдгүй байгаа нь бизнесийн орчинд сөргөөр нөлөөлж байна.

Бизнес хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангасан нэгдсэн зохицуулалт хийх шаардлагатай байна.

3. Хөрөнгө оруулалт, бизнесийн орчин

Монгол Улс 1992 онд ардчилсан тогтолцоонд шилжиж Үндсэн хуулиа шинэчлэн баталсантай холбоотойгоор эрх зүйт төрийн үндсийг хуульчилж, төрийн эрх мэдлийн хуваарилалт хийж, шүүхийн бие даасан байдлыг хуульчлахын сацуу, хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрх ашгийг хамгаалан, дэлхийн эдийн засгийн түгээмэл чиг хандлагад нийцүүлж эдийн засгаа удирдах, чөлөөт зах зээлийн зарчмыг нэвтрүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн чиг хандлагад нийцүүлж анхны хөрөнгө оруулалтын хуулийг 1993 онд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай нэртэйгээр баталснаар Монгол Улс гадаад зах зээлд нээлттэй бодлогыг баримталж, улмаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ тогтмол өсөлттэй явж, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлсэн юм.

Хөрөнгө оруулалтын хэмжээ уул уурхайгаас хамааралтай огцом өсөж байсан боловч 2012 оны олон улсын зах зээл дээрх гол түүхий эд бараа бүтээгдэхүүний үнэ

уналт зэрэг нь гадаад шууд хөрөнгө оруулалтын урсгал огцом буурахад нөлөөлсөн. Үүнтэй зэрэгцэн 2012 онд Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг баталсан. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хадгалах, татварын болон татварын бус дэмжлэгийг хөрөнгө оруулагч нарт үзүүлэх, дотоод хөрөнгө оруулагчдыг дэмжих зорилгоор 2013 онд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталсан.


Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт уул уурхайн салбарын эерэг хүлээлт, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтийг даган 2005-2010 онд жилд дунджаар 20-25 хувийн тогтмол өсөлттэй байсан ба 2011 онд 5.7 тэрбум ам.долларт хүрч, ДНБ-д гадаадын шууд хөрөнгө оруулалтын 55 хувийг эзэлж байсан байна.

Гэвч гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдал, дэлхийн зах зээл дэх түүхий эдийн эрэлт, үнийн уналтаас шалтгаалан хөрөнгө оруулалт буурч 2015 онд ДНБ-ий 12 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч багассан.

Мөн ГШХО-ын 57 хувийг хоёр улс (Нидерланд, БНХАУ) бүрдүүлж байгаа нь Монгол Улсыг эдгээр улсуудын эдийн засгийн төлөв байдлаас хэт хамааралтай болгож, салбарын үүднээс авч үзвэл ГШХО нь уул уурхайн салбарт хэт төвлөрлийг бий болгосон байна.

Мөн 1990 оноос хойш хийгдсэн ГШХО-ын 74 хувь уул уурхай буюу байгалийн нөөц баялаг эрэлхийлсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж байгаа байгаа бол зах зээл эрэлхийлсэн хөрөнгө оруулалт 10 орчим хувийг эзэлсэн байна.

График 1. ГШХО-ын орох урсгал



Мөн томоохон хөрөнгө оруулалтын төслийг дагаж дотоодын эдийн засаг идэвхжиж, бизнес орчинд эергээр нөлөөлдөг. ГШХО-ын өсөлт нь ДНБ-тэй шууд хамааралтай байдаг. /График 2/

График 2. ГШХО ба ДНБ-ий хамаарал





График 3. ГШХО-ын орох урсгалын өсөлт



Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 2013 оны шинэчлэлээс хойш даруй 10 гаруй жил болж байгаа хуулиар хөрөнгө оруулалт татах, хамгаалах зорилгодоо хүрсэн эсэх, хуулийн хэрэгжилтийн бүрэн хангагдахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын орчны талаар хийгдсэн судалгаануудын үр дүнгүүд харуулж байна.

ГШХО нэмэгдсэнээр эдийн засгийг төрөлжүүлж, үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад худалдааг өргөжүүлэх, дэвшилтэд техник технологи, нөү-хау нэвтэрснээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжирч, инновацыг дэмжих замаар Монгол Улсын өрсөлдөх чадвар дээшилнэ.

Нөгөө талаас бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулж эрхлэхэд улсын бүртгүүлэхэд бүрдүүлэх материал их, лавлагаа, тодорхойлолт авахад хүндрэлтэй, бүртгэл хийх хугацааг хэтрүүлэхээс эхлээд тусгай зөвшөөрөл авахад хуульд

зааснаас гадна нэмэлт материал шаардах, хэрэв уул уурхайн салбарт үйл ажиллагааг явуулсан тохиолдолд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой орон нутгийн захиргааны байгууллагуудын дүгнэлт, санал авах зэрэг олон хүндрэлтэй асуудлыг үүсгэдэг байна.

Цаашлаад үйл ажиллагааг явуулах үед хяналт шалгалтыг давхардуулан хийгдэг, удирдамжид заагаагүй асуудлаар хяналт хийх, дотоод үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хөрөнгө битүүмжлэх, үйл ажиллагаа зогсоосноор хохирол, алдагдал учрах зэрэг хүндрэл учирдаг байна.

ЭЗХЯ-аас хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчийн 120 гомдлыг хүлээн авч, гомдолд холбогдох асуудлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2022 оны 413 дугаар, 2023 оны 160 болон 413 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажилласан. Түүнчлэн бусад гомдлыг шийдвэрлэх хүрээнд тухайн асуудлыг хариуцсан төрийн болон орон нутгийн байгууллага, албан тушаалтанд гомдол шийдвэрлэж ажиллахыг даалгах, эрх бүхий байгууллагад тухай бүр уламжилж ажилласан боловч гомдлын шийдвэрлэлт 26 хувьтай байгаа нь Засгийн газраас хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Үүний үндсэн шалтгаан нь хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжүүд хүсэлтээ шийдвэрлүүлэхээр төрийн байгууллага, албан тушаалтанд хандах, гомдол гаргасан тохиолдолд тухайн гомдлыг хянан шийдвэрлэх, процессын ажиллагаа удаашралтай байгаа нийтлэг асуудлууд тулгамдаж байна. Тухайлбал, хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой мөрдөн шалгах, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процесс удаашралтай, хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлээгүй талаар гомдол гарсан байна. Эдгээр асуудлууд нь нэг талаас төрийн байгууллага, албан тушаалтны хүнд суртал гаргах, авлигын асуудлыг дагуулж байгаа бол нөгөө талаас тухайн байгууллагын ажлын ачаалал, нөөц боломж хязгаарлагдмал байдлаас шалтгаалж үүсэж байна.

Гомдолд хамаарах аж ахуйн нэгжүүдийн 35 хувь нь БНХАУ, 24 хувь Монгол, Улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгаа нь хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрийг ялгалтгүй бүх төрлийн эдийн засгийн үйл ажиллагаанд хүндрэл, бэрхшээл учирч байгаа нь харагдаж байна.

График 4. Хөрөнгө оруулагчийн гомдол, улсаар



Дээр дурдсан хүндрэлтэй, тулгамдсан асуудлуудаас харахад хөрөнгө оруулагчдын төрийн захиргааны байгууллагуудаас аж ахуйн нэгжтэй харилцахад хүнд суртал чирэгдэлгүй төрийн үйлчилгээг авах, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт хийх үе шатыг хялбарчлах шаардлагатай байгааг харуулж байна.

1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

Дээр дурдсан нөхцөл байдлыг дүгнэж үзвэл дараах үндсэн асуудал тулгамдаж байна. Үүнд:

1. Хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, өмчийн халдашгүй байдлыг хангаж, аж ахуйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, гадаад, дотоодын зах зээлд чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх нэгдсэн зохицуулалтын орчин бүрдээгүй байна.
2. Бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, гомдол, маргаанаа шуурхай шийдвэрлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, эрх үүргийг нарийвчлан тогтоогоогүй, хуулийн хэрэгжилтийг хангуулах механизм тодорхойгүй байна.

Иймд эдийн засгийн харилцаанд оролцож буй бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид үйл ажиллагаа явуулахад төрөөс баримтлах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх нөхцөлийг тодорхойлж, бизнесийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эдийн засгийн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан “Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуулийн төсөл боловсруулах” гэж тодорхойлов.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох³

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1. Хөрөнгө оруулагч, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн /Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй	Бизнес, хөрөнгө оруулалтын орчин тодорхой бус, урьдчилан таамаглагдах боломжтой байх зарчим хангагдаагүй, хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгаагаар хангуулах, эрх ашиг эрх ашиг нь зөрчигдсөн тохиолдолд хамгаалах механизм байхгүй, гомдол

³ Аргачлалын 3.1.2-т “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор заасан байдаг. Энэхүү судалгааны хүрээнд хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг эрх ашиг нь хөндөгдөх бүлгээр тодорхойлсон тул дээрх бүгд хамаарна.

	хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/	маргаанаа шийдвэрлүүлэх зохицуулалт хуульд тодорхой тусгагдаагүй зэргээс шалтгаалж цаг хугацаа, хөрөнгө мөнгөний хувьд хохирох тохиолдол бий болдог.
2.	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай Монгол Улсын хуулийн этгээд	Үйл ажиллагаа явуулахад улсын бүртгэлд бүртгүүлэх, зөвшөөрөл авах процесс хүндрэлтэй, зарим салбарын хууль тогтоомжоор үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарласан, төрийн байгууллага, албан тушаалтнаас үзүүлж буй үйл ажиллагаа нь хууль тогтоомжоор олгогдсон эрх үүргийг хэтрүүлсэн, шийдвэрлэлт удаан байдгаас эрх ашиг нь зөрчигддөг.

Эрх ашиг нь хөндөгдөж, нөлөөлөл үзүүлэх бүлгийн хувьд эдийн засгийн харилцаанд оролцогч нь Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн, гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүгд хамаарахаар байна.

Учир нь Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэх ажиллагаанаас эрх ашиг нь хөндөгдөх бүлгийн эрх зүйн байдал, эрх ашиг шууд хамаардаг.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

1. Хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх

Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд хөрөнгө оруулалт татах, шинээр бизнесийн үйл ажиллагааг явуулах, бүртгэл, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаа боловсронгуй бус байгаа нь хөрөнгө оруулагчдыг татахад хүндрэл учруулж, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна" гэх төрийн үндсэн үүргийг хангалттай түвшинд хэрэгжүүлэх боломжийг хааж байна.

Хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж буй бас нэг томоохон хүчин зүйл нь төрийн шийдвэр гаргалттай холбоотой үйл явц юм. Монгол Улс хуулийн хэрэгжилтийг хангах, асуудлыг шийдвэрлэх талаарх болон эрх ашиг нь хөндөгдөх этгээдэд сонсох ажиллагааг хангалттай хийдгүйгээс хөрөнгө оруулагч нарт асар их зардал чирэгдэл учирч байна. Иймээс хөрөнгө оруулагч нарын зүгээс аливаа эрх ашигт нь хамаарах бодлогын шийдвэрийн талаар мэдэх эрхийг хангах, саналаа өгөх боломжийг бүрдүүлдэг байх нь чухал юм. Хэдийгээр Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд энэ талаар тусгасан ч хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх хязгаарлалтын заалтууд холбогдох хуулиудад байна.

Түүнчлэн хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль ёсоор албадан хураан авахтай холбоотой нэгдсэн зарчмыг тодорхойлоогүй нь төрийн байгууллагаас гаргах шийдвэр нь дураар аашлах нөхцөл байдлыг бий болгох эрсдэлтэй бөгөөд хуулийг дураар тайлбарлах ч эрсдэл үүсгэж байна. Иймээс хөрөнгийг хураан авах

зохицуулалтын үр дүнд хөрөнгө оруулагчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох нөхцөлийг хуульчлах нь зүйтэй байна.

Мөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан зарим зохицуулалтуудыг арилгаж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх нэгдсэн зохицуулалт шаардлагатай байна.

Иймд хөрөнгө оруулалтын нээлттэй бодлого баримталж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах, Засгийн газраас хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг бодит үр дүнд хүргэх шаардлагатайг харуулж байна.

2. Хөрөнгө оруулагчийн гомдол, маргаан шийдвэрлэх тогтолцоо

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд шинээр хөрөнгө оруулалт татахаас гадна, нэгэнт хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, үүссэн асуудлыг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой. Олон улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын 50 орчим хувийг дахин хөрөнгө оруулалтын орлого бүрдүүлдэг байна.

Манай улсын хувьд зарим төрийн болон нутгийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд, албан тушаалтнуудын хариуцлагагүй үйлдэл, эс үйлдлээс үүдэн Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэхгүй байх, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах, цаашлаад манай улсын хөгжлийн зорилтод чухал хувь нэмрээ оруулдаг гадаад түнш орнуудтай харилцах харилцаанд ноцтой үр дагавар учруулах болзошгүй тохиолдлууд гарах эрсдэлийг бий болгодог.

Одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхээр орон тооны бус зөвлөлтэй байхаар тусгасан боловч гомдлын төрөл, гомдлыг шийдвэрлэх процесс тодорхойгүй байснаар хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг. Түүнчлэн төрийн байгууллага, албан хаагчийн хууль бус үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгө оруулагчийн эрх ашиг хохирох тохиолдолд төрийн албан хаагчийн буруутай үйлдэлд хариуцлага тооцох шаардлагатай байна.

Монгол Улсад хөрөнгө оруулалтын асуудлаар үүссэн 6 арбитрын маргаан байгаа бөгөөд хамгийн сүүлд Америкийн Нэгдсэн Улсад бүртгэлтэй “Даблю Эм Майнинг” (WMM) компанийн нэхэмжлэлээр 2021 оны хоёрдугаар сарын 12-ны өдөр Дэлхийн банкны дэргэдэх Хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх олон улсын төвд хөрөнгө оруулалтын маргаан үүссэн. Тус маргаанд Монгол Улсын Засгийн газар ялалт байгуулсан хэдий ч цаашид ийм төрлийн маргаан үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

№	Эхэлсэн, шийдвэрлэсэн хугацаа	Маргаан	Хамаарах хууль	Шийдвэрлэсэн байдал	Салбар
---	-------------------------------	---------	----------------	---------------------	--------

1.	2004 он	Алстом /Итали/	Эрчим хүчний харти, ХОХДХХТХ /BIT/	Эвлэрсэн	Эрчим хүч
2.	2007-2011 он	Сергей Паушок /ОХУ/	ХОХДХХТХ /BIT/	Монгол Улсын талд шийдвэр гарсан	Уул уурхай
3.	2010-2017 он	Чайна Хэйлонгжин /БНХАУ/	ХОХДХХТХ /BIT/	Монгол Улсын талд шийдвэр гарсан	Уул уурхай
4.	2011-2015 он	Хан ресурс /Канад, Нидерланд, Виржиний арлууд/	Олон Улсын эрчим хүчний харти	Хөрөнгө оруулагчийн талд шийдсэн /80 сая ам.дол/	Уул уурхай
5.	2018 он	Mohammed Munshi Gobi Coal & Energy Ltd	Олон Улсын эрчим хүчний харти	Хүлээгдэж байгаа	Уул уурхай
6.	2021-2023 он	WM Mining v. Mongolia /Их тохойрол ХХК/	ХОХДХХТХ /BIT/	Монгол Улсын талд шийдвэр гарсан	Уул уурхай

Эх сурвалж: Investmentpolicy.unctad.org

Түүнчлэн хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаа явуулах үе шатад тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргаан шийдвэрлүүлэх тогтолцоог бүрэн хангагдаагүй байгаа нь хөрөнгө оруулагчдын Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхол, итгэл үнэмшлийг бууруулж байна.

Иймд гадаад, дотоодын хөрөнгө оруулагч хоорондын хөрөнгө оруулалтын нөхцөлд ялгамжгүй, эрх тэгш байх зарчмыг хангах, гомдол, маргаан шийдвэрлэх тогтолцоог бий болгож, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай.

3. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

Шинэ тутам гарч ирж буй зах зээлийг хэрхэн ашиглаж, хөрөнгө оруулалт татах боломж болгон хувиргах, шинээр Монголыг зорьж буй хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэгийг салбар бүрд тодорхой болгох, өртөг нь нэмэгдэж буй нүүрсний төслүүдийн санхүүжилтээс ногоон зах зээл рүү шилжих гэх мэтчилэн анхаарах олон нөхцөлүүд үүсэн буйг анхаарах шаардлага тулгарч байна.

Хөрөнгө оруулалт татахад бодлого, эрх зүйн орчноо хөрөнгө оруулагчдад сурталчлан таниулах, зорилтот улс, бус нутаг, эдийн засгийн салбар, тэргүүлэх чиглэлээр нь хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, арга хэмжээг санал болгох, сурталчлах, хөрөнгө оруулалт татах бизнес уулзалт, форум, арга хэмжээг зохион байгуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах, цаашлаад хөрөнгө оруулагчид Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нь шаардлагатай төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, мэдээллээр хангах, хууль тогтоомжид заасан дэмжлэг, урамшууллыг бодитоор үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улс орон бүрийг онилсон хөрөнгө оруулалтын тухайлсан стратеги боловсруулж, хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг нэгдсэн байдлаар хүргэж, дэмжиж ажиллах хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг үр дүнтэй ажиллуулах шаардлагатай байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа Хөгжлийн Бага хурал, Дэлхийн банкнаас гаргасан зөвлөмжид хөрөнгө оруулагчид хууль тогтоомжийн ил тод байдал, хууль тогтоомжийн гэнэтийн өөрчлөлт, зохицуулалт хийхгүй байх, дарамт багатай, зөрчил багатай хууль эрх зүйн орчныг шаарддаг гэж тусгасан байдаг.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлогын шинэчлэлийн талаар Олон улсын байгууллагууд, Олон Улсын Санхүүгийн Корпорацаас “Монгол Улсын Хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн зураглал”, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департамент, Монгол дахь Америкийн Худалдааны Танхимаас хөрөнгө оруулалтын чиглэлийн зөвлөмжүүдийг Засгийн газарт хүргүүлсэн байдаг.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд институтийн өөрчлөлттэй холбоотой оруулсан удаа дараагийн нэмэлт, өөрчлөлтөөс харахад хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангахад сөрөг үр дагавар үүсгэсэн байна.

Анх Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг нь 1996 онд гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг хариуцах чиг үүрэгтэйгээр байгуулагдсан. Тус агентлаг нь эхэн үедээ (i) хөрөнгө оруулалтыг дэмжих болон (ii) бүртгэл, зөвлөх үйлчилгээ гэсэн үндсэн хоёр газартай байсан ба үйл ажиллагааны 50 хувь нь бүртгэл, зөвлөх үйлчилгээнд чиглэгдэж байв.

Тухайн үед Монгол Улсад ГШХО татах үйл явц нь харьцангуй шинэ үйл ажиллагаа байсан тул нэг талаасаа нээлттэй буюу бүх салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа явуулж байсны зэрэгцээ тодорхой тэргүүлэх салбар, чиглэлүүдэд хөрөнгө оруулалтыг дэмжих, татах, эдийн засгийг төрөлжүүлэх үүднээс Засгийн газраас хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэгүүдийг үзүүлдэг байсан. Гэвч хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн тодорхой бодлого, стратеги чиглэлгүй байсны зэрэгцээ ГШХО-ыг татсанаар эдийн засгийн хөгжил, ажлын байр нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй талаар нэгдсэн, ойлголт байхгүй байв.

Өнгөрсөн хугацаанд хөрөнгө оруулалтын бодлого, дэмжлэгийн асуудал хариуцсан байгууллагын бүтэц, зохион байгуулалт дараах байдлаар өөрчлөгдөн ажилласан байна. Үүнд;

- 1996-2012 онд гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын чиг үүрэг бүхий Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг нь бие даасан агентлаг хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан.
- 2012-2013 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт, худалдааны чиг үүргийг салгаж, хөрөнгө оруулалтын асуудлыг Эдийн засгийн хөгжлийн яам (хуучин нэрээр)-ны харьяа Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газарт шилжүүлэн ажилласан.
- 2013-2016 онд Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулалтыг дэмжих “Инвест Монголиа” агентлаг нь

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдан ажилласан.

- 2016-2021 онд Үндэсний хөгжлийн газрын Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтэс ажилласан.
- 2022 оноос ЭЗХЯ-ны Хөрөнгө оруулалтын бодлогын газар тус чиг үүргийг хариуцан ажиллаж байсан.
- 2023 онд Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг нь Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхэлж асуудлын хүрээнд шинэчлэн байгуулсан.
- 2024 оноос Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг нь Шадар сайдын /гадаадын хөрөнгө оруулалт/ эрхлэх асуудал хамаарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 37 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулагдсан боловч, тус агентлагийн үндсэн чиг үүргийн талаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгаж өгөөгүй хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу ЭЗХЯ-ны чиг үүргийг тодорхойлсон.

Түүнчлэн УИХ-ын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны нэгдсэн чуулганаар баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэлийн асуудлыг хамааруулж, энэ хүрээнд Хөрөнгө оруулалт, худалдааны газар хөрөнгө оруулалтын орчин, хууль, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийг нэг цонхоор хүргэх, хөрөнгө оруулалт татах төслүүдийг бэлтгэх, бэхжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь бодлого болон хэрэгжилтийн уялдааг алдуулж байна.

Иймд тус байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг Хөрөнгө оруулалтын тухай хуульд бусад байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй давхардуулалгүйгээр нарийвчлан тусгаж өгөх шаардлага байна.

Тухайлбал, “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” болон “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 149 хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төслүүд нь бүрэн хэрэгжсэнээр макро эдийн засгийн төрөлжүүлэх, төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөлөл үзүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой хэдий ч 22 төслийн нийт төсөвт өртөг 3.8 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай байна.

Иймд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, мэдээллээр хангах, хөрөнгө оруулалтыг төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх нөхцөл талаар хуульд тодорхой зааж оруулах шаардлагатай байна.

Дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан дараах арга хэмжээг хэрэгжүүлэхэд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг дагалдаж, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шалтгаан нөхцөл үүсэж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Шийдвэрлэх зорилгын тухайд өмнөх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрлэх зорилгыг тодорхойлж байна.

Зорилго: “Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эдийн засгийн үйл ажиллагааг тогтвортой явуулах баталгааг хангах, бизнесийн үйл ажиллагааг саадгүй эхлүүлэх, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг, сонирхлыг хамгаалах үр дүнтэй механизмыг бий болгох”.

Дээрх зорилгын хүрээнд Монгол Улсад эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зөвшөөрөл авахад тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг арилгах, хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах бодитой механизмыг бий болгох замаар шийдвэрлэх боломжтой, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулах хууль, эрх зүйн шаардлага бий эсэх гэсэн зорилтуудыг томъёолсон болно.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЗЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбаруудын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, зерэг болон сөрөг талыг харьцуулан хүснэгт 2-т харуулав.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
“тэг” хувилбар	Хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулж буй хуулийн хэрэгжилт хангалтгүй өнөөгийн тулгамдаж буй байдал хэвээр үргэлжлэх тул зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;	Тус хувилбарыг хэрэгжүүлснээр асуудлууд шийдвэрлэгдэхгүй хэвээр үргэлжлэх тул зорилгод хүрэх боломжгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Одоо зах зээлийн механизм нь хүндрэл, бэрхшээл дагуулж байгаа тул зорилгод хүрэх боломжгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
төрөөс санхүүгийн интервенц хийх	Одоо тулгамдаж буй асуудлуудыг төрөөс шууд мөнгөн хэлбэрийн санхүүжилт үзүүлэх замаар шийдвэрлэхэд тохиромжгүй тул тус хувилбар зорилгод хүрч чадахгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.

төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаа нь эдийн засгийн өргөн цар хүрээ, олон салбарыг хамардаг бөгөөд нэгдсэн бодлогын дагуу төрийн холбогдох байгууллагууд хувийн хэвшилтэй харилцан уялдаатай хамтран ажиллах шаардлагатай бөгөөд уг харилцааг нарийвчлан зохицуулж тодорхой болголгүйгээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлснээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
захиргааны шийдвэр гаргах	Хуулиар зохицуулагдаагүй зарим харилцааг тус хувилбарын дагуу захиргааны шийдвэр гарган хэрэгжүүлэх боломжгүй байна. Тус хувилбар нь асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна.	Асуудлыг үүсгэж байгаа зарим шалтгааныг арилгах боломжтой ба тулгарч буй бэрхшээлийг бүрэн шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тулгамдаж буй асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх тул тус хувилбар нь зорилгодоо хүрэх бүрэн боломжтой байна.	Зардал гарахгүй бөгөөд одоо үүсээд байгаа тулгамдсан асуудлуудын шалтгаан, сөрөг үр дагавар арилна. Төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой болно.	Үр дүн эерэг байна.

Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх замаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй.

Дээрхээс дүгнэвэл асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн “Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эдийн засгийн үйл ажиллагааг тогтвортой явуулах баталгааг хангах, бизнесийн үйл ажиллагааг саадгүй эхлүүлэх, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг, сонирхлыг хамгаалах үр дүнтэй механизмыг бий болгох” гэсэн зорилтод хүрэхийн тулд одоо байгаа тогтолцооны хүрээнд хуулийн төслийг боловсруулж, батлах нь зүйтэй гэж үзлээ.

Үүнээс гадна захиргааны шийдвэр гаргах ажиллагаа нь зарим нэг зорилтыг хангах боломжтой боловч тулгамдаж буй асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй бөгөөд үр дүн муутай болох нь харагдаж байна.

Иймд “Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эдийн засгийн үйл ажиллагааг тогтвортой явуулах баталгааг хангах, бизнесийн үйл ажиллагааг саадгүй эхлүүлэх, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг, сонирхлыг хамгаалах үр дүнтэй механизмыг бий болгох” зорилгын хүрээнд дараах хувилбаруудыг дэвшүүлж байна.

Хувилбар 1. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах.

Хувилбар 2. Хөрөнгө оруулалт, бизнесийн харилцаанд тулгамдаж буй асуудлыг захиргааны шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар зохицуулах.

Дээрх зорилгын хүрээнд Монгол Улсад хөрөнгө оруулах, бизнес эрхлэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг арилгах, хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах бодитой механизмыг бий болгох замаар шийдвэрлэх боломжтой, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулах хууль, эрх зүйн шаардлага бий эсэх гэсэн зорилтуудыг томъёолсон болно.

Нэгдүгээр хувилбарын хувьд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Монгол Улсад эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг арилгах, хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах бодитой механизмыг бий болгох боломжийг олгоно.

Хоёрдугаар хувилбар нь захиргааны шийдвэр буюу захиргааны акт захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар дээр дурдсан асуудлаас зарим асуудлыг шийдвэрлэх боломж олгохоор байна.

Дээрх хоёр хувилбар нь судалгаагаар дэвшүүлсэн зорилгод тодорхой хэмжээгээр хүрэх боломжтой гэж үзэж тус хоёр хувилбарын үр нөлөөг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаагаар харьцуулан авч үзье.

Хувилбар 1. Томьёолол

“Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Монгол Улсад эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг арилгах, хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах бодитой механизмыг бий болгох”

Зорилгод хүрэх байдал:

Асуудлыг шийдвэрлэх зорилт нь хөрөнгө оруулалт, бизнесийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилт хангалгүй, зарим зохицуулалт нь практикт хэрэгжих боломжгүй, тодорхойгүй байдал үүсгэж байгаа тул үүнээс үүдэн хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн эрх ашиг зөрчигдөж, Монгол Улсад хөрөнгө

оруулах сонирхол багасах, бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл байдлыг Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар арилгах явдал юм.

Хувилбар 1-ийн хувьд хуулийг боловсруулж, батлах замаар зорилгод бүрэн хүрэх боломжтой хувилбар гэж үзэж байна. Учир нь тулгарч буй асуудлыг зохицуулах нь дараах ач холбогдолтой байна.

1. Төрийн зүгээс иргэн, хуулийн этгээдийн эрхлэх аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой харилцаанд оролцохдоо баримтлах нийтлэг зарчмуудыг тодорхой тусгасан бөгөөд тэдгээр зарчмыг төрийн бүх шатны байгууллагууд болон хувь хүн, байгууллага (зохих хэмжээнд) дагаж мөрдөх үүргийг хүлээхээр зохицуулна..

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль баталж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэх, бизнес эрхлэгч чөлөөтэй саадгүй үйл ажиллагаа явуулах боломжоор хангагдах, төрийн үйлчилгээг шуурхай хүртээмжтэй байдлаар авч, улмаар эдийн засгийг сэргээх, тэлэх ач холбогдолтой байна. Харин зардлын хувьд хөрөнгө оруулалтын оролцож буй төрийн байгууллагуудад шинээр нэгж үүсэх, орон тоо нэмэх шаардлага үүсэхгүй тул улсын төсвөөс нэмэлт зардал гарахааргүй байна.

Иймд хуулийн төсөл батлагдсан гарснаар Монгол Улсын эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэх ба нэмэлт зардал гарахааргүй байгаа тул зардал, үр өгөөжийн харьцааны хувьд Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь илүү өгөөжтэй байна.

Хувилбар 2. Томьёолол

“Хөрөнгө оруулалт, бизнесийн харилцаанд тулгамдаж буй асуудлыг захиргааны шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар зохицуулах.”

Зорилгод хүрэх байдал:

Энэхүү хувилбарын хувьд өмнөх хувилбартай харьцуулбал захиргааны шийдвэр буюу захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар тулгарч буй зарим саад бэрхшээлийг зохицуулах гэдгээрээ ялгаатай байна.

Захиргааны акт гэдэг нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгодог. Захиргааны актаар хөрөнгө оруулагчдад тулгарч буй тодорхой нэг тохиолдлыг буюу явцуу хүрээнд шийдвэрлэх боломжтой.

Харин захиргааны хэм хэмжээний тухайд заавал нийтээр дагаж мөрдөгддөг хэм хэмжээ байх хэдий ч хуулиар эрх олгогдсон хүрээнд л тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжтой. Бидэнд тулгарч буй асуудлын хүрээнд хууль эрх зүйн

тодорхой бус бөгөөд зорилгодоо хүрч чадаагүй, зарим зохицуулалт тусгагдаагүй зэрэг нөхцөл байдал хамаарч байгаа болно.

Иймд захиргааны шийдвэр буюу захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй үлдэх сул талтай байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Зардлын хувьд өмнөх хувилбартай адил хэдий ч өмнө дурдсанаар үр, өгөөж муутай байна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь бага зардлаар өндөр үр дүнд хүрэхээр байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг Аргачлалын дагуу тандан судлалаа.

1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхтэй холбоотой болон хүнийг эрхийг зөрчих магадлалтай зохицуулалт байхгүй болно.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг хангах нөхцөлийг нэмэгдүүлэхэд дэмжсэн зохицуулалт хийнэ.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг

				хангах нөхцөлийг нэмэгдүүлэхэд дэмжсэн зохицуулалт хийнэ.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг хангах нөхцөлийг нэмэгдүүлэхэд дэмжсэн зохицуулалт хийнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт хийгдэхгүй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт хийгдэхгүй.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт хийгдэхгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт хийгдэхгүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх зүйн зохицуулалт нь холбогдох бүлэг, эрх агуулагчдад эрх тэгш үйлчлэх тул тусгайлсан зохицуулалт шаардлагагүй.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Тусгайлсан зохицуулалт шаардлагагүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Тусгайлсан зохицуулалт шаардлагагүй.

4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ялгаатай тусгах зохицуулалт байхгүй.
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Ялгаатай тусгах зохицуулалт байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	

2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хүндрэл бэрхшээлийг бууруулна.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй, зардал буурна.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.

4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй. Одоо байгаа зохицуулалтыг сайжруулж, тодорхой болгож, зардлыг бууруулна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Өмчлөх эрхийг баталгаажуулна.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалт, бизнесийн орчин сайжирснаар тус асуудлыг дэмжихэд шууд бусаар эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах нөхцөл бүрдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд эерэг нөлөөлөл үзүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт эергээр нөлөөлнө.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Одоогийн тогтолцоо сайжирна.

	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тус асуудалд эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулагчдын татах нөхцөл бүрдэнэ.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй. Олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжид нийцсэн.

3. Нийгэмд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Бизнесийн орчин сайжирч ажлын байр нэмэгдэх боломжтой.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.

	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгож өгснөөр үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, хамтран ажиллах нөхцөлийг нэмэгдүүлнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулахад эергээр нөлөөлнө.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулахад эергээр нөлөөлнө.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.

	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.

4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	

6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Хувилбар 1. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах.

Хувилбар 2. Хөрөнгө оруулалт, бизнесийн харилцаанд тулгамдаж буй асуудлыг захиргааны шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар зохицуулах.

	Зохицуулалтын хувилбарууд	Хувилбар 1. “Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах.”	Хувилбар 2. “Хөрөнгө оруулалт, бизнесийн харилцаанд тулгамдаж буй асуудлыг захиргааны шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар зохицуулах..”
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрэх байдал	Тус хувилбарын хувьд: - Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан төрийн үүрэгтэй холбоотой; - Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчийн эрх ашгийг хангах, хамгаалах, ГШХО	Тус хувилбарын хувьд захиргааны хэм хэмжээний акт буюу захиргааны шийдвэрээр тус хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэсэн асуудлыг цогцоор шийдвэрлэх боломжгүй тул уг зорилгод бүрэн нийцэхгүй байна.

		нэмэгдэхтэй холбоотой зохицуулалтууд баталгаажна.	
Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө		Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчийн эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ. Гэхдээ хувилбар 2-оос тухайн хувилбар нь илүү эерэг үр нөлөөг үзүүлж байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын орчныг боловсронгуй болгоход чиглэсэн зарчмын өөрчлөлтүүдийг тусгаснаар төсөлд тусгаснаар захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар шийдвэрлэх боломжгүй асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.	Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчийн эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.
Зардал, үр өгөөжийн харьцаа		Хуулийн төслийг баталснаар төрийн байгууллагуудад шинээр зардал үүсгэхгүй ба үр өгөөжийн харьцааны хувьд үр өгөөж нь илүү байхаар байна.	Зардлын хувьд өмнөх хувилбартай ижил үр дагавартай хэдий ч өмнө дурдсанаар үр, өгөөж муутай байна.
Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх		Хууль тогтоомжтой бүрэн нийцэж байна.	Тус хувилбарыг сонгосон тохиолдолд хууль тогтоомжтой нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах боломжтой.
Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох		Хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, хуулийн этгээд.	Хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, хуулийн этгээд.

Дээрх судалгаанд үндэслэн тухайн хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дүн

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд хувилбар 1 нь хувилбар 2-оос эерэг үр дүнг үзүүлж байгаа нь харагдаж байна. Тухайлбал, хувилбар 1-ийг сонгосон тохиолдолд зохицуулалтын агуулга, шаардлага, нийгэмд үзүүлэх нөлөөний хувьд илүү байна.

Гарч болох сөрөг үр дагавар

Гарч болох сөрөг үр дагаврын хувьд хувилбар 2 нь хувилбар 1-ээс сөрөг үр дагавар ихтэй болох нь дээрх хүснэгтээр тодорхойлогдож байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч, иргэн, аж ахуйн нэгжийг хамгаалах, зөвшөөрөл олгох ажиллагааг хялбарчлах, аливаа шаардлагагүй хориглолт, хязгаарлалтыг багасгаснаар бизнесийн орчин сайжирна. Үүний тулд хууль, эрх зүйн тогтолцоогоор эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах шаардлагатай.

Иймд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийг олон улсын туршлагатай харьцуулан судлах, олон улсын байгууллагуудын зөвлөмж, саналыг харгалзан үзэж, хүчин төгөлдөр үйлчилж буй Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх талаар судалсан болно.

1. Эдийн засгийн эрх чөлөө

Дэлхийн Эдийн Засгийн Эрх Чөлөө (Economic Freedom of the World, EFW)-ний индексээр дэлхийн улс орнуудын хууль тогтоомжийн эдийн засгийн эрх чөлөөт байдлыг үнэлдэг. Эдийн засгийн эрх чөлөө нь хөдөлмөр эрхлэх, хэлцэл хийх, эд хөрөнгө өмчлөх, ашиглах, гүйлгээ хийх зэрэг эдийн засгийн үйл ажиллагаатай холбогдох эрх чөлөөг хамруулсан өргөн ойлголт юм.

Эдийн засгийн эрх чөлөөг бүрдүүлэх гол хүчин зүйлсэд хувь хүний сонголт хийх, хүссэн үедээ арилжаа хийх, өрсөлдөх эрх чөлөө болон өмчийн эрхийн хамгаалалт багтдаг. Иймд төрөөс өмчлөгчийн эд хөрөнгийг хамгаалах болон хууль хэрэгждэг тогтолцоог бүрдүүлэх нь эдийн засгийн эрх чөлөө хангагдах үндэс болдог.

Эдийн засгийн эрх чөлөө нь Засгийн газрыг олон төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон нөхцөлд хангагддаг гэж үздэг. Харин эсрэгээр татвар, хураамж, засгийн газрын зардал ихсэж, олон дүрэм журам батлах нь эрх чөлөөг хязгаарладаг гэж олон улсад үздэг. Эдийн засгийн эрх чөлөөний индекс өндөр орнуудын хувьд Засгийн газар нь тогтвортой валют авахыг зөвшөөрөх, гэнэтийн инфляц эсхүл дефляцийн үед эд хөрөнгө хураан авахгүй байхаар журамласан байдаг байна.

Дэлхийн өв уламжлалын сангаас 2025 онд хийсэн Эдийн засгийн индексийн судалгаагаар 176 улсын эдийн засгийн эрх чөлөөт байдлыг өмчийн эрх, шүүх засаглал, засгийн газрын зарчимт байдал, татварын дарамт, засгийн газрын зардал, санхүүгийн эрүүл мэнд, бизнесийн эрх чөлөө, мөнгөний эрх чөлөө, худалдааны эрх чөлөө, хөрөнгө оруулалтын эрх чөлөө, санхүүгийн эрх чөлөөг гэсэн 12 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн.

Уг судалгаагаар Сингапур Улс 84.1 оноогоор нэгдүгээр байр, Швейцар Улс 83.7 оноогоор хоёрдугаар байр, Тайван 79.7 оноогоор дөрөвдүгээр байрт тус тус эрэмбэлэгдсэн байна. Монгол Улс 62.6 оноогоор 74 дүгээр байранд орсон нь эдийн засгийн эрх чөлөө хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Эдийн засгийн эрх чөлөөг хангах тал дээр гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээг авч үзье.

Гүрж Улсын Бизнесийн эрх чөлөөний тухай (Law on Freedom of Business, 2005 онд батлагдаж 2011 онд нэмэлт орсон) хуулиар бизнесийн эрх чөлөөний ерөнхий баталгааг бий болгож, хуульд тусгайлан заасан болон нийтийн сайн сайхан, ашиг сонирхлоос бусад тохиолдолд төрөөс эдийн засгийн үйл ажиллагааг хязгаарлахыг хориглосон. Мөн өмчлөгчийн эрхийг Үндсэн хуулиар хамгаалж, хөрөнгийг дур зоргоор хураан авахаас хамгаалах, хууль тогтоомж нь бизнесийн эрх зүйн байдлыг доордуулах тохиолдолд буцаан хэрэглэхгүй байхаар тус тус заасан байна.

Казакстан Улсын Бизнес эрхлэгчийн тухай хууль (Entrepreneurial Code, 2015 онд батлагдсан)-ийн 10 дугаар зүйлд бизнес эрхлэгчийг харьяаллаар үл ялгаварлах зарчим болон тэгш эрхийн зарчмыг баталгаажуулж, 26 дугаар зүйлд хөрөнгө хураан авах тохиолдолд олгох нөхөн олговрыг “шударга, тэргүүн ээлжид” олгох, өмчлөгчийн эрхийг хамгаалсан. Мөн хууль тогтоомж тодорхой, тогтвортой байх талаар зааж, хуулийг буцаан хэрэглэхгүй байх, урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал бий болгохоос сэргийлэх талаар заасан байна.

Киргиз Улсын Үндсэн хууль (2010 онд батлагдаж, 2021 онд нэмэлт орсон) болон Төрөөс бизнес эрхлэгчид үзүүлэх дэмжлэгийн тухай хууль (Law on State Support of Entrepreneurship)-д эдийн засгийн эрх чөлөө, бизнес эрхлэлтийг Үндсэн хуулиар хамгаалсан. Мөн бизнес эрхлэгчийн эрх зүйн байдлыг доордуулах тохиолдолд хуулийг буцаан хэрэглэхгүй байхыг тусгайлан заасан бөгөөд Төрөөс бизнес эрхлэгчид үзүүлэх дэмжлэгийн тухай хуулиар зах зээлд эрх тэгш нэвтрэх, хөрөнгө хамгаалах процессыг тусгасан.

Вьетнам Улсын Аж ахуйн нэгжийн хууль (Law on Enterprises, 2020), Хөрөнгө оруулалтын тухай хууль (Law on Investment, 2020)-д аж ахуйн нэгж нь хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох эрхтэй гэж заасан, мөн бүх хувийн хэвшил өмчийн хэлбэрээс үл хамааран ижил тэгш нөхцөлөөр хангагдана гэж заасан. Эрх зүйн баримт бичгийг түгээн дэлгэрүүлэх тухай хууль (Law on Promulgation of Legal Documents)-д хувийн хэвшилд эерэг үр дагавар үзүүлэхээс бусад тохиолдолд хууль буцаан хэрэглэхийг хориглосон.

БНСУ, БНВУ, БНЧУ, БНКУ болон Чили улсын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг эх орондоо татах чиглэлээр дараах байр суурьтай байдаг. Үүнд:

- Хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгах;
- Нэг цэгт иж бүрэн шийдлийн системийг бүрдүүлэх;
- Үйл ажиллагааны зөвшөөрөл олгох процесс, дамжлагыг хялбаршуулах, автоматжуулан хүнээс хамаарлыг бууруулах;
- Хөрөнгө оруулагчдаас төслийн хэрэгжилт дээр нь шаарддаг олон тооны шаардлагуудыг бууруулах;
- Хөрөнгө оруулагч газар болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эзэмших, бизнесийн зорилгоор ашиглах бололцоо олгох;
- Өөрийн хөрөнгийг чөлөөтэй ашиглах, гадаад улс руу шилжүүлэх;
- Төрөөс хувийн өмчийн хөрөнгө, орлогыг хураан авахыг хязгаарлан зөвхөн нийтийн зайлшгүй хэрэгцээг харгалзах;
- Хөрөнгө оруулалтын урамшууллыг хоёр чиглэлээр нэмэгдүүлэх, хүрээг нь тэлэх. Үүнд: стратегийн хөрөнгө оруулагч болон энгийн төсөл хэрэгжүүлэхэд ялгамжтай хандаж, тус тусад нь өөр төрлийн хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;
- Эдийн засгийн өсөлт бий болгох, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байрыг

- олноор бий болгох салбар болон ногоон төсөл, хөтөлбөр, төв суурин газар бус орон нутагт хөрөнгө оруулалт хийхийг түлхүү дэмжих;
- Хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчныг ээлтэй болгох, нээлттэй хэлбэрээр зах зээлээс хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлэх;
- Холбогдох дүрэм, журмын тоог цөөрүүлэх.

Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), Евразийн түншлэлийн харилцан үнэлгээний сайн туршлага (OECD-Euroasia Peer Practices)-д Евразийн Өрсөлдөх чадварын хөтөлбөрийн улс орнууд (Монгол Улс, Казакстан Улс, Киргиз Улс, Гүрж Улс, Украин Улс зэрэг) эдийн засгийн эрх чөлөөний зохицуулалтыг (өмчийн эрхийн хамгаалалтыг багтаан) батлах, мөн хууль буцаан хэрэглэхгүй байх, тэгш эрх, өрсөлдөөний тэгш байдал, хууль тогтоомж боловсруулах ажиллагаа нээлттэй, ил тод байх, түүнд оролцох боломжийг тусгахыг зөвлөсөн.

Дэлхийн Худалдааны Байгууллагын Хөгжлийн төлөөх хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх хэлэлцээрээр (WTO Investment Facilitation for Development Agreement)⁴-т:

- Нээлттэй, урьдчилан таамаглахуйц байх–хөрөнгө оруулалттай холбоотой бүхий л арга хэмжээг нийтлэх, цахим платформыг бий болгох, шинэ журам батлахын өмнө урьдчилан хэлэлцүүлэг хийх;
- Үйл явцыг хялбарчлах–бизнес эхлүүлэх, зөвшөөрөл авах, үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлагыг хялбаршуулж стандартчилах. Үүнд нэг цэгийн үйлчилгээ, цахим платформ нь захиргааны байгууллагын дарамт шахалтыг багасгах үр нөлөөтэй болохыг онцолсон;
- Төрийн үйлчилгээ авах, зөвшөөрөл олгох явцыг хялбаршуулах–баримт бичгийн бүрдүүлбэр, хугацаа, зөвшөөрөл олголт, түүний явцыг харах, гомдол гаргах механизмыг тодорхой ойлгомжтой болгох;
- Байгууллага хоорондын уялдаа холбоо–хөрөнгө оруулалтыг хялбаршуулахтай холбоотой ажилд яамд болон агентлагийн хоорондын уялдаа холбоог сайжруулах;
- Гомдол шийдвэрлэлт, түүний дараах үйлчилгээ–хөрөнгө оруулагч гомдол гаргах, гомдлыг шийдвэрлэх процесс бий болгох үүргийг заасан.

2. Хөрөнгө оруулагчийн хамгаалалт

Мөн БНСУ, БНВУ, БНЧУ, БНКУ болон Чили Улсад хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бизнесийг хөхиүлэн дэмжих бие даасан агентлаг байгуулж, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь олон улсын түвшинд хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх оновчтой хэлбэрт тооцогдож байна. Агентлагууд нь шаардлагатай нөхцөлд өөрийн хэрэгжилт, практик туршлага, төр болон хөрөнгө оруулагчдад тулгамдаж байгаа хүндрэл бэрхшээлд үндэслэн хууль тогтоомжийн болон холбогдох дүрэм, журам зэрэг зохицуулалтад өөрчлөлт оруулах санал зөвлөмжийг боловсруулах нийтлэг эрх, үүрэгтэй.

Чили улсад хөрөнгө оруулагчдыг дэмжих чиг үүрэг бүхий агентлагаас гадна тус улсын Ерөнхийлөгчид стратегийн бодлогын зөвлөгөө өгөх сайд нарын зөвлөл хөрөнгө оруулалтын асуудлыг давхар хариуцан ажилладаг. Мөн БНСУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалт хариуцсан дэд сайд, газрын дарга нар хөрөнгө оруулагч гадаадын компаниудын удирдлагууд, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын

⁴ <https://docs.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=q:/INF/IFD/W55.pdf&Open=True>

гишүүд, худалдаа, эдийн засгийн асуудал эрхэлсэн ажилтнуудтай тогтмол уулзаж, санал солилцдог байна.

3. Хөрөнгө оруулагчийн гомдол, хүлээх хариуцлага

Гүрж Улсын Бизнес эрхлэгчийн хууль (Law on Entrepreneurs) болон Төрөөс бизнесийн үйл ажиллагаанд тавих хяналтын тухай (Law on State Control of Business Activities) хуулиар төрийн албан хаагчийг хуульд заасан эрх мэдлээ хэтрүүлж бизнесийн үйл ажиллагаанд оролцохыг хориглож тэдгээрийн хууль бус үйлдэлтэй холбоотой гомдлыг захиргааны болон шүүхийн журмаар шийдвэрлүүлэхээр заасан.

Казакстан Улсын Бизнес эрхлэгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд төрийн албан хаагч бизнесийн үйл ажиллагаанд эрх мэдлээ хэтрүүлэн дур зоргоор авирлахаас хамгаалж, хууль бус үйлдэлд нөхөн олговор олгох тухай заасан байна. Мөн хуулийн 20 дугаар зүйлд захиргааны байгууллагын аливаа шийдвэр үндэслэлтэй байх, ил тод байх, давж заалдах журмаар гомдол гаргах боломжтой байхаар заасан. Түүнчлэн, хөрөнгө оруулагчийн гомдлыг хүлээн авч шалгадаг, төрийн байгууллагад нөлөөлдөг хянан шийдвэрлэх институтыг бий болгосон.

Узбекистан Улсын Бизнесийн үйл ажиллагааны эрх чөлөөний баталгааны тухай хуульд бизнесийн байгууллага учирсан хохирол болон олох ёстой байсан орлогыг хууль бус үйлдэл хийсэн төрийн байгууллагаас шаардах, шүүхээр хуульд заасан хугацааны дотор шийдвэрлүүлэх талаар заасан байна. Мөн Узбекистан Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны зарлигт хууль ёсны бизнесийн үйл ажиллагаанд саад учруулсан албан хаагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх, бизнес эрхлэгчид учирсан хохирлоо шууд тухайн төрийн байгууллагаас нэхэмжлэх талаар тусгасан.

Дүгнэлт

Судалгаанд сонгон авсан улс орнууд хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх, эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах бие даасан байгууллага байгуулах, эрх зүйн байдлыг доордуулсан хэм хэмжээг буцаан хэрэглэхгүй байх, аливаа шийдвэр гаргахдаа олон нийтийн оролцоог хангаж, хууль тогтоомжийг тогтвортой, ойлгомжтой байх зэрэг асуудалд ихээхэн анхаарал хандуулж эрх зүйн шинэчлэл хийсээр байна.

Мөн төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр авах боломжийг нэмэгдүүлэх, зөвшөөрөл авах шат дамжлагыг хялбаршуулж, шуурхай олгох, өөрийн хөрөнгийг чөлөөтэй ашиглах, гадаад улс руу шилжүүлэх боломжоор хангах, хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчныг ээлтэй болгох, нээлттэй хэлбэрээр зах зээлээс хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журмын тоог цөөрүүлэх бодлогыг баримталж ажилладаг байна.

Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар хураан авахгүй байх, нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагын улмаас үл ялгаварлах зарчим, хуульд заасан журмын дагуу бодит нөхөн олговор олгосны үндсэн дээр хураан авах талаар хамгаалалтын зохицуулалт оруулсан байна. Үүнээс гадна, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт хийх, хадгалах, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гомдол шийдвэрлэх бие даасан байгууллага бий болгосон нь олон улсад тэргүүн туршлагад тооцогдож байна.

Төрийн арга хэмжээ нь урьдчилан таамаглахуйц, нөхцөл байдлын шинж чанарт нийцсэн байх, буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан байгууллага, албан хаагч хариуцлага хүлээх асуудлыг мөн тодорхой тусгажээ.

Иймд хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн талаарх гомдол хүлээн авч, шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагыг бий болгох хэрэгцээ, шаардлага байна. Энэхүү байгууллага нь гомдол хүлээн авч шийдвэрлэх эрхтэй байх бөгөөд гомдлыг шалгасны үндсэн дээр холбогдох төрийн байгууллагад шийдвэрлэх санал хүргүүлэх, бусад төрийн байгууллагаас шаардлагатай бичиг баримтыг авахыг шаардах эрхтэй байна. Түүнчлэн, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт хийх, өргөжүүлэх, хадгалахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах судалгаа, мэдээлэл гаргах чиг үүрэгтэй байхаар зохицуулах нь зүйтэй байна.

Эдийн засгийн эрх чөлөөний баталгааг хангахын тулд зөвхөн хөрөнгө оруулалтаар хязгаарлагдахгүйгээр худалдаа, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн суурь баталгааг бие даасан хуулиар тусгайлан зохицуулах нь Зүүн Европ, Төв Азийн орнуудад жишиг болсон байна. Иймд энэхүү харилцааг бие даасан Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хууль баталж зохицуулах шаардлага гэж үзэж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах асуудлыг дээрх бүх улс үйл ажиллагаа явуулах эрх, зөвшөөрөл, газрын эрхийг олгох, сунгах болон үзүүлж байгаа татвар болон татварын бус дэмжлэгтэй шууд уялдуулсан. Ялангуяа үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарт ногоон төсөл, инновац, шинэ технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжихдээ хөнгөлөлт, урамшуулал, визний нөхцөл, газар болон үл хөдлөх хөрөнгийн эрх олгох, сунгахтай уялдуулсан.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Тус судалгаа буюу “Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”-ны хүрээнд 6 бүлэг бүхий аргачлалыг үндэслэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалж, дараах үр дүнд хүрч байна.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага нь хөрөнгө оруулалт, бизнесийн орчин орчин тогтворгүй, зарим тохиолдолд тодорхойгүй бөгөөд ойлгомжгүй, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах механизм бодитой бүрдээгүй, хууль ёсны баталгааг хуульд бүрэн тусгаагүй, төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхойгүй, үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байна.

Судалгааны хүрээнд дээр дурдсан хэрэгцээ шаардлагад үндэслэн хувилбар буюу зохицуулах аргуудад дүгнэлт хийн тэднээс хоёр хувилбарыг сонгож хооронд нь харьцуулсан. Тус харьцуулалтын үр дүнд хувилбар 1 буюу Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл боловсруулж, батлах хувилбар нь зорилгод хүрэх байдал, зардал, өгөөжийн хувьд илүү болох нь ажиглагдсан.

Иймд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалтыг хийх шаардлагатай.

--oOo--



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2025 он

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий зүйл

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т “эдийн засгийн аюулгүй байдал”-ын хүрээнд олон тулгуурт, оновчтой бүтэц бүхий, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, эдийн засгийн бие даасан байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтлах”-аар заасан бөгөөд мөн үзэл баримтлалын 3.2.2-т “хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогын хүрээнд үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх”-ээр заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогод “...эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэсэн зорилгыг дэвшүүлж, “бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх” замаар 2030 он гэхэд хүрэх зорилтыг тавьсан байдаг.

Мөн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3-т эдийн засгийн бодлогыг “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ.” гэж тодорхойлсон. Мөн үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.2-т “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, мөн үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополийн эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, мөн үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.4-т “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол улсын эдийн засагт 1994 оноос хойш уул уурхайн салбарын эзлэх хувь тэлж, уул уурхайн бус салбар, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь агшжээ. Тухайлбал, уул уурхайн салбарын нийт ДНБ-д эзлэх жин өнгөрсөн 30 жилд 10 хувиас (1994 он) 27 хувь болж (2024 он) өссөн бол хөдөө аж ахуйн салбарын жин 27 хувиас 7 хувь болж буурчээ. Барилга, бүтээгдэхүүний цэвэр татвараас бусад үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь 1994 онд 35 хувийг эзэлдэг байсан бол 2024 онд 44 хувь болж өссөн байна.

Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагас жилд 5.6 хувьд хүрч, төсөөллийн орчимд байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн

хэвээр байгаа ба уул уурхай, барилга, боловсруулах салбаруудын үйл ажиллагааны идэвхжил нэмэгдсэнээр эдийн засгийн нийт өсөлтөд үзүүлэх эерэг нөлөө нэмэгдлээ. Харин тээвэр болон худалдааны салбар агшилт хадгалагдлаа. Эрэлт талаас хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол барааны экспорт, төрийн хэрэглээ буурсан нь өсөлтийг саарууллаа. Ажиллах хүчний оролцооны түвшин 62 хувьд хүрч, нэрлэсэн орлого өссөн нь нийт өрхийн хэрэглээг дэмжсэн ч үнийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн бодит орлогын өсөлт 5.8 хувьд хүрч саарсан байна.

Түүнчлэн “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” болон “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 149 хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төслүүд нь бүрэн хэрэгжсэнээр макро эдийн засгийн төрөлжүүлэх, төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөлөл үзүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой хэдий ч 22 төслийн нийт төсөвт өртөг 3.8 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай байна.

Цаашлаад олон улсын эдийн засгийн нөхцөл байдал эрсдэлтэй, тодорхойгүй байдал давамгайлж байгаа нь манай улсын эдийн засагт ихээхэн сөрөг нөлөөлөл учруулж байна. Тухайлбал, АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаанаас шалтгаалж БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширсан, Орос, Украины дайны нөхцөл нь манай улсын гадаад худалдаа, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хязгаарлаж, бараа бүтээгдэхүүний тээврийн зардлыг өсгөсөн, түүнчлэн Израил–Ираны мөргөлдөөн нь газрын тосны үнэ, инфляцад шууд нөлөөлж байна.

Дэлхийн өв уламжлалын сангаас “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг засаглалын үр ашиг, Засгийн газрын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээл гэсэн 4 бүлгийн хүрээнд 12 шалгуур үзүүлэлтээр тооцдог бөгөөд Монгол Улс 2024 онд нийт дүнгээрээ 176 улсаас 60.6 оноотойгоор 74 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна. Шалгуур үзүүлэлтүүдийн оноо ангиллаар өмчийн эрх 92/176 муу, төрийн зарчимт байдал 117/176 муу, бизнесийн эрх чөлөө 79/176 дунд, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал 119/176 бага гэж үнэлэгдсэн байна. Эндээс харахад хувь хүмүүсийн өмч эзэмших эрх чөлөөг хангах, төрийн албаны авлига авах эрсдэлийг бууруулах, бизнесийн үр ашигтай үйл ажиллагааны хязгаарлалтыг бууруулах, хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой Дэлхийн банкны Doing Business-2020, МҮХАҮТ-ын Монголын бизнесийн орчны үнэлгээ-2023, Economist Intelligence Unit, Дэлхийн эдийн засгийн форумын Өрсөлдөх чадварын индекс тайлангуудад дүн шинжилгээ хийхэд бизнес, худалдаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулж, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангасан нэгдсэн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, эдийн засагт нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг шийдвэрлэхийн тулд эдийн засгийг төрөлжүүлэх, бизнес, хөрөнгө оруулалтыг дэмжсэн таатай орчныг бүрдүүлэх чухал болоод байна. Энэ хүрээнд аж ахуйн

нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгах, гарааны компаниудын бизнесийг дэмжих, экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр бодлого, зохицуулалтын арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Иймд хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулах нь төрөөс эдийн засгийн баталгааг нь хангах, эрх ашгийг хамгаалах, төрийн оролцоог бууруулах нь чухал ач холбогдолтой тул Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Хоёр.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндсэн асуудлыг зохицуулахаар зорьсон чиглэл тус бүрээс хуулийн төслийн зорилтыг хамгийн сайн илэрхийлж чадах зохицуулалтыг сонгож, хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай холбогдуулан, аргачлалд дурдсан “зорилгод хүрэх байдал”, “ойлгомжтой байдал”, “зардал”, “харилцан уялдаа”, гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр сонгож авсан.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хүснэгт 1-т үзүүлсний дагуу тогтоосон.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3.	Зардал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн нөлөөллөөс иргэн аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагад гарах нэмэгдэл зардлыг үнэлж тооцох.
4.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн

төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Тус хуулийн төслийн үзэл баримтлалд дараах үндсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

- Эдийн засгийн эрх чөлөөг хангахад баримтлах зарчмыг тодорхойлох;
- Эдийн засгийн эрх чөлөөг хангах үйл ажиллагаа;
- Эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах, хориглосон хуульд тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулах;
- Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх механизмыг бүрдүүлэх;

Иймд үзэл баримтлалын төсөлд тусгасан эдгээр зорилтод Хуулийн төсөл нийцэж байгаа эсэхийг үнэлэв.

Хүснэгт 2. Хуулийн төслийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн байдал

Хуулийн төслийн үзэл баримтлал	Хуулийн төслийн зохицуулалт
Эдийн засгийн эрх чөлөөг хангахад баримтлах зарчмыг тодорхойлох;	Хуулийн төслийн 5 дугаар зүйлд Төр иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулахтай холбоотой дараах агуулгын хүрээнд үндсэн зарчмуудыг тодорхойлсон байна. - хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг хуулийн дагуу чөлөөтэй эрхлэх зарчим; - өмчийн халдашгүй байдлын зарчим - аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн тэгш эрхийн зарчим; - шударга өрсөлдөөний зарчим; - оролцоог хангах зарчим -хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээлэл, ил тод, хүртээмжтэй байх зарчим; - аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдвөл аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, 16 дугаар зүйлийн 16.4-т “...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэж тус тус заасан. Иймээс төрийн зүгээс иргэн, хуулийн этгээдийн эрхлэх аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой харилцаанд оролцохдоо баримтлах нийтлэг зарчмуудыг тодорхой тусгасан бөгөөд тэдгээр зарчмыг төрийн бүх шатны байгууллагууд болон хувь хүн, байгууллага (зохио хэмжээнд) дагаж мөрдөх үүргийг хүлээхээр зохицуулсан байгаа нь хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
Эдийн засгийн эрх чөлөөг хангах үйл ажиллагаа	6 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого

	6.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эдийн засгийн эрх чөлөөний баталгааг хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцохгүй, хохирол, саад учруулахгүй байхад чиглэнэ. 6.2.Төрийн бодлого, хууль тогтоомж, захиргааны шийдвэр нь тодорхой, хоёрдмол утгагүй, нийтэд ойлгомжтой байна. 6.3.Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, захиргааны шийдвэр гаргах тохиолдолд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч, мэргэжлийн холбоодод урьдчилан мэдэгдэх, оролцоог хангах, шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэлэлцүүлгийг нэгээс доошгүй удаа зохион байгуулна. 6.4.Төрийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем, албаны цахим шуудан, нийтийн мэдээллийн системийг ашиглан, эсхүл нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр шуурхай үзүүлнэ. 6.5.Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, зөвшөөрөл олгох ажиллагааг хялбарчлах, гомдол шийдвэрлэлтийн талаар олон нийтэд нээлттэй үйл ажиллагааг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна. 6.6.Төрийн хяналт, шалгалтын биечлэн хийх шаардлагатайгаас бусад хэсгийг цахим хэлбэрээр хийх нөхцөлийг бүрдүүлнэ. 6.7.Төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд хяналт, шалгалт хийхгүй байх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн татгалзах эрхийг хүндэтгэнэ. 6.8.Төрийн байгууллага хуулиар хязгаарлаж, хориглосноос бусад мэдээллийг зохих журмын дагуу нээлттэй өгөгдөл болгон олон нийтэд нээлттэй, үнэ төлбөргүй байршуулж, тогтмол шинэчилнэ. 6.9.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хүсэлт, гомдол, өргөдлийн хариуг хуульд заасан хугацаанд өгөх, шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг цахим хэлбэрээр харах боломжийг бүрдүүлнэ. 6.10.Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын гэрээнд орон нутагт эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар тусгаж, үр дүнг үнэлж дүгнэнэ. Дээрх зохицуулалтууд нь төрийн зүгээс эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих, төрийн үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг хялбарчилсан байна. Төр нь бизнес эрхлэгчдэд биелүүлэхэд ойлгомжтой, боломжтой хууль, шийдвэрийг гаргах, энэ нь бизнесийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх, олон нийтийн
--	--

	оролцоог хангах, ил тод байдлыг хангах зэрэг шаардлагуудыг хуульчилж, төрийн албан тушаалтнууд хууль бус үйлдлээр бизнес эрхлэгчдэд учирсан хохирлын төлөө хариуцлага хүлээлгэх, төрийн үйлчилгээг хурдан, нэгдсэн системээр үзүүлэх зэрэг төрийн бизнес эрхлэгчдэд зориулсан дэмжлэг, тодорхойлолт, үйлчилгээний үр ашигтай байдлыг бий болгох зорилгоор гаргасан нөхцөлүүдийг тусган байгаа нь хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангасан байна.
Эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах, хуульд тавигдах шаардлагыг зохицуулах:	7 дугаар зүйл.Төрийн байгууллага, албан тушаалтанд хориглох үйл ажиллагаа 7.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, шударга өрсөлдөөнийг дэмжих, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаас бусад тохиолдолд төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлан гаргахыг хориглоно. 7.2.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт, шалгалт хийх, хяналт шалгалтыг удаашруулахыг хориглоно. 7.3.Зарим аж ахуйн нэгжид давуу байдал бий болгосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлахыг хориглоно. 7.4.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулахыг хориглоно. 7.5.Хувийн өмчийг хууль бусаар шууд болон шууд бус хэлбэрээр хураан авахыг хориглоно. Зөвхөн нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, үл ялгаварлаж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу, нөхөх олговортойгоор хураан авч болно. 7.6.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг доромжлох, гүтгэх, бие махбодод халдах, эд хөрөнгийг сүйтгэх, нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараахыг хориглоно. Монгол Улсын төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хамгаалах, шударга өрсөлдөөн дэмжих, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хязгаарлалтуудыг тодорхойлж, эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг батлахгүй байх, хуульд заагаагүй төрийн хяналт, шалгалт явуулах, давуу эрх олгосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг батлах, үйл ажиллагаа явуулах, нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулахыг хязгаарласан байна. Мөн төрөөс аж ахуйн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, өмч хөрөнгийг хууль бусаар хураан авах, дайчлахыг хориглож, үндэслэлгүйгээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр хүндэд халдах, гутаан доромжлох, гүтгэх, бие махбодод нь халдах, эд хөрөнгийг сүйтгэх зэрэг хууль бус үйлдлийг хориглосон байгаа нь эдийн засгийн эрх чөлөө, шударга өрсөлдөөнийг хамгаалахад чиглэсэн бодлого юм.

	Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх бүрдүүлэх механизмыг	8 дугаар зүйл. Эдийн засгийн бодлогын зөвлөл 8.1.Төр болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хооронд байнгын ажиллагаатай зөвлөлдөх тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Эдийн засгийн бодлогын зөвлөл ажиллана. 8.2.Эдийн засгийн бодлогын зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд ахална. 8.3.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална. Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувьд хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна. 8.4.Эдийн засгийн бодлогын зөвлөл дараах эрх, үүрэгтэй байна: 8.4.1.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахад ашиг сонирхол нь хөндөгдөх аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж болон мэргэжлийн холбоодын саналыг хүлээн авах, холбогдох төрийн байгууллагад саналыг хүргүүлэх, саналыг шийдвэрт тусгасан эсэх талаар эргэн мэдээлэх зэрэг шийдвэр гаргалтад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн оролцоог хангах; 8.4.2.аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай болон хууль тогтоомжийн давхардал, хийдэл зөрчлийг арилгах чиглэлээр судалгаа хийх, төрийн байгууллагын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах талаар зөвлөмж гаргах; 8.4.3.аж ахуй үйл ажиллагаа эрхлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор төрийн хүнд суртал, хууль бус үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын мэдээллийг нэгтгэн боловсруулж Засгийн газарт танилцуулах. Эдийн засгийн бодлогын зөвлөл нь төр болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн хооронд байнгын зөвлөлдөх тогтолцоог бий болгож, Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулан бүрэлдэхүүнд нь 50%-иас доошгүй хувь хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөл байхаар тусгасан байна. Түүнчлэн зөвлөл нь төрийн бодлого, хууль тогтоомжид санал хүргүүлэх, иргэд, аж ахуйн нэгжийн саналыг хүлээн авч, шийдвэрт тусгасан эсэхийг мэдээлэх, бизнесийн орчныг сайжруулах, аж ахуйн эрхлэгчийн хууль ёсны эрхийг хамгаалах, өргөдөл, гомдлын талаар Засгийн газарт танилцуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Иймд энэхүү зөвлөл нь эдийн засгийн бодлогыг боловсронгуй болгоход төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх

	механизмыг бүрдүүлсэн байх тул хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
--	---

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгасан.

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг тогтоох зорилгоор иргэд, олон нийтээс хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд ойлгомжгүй байгаа зохицуулалт байхгүй талаар саналаа ирүүлсэн.

Хүснэгт 3. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагад нийцсэн байдал

Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.

30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан

3.3. “Зардал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Төрд үүсэх зардал: Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.

Иргэнд үүсэх зардал: Иргэдэд нэмэлт зардал үүсгэхгүй.

Иргэн, аж ахуйн нэгжид: Хуулийн төсөл батлагдсанаар аж ахуйн нэгжид нэмэлт зардал үүсгэхгүй бөгөөд төрийн байгууллагаас үйлчилгээ авахад тулгамдаж буй асуудлууд шийдэгдэж, цаг хугацаа, процессуудыг хялбарчилснаар зардлыг хэмнэнэ.

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийг бүхэлд нь авч үзсэн.

Хүснэгт 4. Хуулийн төслийн аргачлалын дагуу үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөл нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэн хөгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн, шуурхай хүргэх, харилцан мэдээлэл солилцох зэргээр тэдгээрийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн агуулгатай нийтлэг зохицуулалтыг тусгасан тул хуулийн зорилттой нийцэж байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төсөл нь эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулж, аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомж, шийдвэрийг батлахдаа тус анхдагч хуулийг давуу хүчинтэй байдлаар баримтлах эрх зүйн орчныг бүрдүүлэх тул Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн нэр уялдаж байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын стандарт болон бусад хуульд нийцүүлсэн байна.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Нийцсэн байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан.
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан, нэг чиг үүргийг хоёр өөр төрийн байгууллага гүйцэтгэх, давхардуулсан зохицуулалт байхгүй байна.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй. Авлига, хүнд суртлыг таслан зогсоох буюу түүнийг шийдвэрлэхтэй холбоотой механизмыг тусгасан.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийг хохироор, төрийг хариуцлагад оруулсан албан хаагч, хувь хүнд албан тушаалын болон эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Дээрх судалгаанаас үзэхэд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл нь хууль тогтоомжтой уялдсан бөгөөд давхардалгүй байна.

Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Дүгнэлт: Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

- Хуулийн төслийн зорилт нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, үндэслэлийг бүрэн илэрхийлж чадсан байна.

- Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөлд тодорхойлсон зорилго, зорилтыг бүрэн илэрхийлсэн байна.

- Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах шаардлагад нийцсэн бөгөөд төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байна.

- Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байна.

Тав. Зөвлөмж

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхэд хуулийн төсөл зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байх тул хуулийн төслийг хэвээр үлдээх нь зүйтэй байна.

---oOo---



**ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ**

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

2025 он

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий мэдээлэл

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төслийг анхдагч хууль хэлбэрээр боловсруулсан байна. Хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр болон өмнө гүйцэтгэж байсан үүрэгт шинээр нэмэгдсэн, эсхүл хасагдсан чиг үүргийн хүрээнд үнэлгээг хийнэ.

Хуулийн төсөл нь аж ахуйн үйл ажиллагааг хуулиар хориглосноос бусад тохиолдолд чөлөөтэй эрхлэх, өмчийн халдашгүй байдлыг хангах, аж ахуйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, гадаад, дотоодын зах зээлд чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог багасгаж, зохицуулалтын үр нөлөөтэй байдлыг хангах зорилгоор аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомж, шийдвэрийг батлахад баримтлах зарчмыг тодорхойлсон байна.

Хуулийн төсөлд Эдийн засгийн бодлогын зөвлөлийн чиг үүргийг тодорхойлж, уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслөөр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргээс давхардлыг арилгахад чиглэсэн байна. Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн зохицуулалтаар шинээр орж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцсон болно.

Хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хоёр. Иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцсон байдал

Зардал тооцсон субъект:

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

“Аргачлал”-ын 1.5-д заасны дагуу дараахь 3 этгээдтэй холбогдон гарах зардлыг тооцов.

1. Иргэнд үүсэх зардал;
2. Хуулийн этгээдийн зардал;
3. Төрийн байгууллагын зардал.

1. Иргэнд үүсэх зардал

Хуулийн төслийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хөрөнгө оруулагчийг багтаан үзсэн болно.

Дүгнэлт: Хуулийн төслөөр иргэний хувьд нэмж гүйцэтгэх үүрэг үүсэхгүй тул иргэнд шууд үүсэх зардал байхгүй болно.

2. Хуулийн этгээдийн зардал:

Хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, аж ахуйн үйл ажиллагаанд төрөөс баримтлах зарчмыг тогтоох, төрийн оролцоог багасгаж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэхтэй зорилготой. Энэ зорилгын хүрээнд боловсруулсан хуулийн төслийн нэмэлт зохицуулалтууд нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд эерэг нөлөөтэй бөгөөд ямар нэгэн илүү үйлдэл, зардал үүсгэхгүй.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулалт хийх таатай орчин бүрдэж, үйл ажиллагаа явуулахад төрийн байгууллагын авлига, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг бууруулж, төрийн үйлчилгээ авахад бүрдүүлэх баримт бичгийн тоо, шат дамжлагыг багасгах боломж бүрдэх тул зардлыг бууруулах эерэг нөлөөлөлтэй.

Дүгнэлт: Хуулийн төслөөр хуулийн этгээдийн хувьд шууд үүсэх зардал байхгүй, харин хуулийн этгээдүүдэд зардал талаасаа илүү таатай орчин бүрдэж байна.

3. Төрийн байгууллагын зардал:

3.1. Эдийн засгийн бодлогын зөвлөл

Тус бодлогын зөвлөл нь төр, хувийн хэвшлийн зөвлөлийн механизмыг бүрдүүлж, төрийн шийдвэр гаргалтад хувийн хэвшлийн оролцоог хангах бөгөөд шинээр бүтэц орон тоо нэмэх шаардлагагүй, Засгийн газрын үйл ажиллагааны хүрээнд ажиллах тул төсөвт нэмэлт зардал үүсэхгүй, шинэ бүтэц орон тоо бий болгохгүй байна.

3.2. Засгийн газар болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

Хуулийн төслийг дагалдаж Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөлд Засгийн газраас хөрөнгө оруулалтын асуудлаар ерөнхий чиг үүргийг тодорхой тусгасан нь төсөвт ямар нэгэн зардал үүсгэхгүй болно.

Мөн хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Эдийн засаг, хөгжлийн яамны зарим чиг үүрэг нь Хөрөнгө

оруулалт, худалдааны газарт шилжих тул шинээр орон тоо нэмэх, бүтэц өөрчлөх шаардлагагүй тул төсөвт ямар нэгэн зардал нэмэгдэхээргүй байна.

3.3.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага:

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 69 дүгээр тогтоолоор Хөрөнгө оруулалт худалдааны газрыг “Төрийн захиргааны байгууллын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д оруулсан байдаг. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 37 дугаар тогтоолоор Хөрөнгө оруулалт, худалдааны газрыг байгуулж, орон тооны хязгаарыг 30 байхаар тогтоосон.

Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуульд тус байгууллагын талаар болон түүний чиг үүргийн талаар ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй.

Иймд хуулийн төсөл батлагдсанаар Хөрөнгө оруулалт, худалдааны газрын чиг үүрэг хуульд тусгагдаж, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчин бүрдэж байгаа ба батлагдсан орон тооныхоо хүрээнд үйл ажиллагаагаа явуулах тул төсөвт зардал нэмэгдэхгүй байна.

3.4. Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл

Мөн түүнчлэн хуулийн төсөлд Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөлд Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн Ажлын албаны чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр тул бөгөөд шинээр орон тоо нэмэх, нэмэлт санхүүжилт шаардагдахгүй байна.

Гурав. Дүгнэлт

Зардлын тооцооны судалгааны үр дүнд Эдийн засгийн эрх чөлөөний хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, холбогдох төрийн байгууллагад нэмэлт зардал гарахгүй, төсөвт дарамт учрахгүй нь тогтоогдов.

Харин аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг шуурхай авах, санал хүсэлт, эрх ашгаа хамгаалуулах тогтолцоо бий болж, зардлаа хэмнэх, үйл ажиллагаагаа саадгүй явуулах нөхцөл бүрдэнэ.

--oOo--

ТАНИЛЦУУЛГА

*Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн
төслийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион
байгуулсан тухай*

Хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах, оролцогч талуудын санал хүсэлтийг авах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу бичгээр болон цахимаар, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг хэлбэрээр зохион байгуулан ажилласан.

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн санал авахаар 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яамны цахим хуудсанд, 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тус тус байршуулж нээлттэй санал авсан.

Хуулийн төсөлд Дэлхийн банк, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим, Европ Монголын Хамтарсан Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Бизнесийн Зөвлөл, Улаанбаатар Хотын Худалдааны Танхим, Монгол дахь Австралийн Худалдааны Танхим, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, “Монцемент билдинг материалс” ХХК, “Монполимет” ХХК болон иргэдээс ирүүлсэн 200 орчим саналыг хүлээн авсан.

2.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн эхний хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж, хувийн хэвшил болон олон улсын байгууллагын 240 гаруй төлөөллийг өргөнөөр оролцуулан олон нийтийн оролцоог ханган ажиллав.

Тус хэлэлцүүлгийн үеэр хуулийн төслийг олон нийтэд танилцуулж, Монгол Улсын хөрөнгө оруулалт, бизнесийн орчны өнөөгийн нөхцөл байдлыг илтгэх олон улсын үнэлгээ, дүгнэлтийг танилцуулсан. Эдгээр үнэлгээ нь бизнес эхлүүлэхэд шат дамжлага, хугацаа их шаарддаг, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин сул байгааг харуулж байгааг онцоллоо. Үүнтэй холбогдуулан бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг бодитой хамгаалах, бизнесийн орчныг сайжруулах зорилгоор хуулийн төслийг боловсруулж, олон нийтээс санал авах үйл явцыг эхлүүлсэн талаар танилцуулсан.

Мөн хэлэлцүүлгийн хүрээнд уг хууль нь хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжуудын малгай хууль болж, төрөөс хууль бус хяналт шалгалт хийх, хуулиас давсан дүрэм, журам батлахыг хориглох, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын бие, хөрөнгө, үйл ажиллагаанд халдсан аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох эрх зүйн баталгааг бүрдүүлэх ач холбогдолтойг тайлбарлав.

Хэлэлцүүлэгт оролцогчид хуулийн төслийн суурь үзэл баримтлал, зорилгыг нийтлэгээр дэмжиж, төслийн агуулга, хэрэгжилтийг хангах механизм, бизнесийн орчинд үзүүлэх бодит нөлөөллийн талаар санал солилцсон. Энэ хүрээнд хуулийн нэр томьёо, тодорхойлолтыг нарийвчлах, хуулийн хэрэгжилтийг хангах зохицуулалт, хариуцлагын тогтолцоо, институтийн бүтэц, хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах, түүнчлэн холбогдох зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох шаардлагатайг онцолсон.

Олон нийтийн ирүүлсэн саналыг хуулийн төсөлд тусгаж, шаардлагатай зохицуулалтыг сайжруулж ажилласан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу олон нийтийг оролцоог хангасан болно.

---oOo---

[illegible]



**ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН УГ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН БОЛОВСРУУЛСАН
БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛД ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ**

№	Байгууллагын нэр, ирсэн бичгийн огноо, дугаар	Санал	Саналыг тусгасан байдал
1.	Монголын Өмгөөлөгчдийн Холбоо (2025.10.01 01/411)	Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд: 1/4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан “ажиллагаа” гэснийг “ажиллагаа” гэж өөрчлөх 2/7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад заасан “Зам, гүүр, ус, цахилгаан” гэснийг “Зам тээвэр, усан хангамж, эрчим хүч, харилцаа” гэж өөрчлөх	Саналыг тусгасан.
2.	Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (2025.10.02 01/990)	Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль төсөлд: 1/ Эдийн засгийн эрх чөлөө гэж юу болохыг тодорхойлоогүй цагт хуулийн заалтыг хэт өргөн, эсхүл явцуу утгаар тайлбарлах боломжийг бий болгодог. ОУ-д эдийн засгийн эрх чөлөөг төр хуульд зааснаас өөр нэмэлт захиргааны шаардлага тавих замаар бизнес эрхлэгчдийг хүндрүүлэхийг хязгаарлах тухай тодорхойлсон байна. Иймд хуулийн төсөлд дараах нэр томьёог нэмэх: “Эдийн засгийн эрх чөлөө гэж хүн, хуулийн этгээд Үндсэн хуулиар баталгаажсан аж ахуй чөлөөтэй эрхлэх, хувийн өмчтэй байх, өмч халдашгүй байх эрхээ төрийн хамгийн бага оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжид суурилсан чадварыг хэлнэ.” 2/ Эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалтыг баримтлах гэдэг нь сонгох боломжтой 2 ба түүнээс дээш эрх зүйн зохицуулалт байгаа тохиолдолд хэрэглэгдэнэ. Гэтэл хийдэл гэдэг нь эрх зүйн зохицуулалт байхгүй буюу зохицуулалтгүй байхыг хэлнэ. Иймд 5.1.5-г “хууль тогтоомж хооронд давхардал, зөрчил үүссэн, эсхүл хуулийг хууль буцаан хэрэглэх тохиолдолд хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн байх зохицуулалтыг баримтлах” гэж өөрчлөх 3/ Нийгмийн хариуцлага гэх нэр томьёо тодорхой агуулгатай. Жишээ нь ОУ-д компанийн нийгмийн хариуцлага гэдгийг экологид	Хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан. Саналыг агуулгын хувьд тусгасан. Тус заалтыг хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад үндэслэн хассан. Хуулийн төслийн 2.3-т “Монгол Улсын хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн актын хэм хэмжээ нь энэ хуулиар баталгаажуулсан эдийн засгийн эрх чөлөөг хангах хэм хэмжээг дордуулахыг хориглоно.” гэх хэсгийг нэмсэн. Саналыг агуулгын хувьд тусгаж, холбогдох заалтыг өөрчлөн найруулсан.

	ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ цаг тухайд нь зохих ёсоор биелүүлэх, хөдөлмөрийн эрүүл, аюулгүй таатай орчныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зэрэг тогтвортой хөгжилд чиглэсэн үйлдэл, үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг хэлдэг. Тухайлбал, хог хаягдал үүсгэсэн бол түүнийгээ буцаад устгадаг, боловсруулдаг байх, байгальд сөрөг нөлөө бүхий техник тоног төхөөрөмжийг ногоон тоног төхөөрөмжөөр солих гэх мэт. Тиймээс нийгмийн хариуцлага гэдэг үгийг болгоомжтой ашиглах ёстой. Иймд 5.1.12-г “аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг хандив, тусламж, сайн үйлсийн аян, санхүүгийн болон бусад байдлаар хүлээн авагч этгээдэд давуу байдал үүсгэсэн дэмжлэг зэрэг үйл ажиллагаанд албадан оролцуулахгүй байх” гэж өөрчлөх	
	4/ Төслийн 5.1.13-д улсын байцаагчаас татгалзан гарах тухай ойлголтыг хэлж байгаа эсэх, эсхүл хяналт шалгалт хийлгүүлэхгүй байх тухай эсэхийг ялгаж зохицуулах шаардлагатай. Энэ заалт нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд багагүй өөрчлөлт оруулах хэмжээний зохицуулалт байх авч дагалдах хууль дунд ийнхүү өөрчлөлтийг тусгаагүй байна. “5.1.13. төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө хяналт шалгалт хэрэгжүүлэх албан тушаалтан нь хуульд заасан сонирхлын зөрчилгүй байх шаардлагыг хангаагүй тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч албан тушаалтнаас татгалзан гарах боломжийг бүрдүүлэх” гэж өөрчлөх мөн дагалдах хуульд тусгах	Саналыг тусгасан. Хуулийн төслийн 6 дугаар зүйл “Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого”-ын 6.7-д “Төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд хяналт, шалгалт хийхгүй байх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн татгалзах эрхийг хүндэтгэнэ.” гэж туссан.
	5/ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан шүүх байгууллагаас бусад зөрчил шалган шийдвэрлэх эрхтэй эрх бүхий этгээдийн эрх хэмжээг хязгаарлах буюу захиргааны шийтгэл оногдуулах төрөлд эд хөрөнгө хураан авах эрх хэмжээг шүүхээс бусад байгууллагад олгосон байдаг. “5.4.Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэйгээс бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эд хөрөнгийг хураан авч болохгүй. Хуульд заасан тохиолдолд улсын хэрэгцээнд зориулан эд хөрөнгийг түүнтэй адилтгах нөхөн олговортойгоор албадан хурааж болно.” гэснийг хасах, эсхүл Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах	Саналыг тусгаж өөрчлөн найруулсан.

	6/ Зээл авахад эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлээ баталгаажуулахыг “Барьцаа” гэж тодорхойлно. Оюуны өмч нь барьцааны зүйл байх боломжийг ИХ-аар олгосон байдаг. 5.6-г “Төр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч өөрийн оюуны өмчийг зээлийн барьцаа болгон ашиглах боломжийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх	Хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан.
	7/ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.4-т “худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан” гэж тухайлан зааж ердийнхөөс урт хугацаа тавьсан. Эдийн засгийн эрх чөлөө гэдэг ойлголтод дээрх 3 ойлголт хамаарч байгаа тохиолдолд давхардал үүснэ. Тиймээс эдийн засгийн эрх чөлөө гэх ойлголтыг мөн л нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Хууль тогтоомжийн тухай хууль дагалдах хуулиар ороогүй байна. Эдийн засгийн эрх чөлөө гэх ойлголтыг тодорхойлоод, “6.1.4.энэ хуульд заасан эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж, хориглосон хууль тогтоомжийг батлахын өмнө хууль тогтоомжийн төслийг бүрдүүлбэрийн хамт Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo)-д хуанлийн 90 хоногоос доошгүй хугацаанд нээлттэй байршуулж, олон нийтээс санал авах” гэж өөрчлөх, дагалдах хуульд тусгах	Хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан
	8/ Жагсаалт оруулах нь хууль тогтоомж тодорхой байх зарчимд нийцэх ч зарим тохиолдолд “зөвшөөрснөөс бусдыг хориглоно” гэх Захиргааны эрх зүйн зарчимд захирагдах тул эргээд эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл болдог. “7.1.Төр өөрт хамаарах дараах зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид шилжүүлж болно” гэж заасан. “Ийнхүү жагсаасан нь өөр бусад чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид шилжүүлэхийг хязгаарлах үндэслэл болохгүй.” гэж нэмэх	Хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан.
	9/ Дагалдах хуулиар өөрчлөлт оруулах шаардлагатай. Энэ тохиолдолд тус зохицуулалт хэрэгжих боломж бүрдэх ба үгүй бол “болно” гэдэг үг тунхгийн шинжтэй байсаар байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулах харилцаа бөгөөд хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан.

	“7.3.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зорилгоор 1 жилээс дээш хугацаагаар ашиглалтгүй байгаа төрийн өмчийн эд хөрөнгийг тодорхой нөхцөл, журмын дагуу эзэмшүүлэх, ашиглуулж болно.” гэж заасан тул Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 10/ Төрийн аль байгууллага, ямар процесс журмын дагуу энэ санал хүсэлтийг хүлээн авах нь тодорхойгүй тохиолдолд бодит амьдралд хэрэгжихгүй. “7.4.Төрийн байгууллага, албан тушаалтан өөрийн харьяалагдах салбарын асуудлаарх аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалтын давхардлыг арилгах, улсын бүртгэл, зөвшөөрөл, татварын тогтолцоог боловсронгуй болгох санал, хүсэлтийг жилд 1-ээс доошгүй удаа хүлээн авч шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээг авна” гэж өөрчлөх 11/ Үнэлгээний систем нэвтрүүлэх нь том хэмжээний процесс тул журмаар зохицуулагдах шаардлагатай. Мөн дүгнээд л орхидог бол сайн үнэлэгдэх шаардлага үүсэхгүй тул үнэлгээ ямар байхаас хамаарч авах арга хэмжээ, албан тушаалтны хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай. “7.6.Төрөөс орон нутагт эдийн засгийн эрх чөлөөт байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлж аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг жил бүр эрэмбэлж, дүгнэнэ. Арга хэмжээний төлөвлөгөө гаргах, батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх, хариуцлага тооцох нөхцөл, шаардлагыг Эдийн засгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас батална.” гэж өөрчлөх.	
	12/ Захиргааны шийдвэр үйл ажиллагааны талаар өргөдөл, гомдол гаргах процесс журмыг Захиргааны хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нарийвчлан зохицуулсан байдаг. Тухайлбал, өргөдөл, гомдол гаргах хуулийн хугацаа, өргөдөл, гомдлын шаардлага зэрэг нарийн төвөгтэй ойлголтуудыг шууд үгүйсгэж болохгүй юм.	Саналыг тусгасан.
		Саналыг агуулгын хувьд тусгасан.
		Саналыг агуулгын хувьд тусгасан.

	“9.2. Төрийн байгууллага, албан тушаалтан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хуульд заасан шаардлагын дагуу гаргасан тайлбар болон өргөдөл, гомдлыг хүлээж авахаас татгалзаж болохгүй бөгөөд гомдол хүлээн авах үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллана” гэж өөрчлөх 13/ Эдийн засгийн зөвлөл ямар төрлийн аль эрх зүйд хамаарах гомдлын тухай гэдэг нь ойлгомжгүй, хэт бөөрөнхий, мөн эдийн засгийн зөвлөлийн эрх зүйн байдал нь тодорхойгүй, чиг үүргийг нь нарийн тодорхойлсон хууль байхгүй байгаа хэр нь гомдол урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг Эдийн засгийн зөвлөлд олгосон. “10.3.3.аж ахуй эрхлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүнд суртал, хууль бус үйл ажиллагаатай холбоотой гомдол, саналыг шуурхай шийдвэрлэх болон шүүх, олон улсын арбитрын байгууллагад Монгол Улсын Засгийн газрыг хариуцагчаар татагдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тэдгээрээс ирүүлсэн гомдлыг урьдчилан хэлэлцэх, зөвлөмж, чиглэл гаргах.” гэсэн заалтад “Аж ахуй эрхлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүнд суртал, хууль бус үйл ажиллагаатай холбоотой гомдол, саналыг урьдчилан шийдвэрлэх процесс журам”, “Эдийн засгийн зөвлөлийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, журмыг” нэмэх. 14/ Заалт нэмэх санал: 1.Энэхүү хууль нь зөвхөн Иргэний хууль бус бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулсан бусад хуультай уялдаж хэрэгжих тул тус заалтад дараах өөрчлөлтийг оруулах. “2.1. Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.” 2.Мөн хууль хооронд зөрчил үүссэн тохиолдолд аж ахуйн эрхлэгчид таатай нөхцөл олгосон энэ хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөх агуулгыг тусгах. 2.2.“Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулна. Хэрэв тухайлсан хууль болон энэхүү хууль	Саналыг тусгаж, хуулийн төсөлд Эдийн засгийн бодлогын зөвлөлийн чиг үүргийг тодорхой болгосон. Зөвлөлийн “Монгол Улсын Засгийн газрыг хариуцагчаар татагдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тэдгээрээс ирүүлсэн гомдлыг урьдчилан хэлэлцэх, зөвлөмж, чиглэл гаргах” гэснийг хассан.	
	1.Саналыг агуулгын хувьд тусгасан. 2.Энэ хуулиар баталгаажуулсан эрх чөлөөг Хуулийн төслийн 3.2-т “Төрийн байгууллага, албан тушаалтнаас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны акт, хэм хэмжээ батлах, хэрэгжүүлэхэд энэ хуулийг дагаж мөрдөнө.” хэсэг нэмсэн.		

	хоорондоо зөрчилдсөн тохиолдолд энэхүү хууль давуу хүчинтэй үйлчилнэ.” гэсэн заалт нэмэх	
	15/ Практикт хууль тогтоомжийн төсөлд бизнесийн байгууллагуудаас олон тооны санал авдаг боловч саналыг харгалзан үзэж, хуулийн төсөлд тусгасан байдал хангалтгүй байдаг. Иймд хуулийн төсөлд өгсөн саналыг харгалзан үзэх агуулгыг нэмж тусгах. “6.1.4. эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж, хориглосон хууль тогтоомжийг батлахын өмнө хууль тогтоомжийн төслийг бүрдүүлбэрийн хамт Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo)-д хуанлийн 90 хоногоос доошгүй хугацаанд нээлттэй байршуулж, олон нийтээс санал авч, үндэслэл бүхий саналыг хууль тогтоомжийн төсөлд тусгах бөгөөд тусгаагүй тохиолдолд үндэслэл, шалтгааныг санал өгсөн иргэн, хуулийн этгээдэд тайлбарлана,” гэж өөрчлөх 16/ Тус заалт нь хуулийн төслийн 4.1.7-д заасан үндэсний үйлдвэрлэгчийг хамгаалах зорилгоор шийдвэр гаргах боломжийг хязгаарлах үр дагавартай тул хасах. 16/“5.1.4.төрөөс зарим аж ахуйн нэгжид давуу эрх олгосон хууль тогтоомж гаргах, захиргааны шийдвэр, үйл ажиллагаа явуулахгүй байх,” гэсэн заалтыг хасах	Саналыг тусгасан.
	Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: 1/ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 18.1 дэх заалтад “хуулийн 9.3-т заасан зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн тогтворжуулах гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ” гэж заасан. Дагалдах хуулийн төслөөр хуулийн 18-р зүйлийг хөндөөгүй байх бөгөөд гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй этгээд гомдлын нэг тал болж болох хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох үндэслэл болох дүгнэлт гаргах нь зохимжгүй юм. Тодруулбал, гомдол хянан шийдвэрлэх эрх бүхий этгээд хөндлөнгийн, хараат бус байх төдийгүй маргааны аль нэг талд давуу байдал үүсгэж болохуйц бичиг баримт гаргах чиг үүргийг хэрэгжүүлэх нь өөрийнхөө олгодог эрх зүйн баримт бичгийг хянах болох юм.	Саналыг тусгасан. Тус зохицуулалтыг өөрчлөн найруулж, тодорхой болгосон.

	Иймд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 18.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах: “18.1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлт, холбогдох бичиг баримтыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуульд заасан шалгуурыг үндэслэн тогтворжуулах гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв шаардлагатай гэж үзвэл хугацааг 15 хоногоор сунгаж болно.”	
3. Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (2025.10.02 01/990)	Үргэлжлэл. Бизнес эрхлэгчдийн санал: Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд: 1/ Энэхүү хууль нь зөвхөн Иргэний хууль бус бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулсан бусад хуультай уялдаж хэрэгжих тул тус заалтад холбогдох өөрчлөлтийг оруулах. Хуулийн 2.1. дэх заалтыг “Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.” гэж өөрчлөх. 2/ Хууль хооронд зөрчил үүссэн тохиолдолд аж ахуйн эрхлэгчид таатай нөхцөл олгосон энэ хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөх агуулгыг тусгах. “Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулна. Хэрэв тухайлсан хууль болон энэхүү хууль хоорондоо зөрчилдсөн тохиолдолд энэхүү хууль давуу хүчинтэй үйлчилнэ.” гэсэн заалт нэмэх. 3/ Практикт хууль тогтоомжийн төсөлд бизнесийн байгууллагуудаас олон тооны санал авдаг боловч саналыг харгалзан үзэж, хуулийн төсөлд тусгасан байдал хангалтгүй байдаг. Иймд хуулийн төсөлд өгсөн саналыг харгалзан үзэх агуулгыг нэмж тусгах.	Саналыг агуулгын хувьд тусгасан. Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Мөн Монгол Улсын хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн актын хэм хэмжээ нь энэ хуулиар баталгаажуулсан эдийн засгийн эрх чөлөөг хангах хэм хэмжээг дордуулахыг хориглоно гэж туссан. Энэ хэсгийг бусад газруудаас ирсэн саналын дагуу хассан. Хуулийн давуу хүчинтэй байдлыг хангах зорилгоор хуулийн төслийн 2.3-т “Монгол Улсын хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн актын хэм хэмжээ нь энэ хуулиар баталгаажуулсан эдийн засгийн эрх чөлөөг хангах хэм хэмжээг дордуулахыг хориглоно” гэж туссан. Хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан

	Хуулийн 6.1.4. дэх заалтыг “эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж, хориглосон хууль тогтоомжийг батлахын өмнө хууль тогтоомжийн төслийг бүрдүүлбэрийн хамт Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo)-д хуанлийн 90 хоногоос доошгүй хугацаанд нээлттэй байршуулж, олон нийтээс санал авч, үндэслэл бүхий саналыг хууль тогтоомжийн төсөлд тусгах бөгөөд тусгаагүй тохиолдолд үндэслэл, шалтгааныг санал өгсөн иргэн, хуулийн этгээдэд тайлбарлана.” гэж өөрчлөх. 4/ Тус заалт нь хуулийн төслийн 4.1.7-д заасан үндэсний үйлдвэрлэгчийг хамгаалах зорилгоор шийдвэр гаргах боломжийг хязгаарлах үр дагавартай тул хасах. Хуулийн “5.1.4. төрөөс зарим аж ахуйн нэгжид давуу эрх олгосон хууль тогтоомж гаргах, захиргааны шийдвэр, үйл ажиллагаа явуулахгүй байх” гэсэн заалтыг хасах. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: Төслийн 7^{1.4}-т зааснаар хөрөнгө оруулагчид заавал Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлд хандах үр дагавар үүсэж болзошгүй байна. Зөвлөл нь хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх явцад зайлшгүй хандах шаардлагатай шат дамжлага болох ёсгүй бөгөөд практикт тус заалтыг заавал хэрэгжихээр тайлбарлаж, гажуудуулах эрсдэлтэй тул заалтад тодруулга нэмэх 5/ “7^{1.4}. Хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 3.1.14-т заасан төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тухай гомдлыг Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлд гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй. Энэхүү заалт нь хөрөнгө оруулагчийн маргаан шийдвэрлэх байгууллагад шууд хандах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.” гэж өөрчлөх 6/ Тус заалтад Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулахаар заасан нь хөрөнгө оруулагч, төрийн хооронд үүссэн маргааныг хараат бусаар шийдвэрлэх нөхцөлийг хязгаарлаж байна.	Саналыг тусгасан. Тус заалтыг хассан.
	Саналыг агуулгын хувьд тусгасан. Зохицуулалтыг тодорхой болгосон.	
	Энэ хэсгийг хуулийн төслөөс хассан тул тусгах шаардлагагүй.	

	Иймд маргааны талууд харилцан тохиролцож шинжээч томилохоор тусгах. “7.4. Гомдлыг шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, нарийн мэргэжил, ур чадвар зэрэг тусгай мэдлэг шаардагдах тохиолдолд талууд харилцан тохиролцож Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулж болно.”	
	7/ Хөрөнгө оруулалтын гомдол шийдвэрлэх хугацаа урт байх тусмаа хөрөнгийн оруулагчийн хүлээх санхүүгийн хохирол, алдагдал нэмэгдэх эрсдэл учирдаг. Иймд энэхүү эрсдэлийг бууруулах, эрсдэл учирсан тохиолдолд хөрөнгө оруулагчийн хохирлыг барагдуулах дараах зохицуулалтыг төсөлд нэмж тусгах. “Гомдол шийдвэрлэх хугацааг үндэслэлгүйгээр хоцроосон, эс үйлдэхүй гаргасны улмаас хөрөнгө оруулагчид алдагдал учирсан тохиолдолд учирсан алдагдал, хохирлыг төр барагдуулна.”	Гомдол хянах хугацааг 30 хоног байхаар заасан. Зөвлөлөөс гарсан саналыг холбогдох байгууллага биелүүлэх, хэрэгжилтийн талаар мэдэгдэх талаар зохицуулалт тусгасан.
	8/Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, хөрөнгө оруулалтыг татах, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд дараах “Төрөөс хөрөнгө оруулалтын талаар баримтлах зарчим”-ыг хуулийн төсөлд шинээр тусгах “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд төрөөс Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална: • Хөрөнгө оруулагчийг үл ялгаварлан гадуурхах; • Хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандах; • Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах; • Тогтвортой хөгжлийг хангах; • Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах.”	Одоогийн хуулиар тус асуудлыг зохицуулсан бөгөөд баталгаатай холбоотой заалтуудыг сайжруулсан. Саналыг агуулгын хувьд тусгасан.
	9/ Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаанд ЭЗХЯ-аас Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой Дэлхийн банкны Doing Business-2020, МҮХАҮТ-ын Монголын бизнесийн орчны үнэлгээ-2023, Economist Intelligence Unit, Дэлхийн эдийн засгийн форумын Өрсөлдөх чадварын индекс	Саналыг тусгасан. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хөрөнгийг хууль бусаар шууд

	тайлангуудад дурдсан үнэлгээнд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх шаардлагатай нэгдсэн арга хэмжээнүүдийг тодорхойлсон. Үүний нэг нь хөрөнгө дайчлан авах нөхцөл, хохирлыг барагдуулах харилцааг тодорхой зохицуулах гэсэн байна. Түүнчлэн хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль ёсоор албадан хураан авахтай холбоотой нэгдсэн зарчмыг тодорхойлоогүй нь төрийн байгууллагаас гаргах шийдвэр нь дураар аашлах нөхцөл байдлыг бий болгох эрсдэлтэй гэжээ. Иймд хөрөнгө оруулалтын тухай хуульд үл ялгаварлан гадуурхах зарчмыг тодорхой тусгах. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хураан авахад (i) нийтийн ашиг сонирхлын үүднээс (ii) хуульд заасан журмын дагуу (iii) үл ялгаварлах зарчмын хүрээнд (iv) зах зээлийн үнэлгээ бүхий нөхөн төлбөртэйгөөр хураан авах зарчим үйлчилдэг. Иймд, уг заалтад “<u>үл ялгаварлах зарчмыг</u>” нэмж тусган дараах байдлаар өөрчлөн найруулах: “6.4. хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно.”	болон шууд бус хэлбэрээр хураан авахыг хориглох, нөхөх олговрын талаарх зохицуулалтыг олон улсын стандарт, зарчимд нийцүүлж нэмсэн.
	10/ Хуулийн төслийн 5.1.6-д “үйлдвэр, машин, тоног төхөөрөмж, техник, технологи дамжуулалт, барилга байгууламж зэрэг үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулах; 5.1.7-д “хөрөнгө оруулагчаас өөрийн хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн хувьцаанд хөрвөх зээл олгох” зэрэг хөрөнгө оруулалтын хэлбэрийг шинээр тусгасан. Одоогийн хуульд “хувь нийлүүлсэн хөрөнгө”-д хөрөнгө оруулсныг <u>хөрөнгө оруулалт</u> гэж тооцохоор байгаа нь хуульд заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах; санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх; болон хуулийн төсөлд заасан дээрх зохицуулалттай зөрчилдөж байна.	Үйлдвэр, машин, тоног төхөөрөмж, техник, технологи дамжуулалт зэрэг үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулах нь хөрөнгө оруулалтын 1 хэлбэр байхаар заасан. Харин энэхүү хөрөнгө оруулалтаа компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тооцуулан, хувьцаа эзэмших нь хөрөнгө оруулагчийн хувьд нээлттэй. Төр, хувийн хэвшлийн түншлэл, бүтээгдэхүүн хуваах гэрээ нь Хөрөнгө оруулалтын тухай хууль болон олон улсын эрх зүйд хөрөнгө оруулалтын гэрээний төрөлд тооцогдож хөрөнгө оруулалт нь хамгаалагддаг.

	Хөрөнгө оруулалтыг зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрөнгө оруулах байдлаар хязгаарлах нь улсын бүртгэлд тухай бүр бүртгүүлэх хүндрэлтэй байдлыг үүсгэдэг. Цаашлаад төслийн санхүүжилт зэрэг бусад хэлбэрээр хийх хөрөнгө оруулалтыг үгүйсгэдэг, татварын хувьд маргаан дагуулдаг заалт юм. Иймд тус заалтыг өөрчлөн найруулах. 11/ Уг заалтын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагын хүрээнд зөвхөн хуулийн этгээд байгуулах замаар хөрөнгө оруулалт хийх боломжоор хязгаарлаж, хувь хүн өөрөө хөрөнгө оруулагч байх боломжийг үгүйсгэсэн байна. Иймд хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулахаас бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэлбэрүүдтэй уялдуулан өөрчлөн найруулах. “3.4. Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.”	Хөрөнгө оруулалтын тухай хуульд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулан заасан. Хувь хүн хувьцаа эзэмшигчээр бүртгүүлснээр компанийн хөрөнгө оруулагч болно. Хувьцааг мөнгөн хөрөнгө, өөр бусад хэлбэрээр оруулах боломжтой. Иймд саналыг тусгаагүй.
4.	Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим-санал 2 (2025.11.07 01/1040) Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуульд: 1/төслийн 5.1.2-т “хөрөнгө оруулагч” гэсний өмнө “гадаад болон дотоодын” гэж нэмэх. 2/төслийн 5.1.4-т “...нэгжид” гэснийг “нэгж, төрийн өмчит хуулийн этгээдэд” гэж өөрчлөх 3/төслийн 5.1.6 “хөрөнгө оруулагч” гэсний өмнө “гадаад болон дотоодын” гэж тодотгох 4/төслийн 5.1.15 “...холбогдох этгээдэд” гэснийг “төрийн байгууллага, албан хаагчид, төрийн өмчит хуулийн этгээд” гэж тодотгох. 5/төслийн 5.4 “...нөхөн олговортойгоор” гэсний дараа “зөвшилцсөний үндсэн дээр” гэж нэмэх.	Тус асуудал нь одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй. Саналыг агуулгын хувьд тусгасан. Тус асуудал нь одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй. Саналыг агуулгын хувьд тусгасан. Саналыг тусгасан. Хөрөнгийг хууль бусаар хураан авахгүй байх болон хураан авах тохиолдолд төлөх нөхөх олговрын талаар тусгасан.

	6/төслийн 5-р зүйлд хууль тогтоомжийн хүрээнд төрөөс иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой хамаарах асуудлын хүрээнд гаргасан шийдвэрийг төрийн өмчит хуулийн этгээд биелүүлэхээс татгалзах эрхгүй байх гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	Саналыг агуулгын хувьд тусгасан.
	7/төслийн 5-р зүйлд "Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой төр, захиргааны байгууллага дангаар шийдвэрлэх боломжгүй асуудлыг холбогдох харьяаллын эрх бүхий байгууллагуудтай зөвшилцөн хамтран шийдвэрлэнэ" гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	Саналыг тусгаагүй.
	8/төслийн 5-р зүйлд "Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ хяналт шалгалт явуулж буй байгууллагууд харилцан уялдаа холбоотой ажиллаж, шалгалтын хугацаа давхцахгүй байх бөгөөд иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулна" гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	Саналыг агуулгын хувьд тусгасан.
	9/төслийн 4.1.8 "хөрөнгө оруулагч" гэсний өмнө "гадаад болон дотоодын" гэж нэмэх	Тус асуудал нь одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй.
	10/төслийн 4-р зүйлд "иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжсэн төр, захиргааны байгууллагын шийдвэр нь үйл ажиллагааныхаа үндсэн бодлого, чиг үүрэгт нийцсэн байх" гэсэн агуулга бүхий заалт нэмэх	Саналыг агуулгын хувьд тусгасан. Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эдийн засгийн эрх чөлөөний баталгааг хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцохгүй, хохирол, саад учруулахгүй байхад чиглэнэ.
	11/төслийн 4-р зүйлд "иргэн, хуулийн этгээдийн бизнес, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, гэм хор учруулсан бол нөхөн сэргээх" гэсэн заалт нэмэх	Саналыг агуулгын хувьд тусгасан.
	12/төслийн 9-р зүйлд "хууль тогтоомжийн хэрэгжилтийг /эрх олгосон, зөвшөөрсөн/ хангуулахаар төр, захиргааны байгууллагад гаргасан иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг төр, захиргааны	Саналыг тусгаагүй.

		байгууллага шийдвэрлээгүй нь иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй” гэсэн заалт нэмэх	
Мэргэжлийн холбоод (Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Европ Монголын Хамтарсан Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Бизнесийн Зөвлөл, Улаанбаатар Хотын Худалдааны Танхим, Монгол дахь Австралийн Худалдааны Танхим) (2025.12.03 43/03)	Мэргэжлийн холбоод (Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Европ Монголын Хамтарсан Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Бизнесийн Зөвлөл, Улаанбаатар Хотын Худалдааны Танхим, Монгол дахь Австралийн Худалдааны Танхим) (2025.12.03 43/03)	байгууллага шийдвэрлээгүй нь иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй” гэсэн заалт нэмэх Эдийн засгийн эрх чөлөөний хуулийн төсөлд: 1/ төслийн 1.1 “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс баримтлах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, төрийн байгуулалтын хүлээх үүргийг тодорхойлж, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлээр иргэний хувийн аж ахуй эрхлэх эрх, түүнээсээ үр шим хүртэх эрх, эрх чөлөөг эдийн засаг, нийгэм, эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьжиргааны чанар, түвшинг дээшлүүлэхэд оршино.” гэж өөрчлөх 2/ төслийн 2.1. “Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.” гэж өөрчлөх 3/ төслийн 3.3. “Иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой энэ хуулиар тогтоосон зарчим, зохицуулалтыг дордуулсан хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөхгүй.” гэж өөрчлөх 4/ төслийн 4.1.1. “төр хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх, баталгаажуулах, мөн төрийн оролцоог болзолт тоо, хэмжээгээр бууруулах” гэж өөрчлөх 5/ төслийн 4.1.3. “шүүхийн шийдвэр гарснаас бусад тохиолдолд хувийн өмч, аж ахуйн үйл ажиллагаа, алдар хүнд, нэр төрийн халдашгүй байдлыг хангах” гэж өөрчлөх 6/ төслийн 4.1.-т “Энэ хуулийн 3.2-т заасан болон Үндэсний аюулгүй байдлыг хангаатай холбоотой чиглэлээс бусад чиглэлийн аж ахуйн үйл ажиллагааг төр, төрийн өмчит байгууллагууд эрхлэхгүй” гэсэн заалт нэмэх	Эдийн засгийн эрх чөлөөний тухай болон дагалдах хуулийн хуулийн төслийн зорилго нь аж ахуйн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх орчныг таатай орчныг бүрдүүлж, тогтвортой байдлыг хангахад бүхэлдээ чиглэсэн тус саналыг тусгаагүй. Саналыг агуулгын хувьд тусгасан. Заалтыг өөрчлөн найруулсан. Саналыг агуулгын хувьд тусгасан. Хуулийн төслийн 2.3-т хэм хэмжээний актыг эрэмбэлж, хэм хэмжээ тогтоосон акт зөрчилдвөл аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдэд давуу байхаар зохицуулсан. Саналыг агуулгын хувьд тусгасан. Саналыг агуулгын хувьд тусгасан. 3.2 дахь заалтыг хассан.

	7/ төслийн 4-р зүйлд “Төр бодлого боловсруулах, хууль тогтоох, эдгээрийн хэрэгжилтийг хангах бүхий л үйл ажиллагаандаа энэ хуулийн 4.1-д заасан зарчмуудыг баримтлана” гэсэн заалт нэмэх	Саналыг агуулгын хувьд тусгасан.
	8/ төслийн 5.1.13. “төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бүрт албан тушаалтан нь хуульчлан заагаагүй нөхцөлд удирдамжгүй хяналт шалгалт хэрэгжүүлэх, хяналт хийх албан тушаалтан нь хуульд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд аж ахуй эрхлэгч нь татгалзах эрхтэй байна” гэж өөрчлөх	Саналыг агуулгын хувьд тусгасан.
	9/ төслийн 5.1.15. “төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид хохирол учруулсан тохиолдолд хуульд заасан хариуцлагыг ногдуулах, холбогдох төрийн байгууллагаар хохирлыг нөхөн төлүүлэх” гэж өөрчлөх	Саналыг тусгах шаардлагагүй. 6.4-т төрийн байгууллага, албан тушаалтанд хууль бус шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйн улмаас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид хохирол учирсан хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгасан.
	10/ төслийн 5.3-т “Дор дурдсан нөхцөлүүд бүрэн бүрдсэнээс бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн аливаа өмч хөрөнгийг дайчлан авах, данс битүүмжлэх болон түүнтэй төстэй арга хэмжээ авахгүй: • нийгмийн зайлшгүй хэрэгцээний төлөө; • үл ялгаварлах зарчмын дагуу; • хууль заасан журмын дагуу; • шударга нөхөн олговортойгоор” гэсэн заалт нэмэх	Саналыг агуулгын хувьд тусгасан. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нарийвчлан зохицуулсан.
	11/ төслийн 5.4. “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэйгээс бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эд хөрөнгийг хураан авч болохгүй. Хуульд заасан тохиолдолд улсын хэрэгцээнд зориулан эд хөрөнгийг түүнтэй адилтгах нөхөн олговортойгоор дайчлан авч болно” гэж өөрчлөх	Хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан.
	12/ төслийн 5-р зүйлд “Төр нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн богино, дунд, урт хугацааны бодлого, зорилтыг эдийн засгийн эрх чөлөөний зарчим болон энэхүү хуультай нийцүүлэн боловсруулна” гэсэн заалт нэмэх	Саналыг агуулгын хувьд тусгасан.
	13/ төслийн 6.1.1. “аж ахуйн үйл ажиллагааны талаар батлах хууль тогтоомж, шийдвэр нь үр нөлөөний үнэлгээ дээр суурилсан, тоон баримттай, үндэслэл бүхий, тодорхой байх; батлагдсан хууль	Саналыг агуулгын хувьд тусгасан. Зохицуулалтыг сайжруулсан.

	тогтоомж, шийдвэрийн талаарх мэдээлэл, ил тод нээлттэй байх” гэж өөрчлөх 14/ төслийн 6.1.2.-т “Шинээр нэмэгдэж буй төрийн зохицууллагууд тодорхой хугацаанд хүчинтэй байгаад, заасан хугацааны дараа автоматаар цуцлагдах зарчмыг нэвтрүүлэх” гэсэн заалт нэмэх 15/ төслийн 6.1.4. “Дараах нөхцөлийг бүрэн хангаснаас бусад тохиолдолд эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж, хориглосон хууль тогтоомж батлах, аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах татвар нэмэгдүүлэхийг хориглоно: 6.1.4.1. Хууль тогтоомжийн төслийг бүрдүүлбэрийн хамт Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo)-д хуанлийн 90 хоногоос доошгүй хугацаанд нээлттэй байршуулж, олон нийтээс санал авах; 6.1.4.2. Хууль тогтоомж, шийдвэрийн төслийг боловсруулах шатанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан олон нийтийн хэлэлцүүлгийг 3-аас доошгүй удаа зохион байгуулах; 6.1.4.3. Хууль тогтоомжийн төслийг Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу нийтийн сонсгол зохион байгуулах” гэж өөрчлөх 16/ төслийн 6.1.-т “эдийн засгийн эрх, эрх чөлөөг дэмжих нийгмийн болон үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлогын зарчмуудыг болон тэдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын үүргийг тодорхойлох” гэсэн заалт нэмэх 17/ төслийн 7.1 “Төр өөрт хамаарах дараах зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид сонгон шалгаруулалт зохион байгуулах журмаар олон нийтэд нээлттэй шилжүүлж болно” гэж өөрчлөх 18/ төслийн 7.1.3. “Дэд бүтцийн үйлчилгээ: Зам, гүүр, ус, эрчим хүч, цахилгаан, харилцаа болон цахилгаан холбоо зэрэг дэд бүтэц, үйлчилгээ болон төслийн хөгжүүлэлт, засвар үйлчилгээ” гэж өөрчлөх	Энэ заалтыг хассан тул тусгаагүй. Агуулгын хувьд туссан. Хууль тогтоомжийн хуульд зохицуулсан байна. Энэ заалтыг хассан тул тусгаагүй. Энэ заалтыг хассан тул тусгаагүй. Энэ заалтыг хассан тул тусгаагүй.
--	--	---

	19/ төслийн 7.1.4. “Нийтийн үйлчилгээ: Хог хаягдлын менежмент, ус, бохир усны үйлчилгээ, тэдгээрийн менежмент, дулаан болон хий хангамж, цэвэрлэгээ, нийтийн тээвэр” гэж өөрчлөх	Энэ заалтыг хассан тул тусгаагүй.
	20/ төслийн 7.1.1-т “хуулийн этгээдийн улсын бүртгэл” гэсэн заалт нэмэх	Энэ заалтыг хассан тул тусгаагүй.
	21/ төслийн 7.1.1-т “гэрээгээр шилжүүлэх чиг үүрэг, үйл ажиллагааны жагсаалтыг Засгийн газраас батлан хэрэгжүүлнэ” гэсэн заалт нэмэх	Тусгах шаардлагагүй.
	22/ төслийн 7.3. “Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зорилгоор 1 жилээс дээш хугацаагаар ашиглалтгүй байгаа төрийн өмчийн эд хөрөнгийг тодорхой нөхцөл, журмын дагуу эзэмшүүлэх, ашиглуулж болох ба эдгээр ашиглалтгүй байгаа эд хөрөнгийн мэдээллийг нийтэд ил тод байршуулна. Энэхүү журмыг холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас батална” гэж өөрчлөх	Энэ хэсгийг бусад газраас ирүүлсэн саналын дагуу хассан.
	23/ төслийн 7.4. “Төр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалтын давхардлыг арилгах, улсын бүртгэл, зөвшөөрөл, татварын тогтолцоог боловсронгуй болгох санал, хүсэлтийг хувийн хэвшлийн төлөөлүүдээс жилд 1-ээс доошгүй удаа хүлээн авч шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх	Агуулгын хувьд тусгасан.
	24/ төслийн 7.5. “Төр бизнес эрхлэгчдэд зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, уулзалтыг зохион байгуулахдаа аж ахуй үйл ажиллагаа эрхлэгчийн оролцоог хангаж, хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ” заалтыг хасах	
	25/ төслийн 7.6. “Төрөөс орон нутагт эдийн засгийн эрх чөлөөт байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоон аргаар үнэлж аймаг, нийслэлийн Засаг дарга нарын жил бүр эрэмбэлж, дүгнэнэ” гэж өөрчлөх	Саналыг тусгасан.
	26/ төслийн 7-р зүйлд “Төр аж ахуй, үйл ажиллагаа эрхлэгчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг болон шийдвэр гаргах эрхийг нь хязгаарлахыг хориглоно. Үүнд: • Аж ахуйн нэгжийн зах зээлийн үнийг зохиомлоор тогтоох; • Түүхий эд, бараа бүтээгдэхүүний нийлүүлэгч, худалдан авагчийг	Саналыг агуулгын хувьд тусгасан.

албадан	сонгох; • Шүүхийн шийдвэргүйгээр гэнэтийн, хууль бус хяналт шалгалт хийх зэрэг үйлдэл хамаарна” гэсэн заалт нэмэх	
27/ төслийн 8.1.1-т “Төр хуулиар нууц байхыг нь заасан мэдээллүүдийн жагсаалтыг (төрийн нууц, хувийн нууц, байгуулалтын нууц) тодорхой олон нийтэд гаргаж, бусад бүх мэдээллийг автоматаар нээлттэй гэж үзэх зарчмыг нэвтрүүлэх” гэсэн заалт нэмэх	Саналыг тусгасан.	
28/ төслийн 8.1.1-т “Төр эдийн засгийн бүх салбаруудын түүхий өгөгдлийг холбогдох яам, төрийн байгууллагууд болон цахимд нээлттэй байршуулах” гэсэн заалт нэмэх	Саналыг тусгасан.	
29/ төслийн 9-р зүйлд “Төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг холбогдох дээд удирдлагад нь эсхүл холбогдох бусад маргаан шийдвэрлэх байгууллагад цаасаар, эсхүл бичгээр гаргах бөгөөд тухайн гомдлыг гомдол хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж гомдол гаргагчид хариу мэдэгдсэн байна” гэсэн заалт нэмэх	Гомдол шийдвэрлэхгүй тул тусгаагүй.	
30/ төслийн 10.1. заалтын “Эдийн засгийн бодлогын зөвлөл”-ийн бүрэн эрх, чиг үүргийг илүү тодорхой болгох, үйл ажиллагааг хуулиар зохицуулах	Журмаар зохицуулахаар хуулийн төсөлд тусгагдсан	
31/ төслийн 10.3.-т “хувийн хэвшлийн төлөөлөлтэй хамтран эдийн засгийн эрх чөлөөний индексийг боловсруулж батлах бөгөөд жил бүр үнэлж тайлан гаргана. Тус тайланг олон нийтэд нээлттэй байршуулж олон нийтээр хэлэлцүүлнэ” гэсэн заалт нэмэх	Энэ хэсгийг бусад байгууллагын саналд үндэслэн хассан.	
32/ төслийн 10.3.3.-т хөрөнгө оруулагчийн гомдлыг ямар зөвлөл шийдвэрлэхийг тодорхой болгож, Эдийн засгийн бодлогын зөвлөл, Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийн чиг үүргийн давхардлыг арилган, захиргааны актын урьдчилан шийдвэрлэх ажиллагаатай зөрчилдөхгүй байх зохицуулалт оруулах	Саналыг тусгаж, өөрчлөн найруулсан.	
33/ төслийн 10-р зүйлд “Эдийн засгийн бодлогын зөвлөлийн нийт гишүүдийн 50-аас доошгүй хувь нь аж ахуй эрхлэгчид болон түүний төлөөллийн байгууллагууд байна” гэсэн заалт нэмэх	Саналыг тусгасан.	

	34/ төслийн 10-р зүйлд “Эдийн засгийн бодлогын зөвлөлийн ажиллах журам, гишүүдийг сонгох, ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэсэн заалт нэмэх	Саналыг тусгасан.
	35/ төслийн 11-р зүйлд “Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн буруутай үйлдлээс болж аж ахуй эрхлэгчид хохирол учирсан бол хохирлын хэмжээг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэн буруутай албан хаагчаар төлүүлнэ” гэсэн заалт нэмэх	Агуулгын хувьд туссан.
	Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: 1/ төслийн 7 ¹ . 1.-т “Энэхүү заалт нь хөрөнгө оруулагчийн маргаан шийдвэрлэх байгууллагад шууд хандах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.” гэсэн тодруулга нэмэх 2/ төслийн “7 ¹ . 4. “Гомдлыг шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, нарийн мэргэжил, ур чадвар зэрэг тусгай мэдлэг шаарддаг тохиолдолд талууд харилцан тохиролцож Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэргэжсэн шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулж болно.” гэж өөрчлөх	Тусгах шаардлагагүй.
	3/төслийн 7 ¹ .6.-т “71.6.1. Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл нь гомдлыг хэлэлцээд ямар шийдвэр, зөвлөмж гаргасан, түүнийг дээд шатны байгууллага, албан тушаалтан хэрхэн хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчид болон олон нийтэд ил тод мэдээлэх механизмыг тодорхой болгох.” гэсэн заалт нэмэх	Гомдол шийдвэрлэх процессыг журмаар зохицуулахаар заасан тул тусгаагүй.
	4/төслийн 7 ¹ .7. заалтын “шаардлагатай тохиолдол” гэснийг тодотгож, ямар нөхцөл байдлуудыг шаардлагатай тохиолдол хэмээн үзэж байгааг хуульчлан өгөх	Саналыг тусгасан.
	5/ төслийн 7 ¹ .8.-т “Гомдол шийдвэрлэх хугацааг үндэслэлгүйгээр хоцроосон, эс үйлдэхүй гаргасны улмаас хөрөнгө оруулагчид алдагдал учирсан тохиолдолд учирсан алдагдал, хохирлыг төр барагдуулна.” гэж нэмэх	Тусгах шаардлагагүй.
		Тусгах шаардлагагүй. Зөвлөл нь хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл бөгөөд хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг шүүхийн өмнөх шатанд хянан үзсэний үндсэн дээр холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлэх чиг үүрэгтэй. Зөвлөлд хандах нь шүүх, арбитрт нэмэмжлэл, хүсэлт гаргахад саад болохгүй.

	6/төслийн 8^{1.2}-т Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг Засгийн газар батална гэж заасан нь хэт ерөнхий байдлаар томъёологдсон байгаа тул тус зөвлөл нь хэдэн хүний бүрэлдэхүүнтэй, бүрэлдэхүүнд ямар талуудын төлөөллийг оролцуулах, ямар шалгуураар, хэдий хугацаанд томилогдон ажиллах зэрэг үндсэн мэдээллийг хуульд нарийвчлан оруулах 7/хуульд “Энэ хуулийг хэрэгжүүлэхдээ төрөөс Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална: • Хөрөнгө оруулагчийн үл ялгаварлан гадуурхах; • Хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандах; • Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах; • Тогтвортой хөгжлийг хангах; • Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах.” гэж нэмэх	Журмаар зохицуулахаар тусгасан.
	• Хөрөнгө оруулагчийн үл ялгаварлан гадуурхах; • Хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандах; • Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах; • Тогтвортой хөгжлийг хангах; • Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах.” гэж нэмэх	Тусгах шаардлагагүй.
	8/ төслийн 6.4. “хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нехэн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно” гэж өөрчлөх	Саналыг тусгасан.
	9/ төслийн 3.1.1. “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;” гэж өөрчлөх	Хөрөнгө оруулалтын тухай хуульд хувь нийлүүлсэн хөрөнгө оруулсан, санхүүгийн тайланд туссан хөрөнгийг хөрөнгө оруулалтад тооцохоор заасан бөгөөд хөрөнгө оруулалтын хэлбэрийг 5.1-т заасан хэлбэрээр хийж болно. Иймд саналыг тусгаагүй.
	10/ төслийн 3.4. “Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.” гэж өөрчлөх	Тусгах шаардлагагүй
	11/ төслийн 7 ^{1.2} -т “Хөрөнгө оруулагч, иргэн, хуулийн этгээдийн аж ахуй эрхлэгчидтэй холбоотой гомдлыг Эдийн засгийн бодлогын зөвлөл ил тод, нээлттэй хэлэлцэн, шаардлагатай гэж үзвэл гомдол гаргасан этгээдийг сонсож шийдвэрлэнэ” гэж заасныг эдгээр гомдлыг Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлд шилжүүлэх зохицуулалтаар тодруулах	Чиг үүргийн хувьд эрхлэх асуудал өөр тул тусгаагүй.

6.	Монцемент билдинг материалс ХХК (2025.10.31 3а/134а)	Эдийн засгийн эрх чөлөөний хуулийн төсөлд: 1/төслийн 5.1.2 "...хөрөнгө оруулагч" гэсний өмнө "гадаад болон дотоодын" гэж нэмэх	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй.
		2/төслийн 5.1.4-т "...нэгжид" гэснийг "нэгж, төрийн өмчит хуулийн этгээдэд" гэж өөрчлөх	Энэ заалтыг хассан тул тусгах шаардлагагүй.
		3/төслийн 5.1.6 "хөрөнгө оруулагч" гэсний өмнө "гадаад болон дотоодын" гэж тодотгох	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй.
		4/төслийн 5.1.15 "...холбогдох этгээдэд" гэснийг "төрийн байгууллага, албан хаагчид, төрийн өмчит хуулийн этгээд" гэж тодотгох.	Тус заалтыг хассан.
		5/төслийн 5.4 "...нөхөн олговортойгоор" гэсний дараа "зөвшилцсөний үндсэн дээр" гэж нэмэх.	Саналыг тусгасан. Хөрөнгийг хууль бусаар хураан авахгүй байх болон хураан авах тохиолдолд төлөх нөхөх олговрын талаар тусгасан.
		6/төслийн 5-р зүйлд хууль тогтоомжийн хүрээнд төрөөс иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой хамаарах асуудлын хүрээнд гаргасан шийдвэрийг төрийн өмчит хуулийн этгээд биелүүлэхээс татгалзах эрхгүй байх гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	Агуулгын хувьд тусгасан.
		7/төслийн 5-р зүйлд "Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой төр, захиргааны байгууллага дангаар шийдвэрлэх боломжгүй асуудлыг холбогдох харьяаллын эрх бүхий байгууллагуудтай зөвшилцөн хамтран шийдвэрлэнэ" гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	Энэ заалтыг хассан тул тусгах шаардлагагүй.
		8/төслийн 5-р зүйлд "Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ хяналт шалгалт явуулж буй байгууллагууд харилцан уялдаа холбоотой ажиллаж, шалгалтын хугацаа давхцахгүй байх бөгөөд иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулна" гэсэн агуулга бүхий заалт нэмэх.	Агуулгын хувьд тусгасан.

	9/төслийн 4.1.8 “хөрөнгө оруулагч” гэсний өмнө “гадаад болон дотоодын” гэж нэмэх	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй. Агуулгын хувьд туссан.
	10/төслийн 4-р зүйлд “иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжсэн төр, захиргааны байгууллагын шийдвэр нь үйл ажиллагааныхаа үндсэн бодлого, чиг үүрэгт нийцсэн байх” гэсэн агуулга бүхий заалт нэмэх	Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эдийн засгийн эрх чөлөөний баталгааг хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцохгүй, хохирол, саад учруулахгүй байхад чиглэнэ.
	11/төслийн 4-р зүйлд “иргэн, хуулийн этгээдийн бизнес, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, гэм хор учруулсан бол нөхөн сэргээх” гэсэн заалт нэмэх	Агуулгын хувьд туссан. Хуулийн төслийн 7.6-д аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг доромжлох, гүтгэх, бие махбодод халдах, эд хөрөнгийг сүйтгэх, нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараахыг хориглоно.
	12/төслийн 9-р зүйлд “хууль тогтоомжийн хэрэгжилтийг /эрх олгосон, зөвшөөрсөн/ хангуулахаар төр, захиргааны байгууллагад гаргасан иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг төр, захиргааны байгууллага шийдвэрлээгүй нь иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй” гэсэн заалт нэмэх.	Тусгах боломжгүй.
7. Монполимет ХХК (2025.11.17 1/284)	Эдийн засгийн эрх чөлөөний хуулийн төсөлд: 1/4.1.4.-ийг “Эдийн засгийн эрх чөлөөг дэмжсэн төрийн бодлого, эрх зүйн орны тогтвортой байдал, тэдгээрийн баталгаатай хэрэгжих нөхцөлийг хангах” гэж найруулах	Агуулгын хувьд тусгасан.
	2/ 4.1.2-ын “хангах” гэсний дараа “хөндөгдсөн эрхийг сэргээх, гэж нэмэх	Энэ заалт хасагдсан тул тусгаагүй.
	3/ 4.1.8-ын “хамгаалах” гэсний дараа “хөндөгдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх” гэж нэмэх	Энэ заалт хасагдсан тул тусгаагүй.

	4/ 5.1.1-н “батлахгүй байх” гэсний дараа “хууль бус шийдвэрийг хүчингүй болгох” гэж нэмэх	Агуулгын хувьд тусгасан.
	5/5.1.2-н “хөрөнгө оруулагч” гэсний өмнө “гадаад болон дотоодын” гэж нэмэх, “хамгаалахад” гэснийг “хамгаалах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд чиглэсэн байх” гэж өөрчлөх	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй.
	6/ 5.1.4-н “нэгжид” гэснийг “нэгж, төрийн өмчит хуулийн этгээдэд” гэж өөрчлөх	
	7/5.1.6-н “хөрөнгө оруулагч” гэсний өмнө “гадаад болон дотоодын” гэж нэмэх	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй.
	8/ 5.1.6-н “болгох” гэсний дараа “, ийнхүү хууль бус шийдвэрийн улмаас хөндөгдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх” гэж нэмэх	Энэ агуулгыг хуулийн төслөөс хассан тул тусгаагүй.
	9/ 5.1.16.Хууль тогтоомжоор хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид татвар, хураамж, торгууль, алдангиас чөлөөлөх эсхүл дэмжих хэлбэрээр олгогдсон эрх, боломжийг баталгаатай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх” гэж шинэ заалт нэмэх	Тусгаагүй
	10/ 5.1.15. “холбогдох” гэсний дараа “төрийн байгууллага, албан хаагчид, төрийн өмчит хуулийн этгээд” гэж нэмэх	Энэ заалтыг хассан тул тусгаагүй.
	11/ 5.4-н “олговортойгоор” гэсний дараа “зөвшилцсөний үндсэн дээр” гэж нэмэх	Саналыг тусгасан. Хөрөнгийг хууль бусаар хураан авахгүй байх болон хураан авах тохиолдолд төлөх нөхөх олговрын талаар тусгасан.
	12/ 5-р зүйлд “Хууль тогтоомжийн хүрээнд төрөөс иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой хамаарах асуудлын хүрээнд гаргасан шийдвэрийг төрийн өмчит хуулийн этгээд биелүүлэхээс татгалзах эрхгүй байх” гэж шинэ заалт нэмэх	Уг хуулиар төрийн байгууллага, албан хаагчид шийдвэр гаргах, хэрэгжүүлэхдээ дагаж мөрдөх, хориглох хэм хэмжээг заасан. Төрийн өмчит хуулийн этгээдийн талаарх санал тул тусгаагүй.
	13/ 5-р зүйлд “Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой төр захиргааны байгууллага дангаар шийдвэрлэх боломжгүй асуудлыг холбогдох харьяаллын эрх бүхий	Тусгах шаардлагагүй

	байгууллагуудтай зөвшилцөн хамтран шийдвэрлэнэ” гэж шинэ заалт нэмэх	
	14/ “Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ хяналт шалгалт явуулж байгууллагууд харилцан уялдаа холбоотой ажиллаж, шалгалтын хугацаа давхцахгүй байх бөгөөд иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулна.” гэж шинэ заалт нэмэх	Агуулгын хувьд тусгасан.
	15/ “6.1.7.Эдийн засгийн харилцаанд хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдсэн хууль тогтоомж, тэдгээрийн зүйл заалтын давхардал, хийдлийг арилгах” гэж шинэ заалт нэмэх	Агуулгын хувьд тусгасан.
	16/ 9.1.-т энэ төрлийн гомдлыг дагнан шийдвэрлэдэг байгууллага тухайлан байгуулах, эсхүл санхүүгийн зохицуулах хороо, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд байгуулах. Үүнд аж ахуй эрхлэгчдийн холбооноос холбогдох төлөөллийг оролцуулах	Саналыг агуулгын хувьд тусгасан
	17/ 10.1-д заасан зөвлөлд Аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг оролцуулах саналтай байна. Аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл нь уг зөвлөлийн нэг бүрэлдэхүүн байх зүйтэй. Энэ нь эдийн засгийн хүрээнд аливаа тулгамдсан асуудлыг илүү бодитоор харж, үндэслэлтэй зөвлөмж гаргахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн тус зөвлөлд аль салбарын ямар ямар бүрэлдэхүүн багтах талаар тодорхой заагаагүй, ойлгомжгүй байна. Иймд тус заалттай холбогдуулж доорх хүснэгт дэх саналыг гаргаж байна.	Саналыг тусгасан.
	18/ 10.2-д Зөвлөлд Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Бизнес эрхлэгчдийн холбоо, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл багтсан байна. Гэсэн агуулга бүхий заалт шинээр нэмэх	Саналыг агуулгын хувьд тусгасан
	19/ 4.1.8-д “хөрөнгө оруулагчийн” гэсний өмнө “гадаад болон дотоодын” гэж нэмэх	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулсан бөгөөд гадаад, дотоод гэж ялгаагүй, бүх хөрөнгө оруулагчдыг хамруулсан. Иймд саналыг тусгаагүй.
	20/ Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжсэн төр, захиргааны байгууллагын шийдвэр нь үйл ажиллагааныхаа үндсэн бодлого, чиг үүрэгт нь нийцсэн байх гэсэн заалт нэмэх	Агуулгын хувьд туссан. Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эдийн засгийн эрх

		чөлөөний баталгааг хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцохгүй, хохирол, саад учруулахгүй байхад чиглэнэ. Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	чөлөөний баталгааг хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцохгүй, хохирол, саад учруулахгүй байхад чиглэнэ.
		21/9-р зүйлд “хууль тогтоомжийн хэрэгжилтийг /эрх олгосон, зөвшөөрсөн/ хангуулахаар төр, захиргааны байгууллагад гаргасан иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг төр, захиргааны байгууллага шийдвэрлээгүй нь иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд: 1/Төслийн 3.3-т энэ хуулиар тогтоосон зарчим, зохицуулалтад нийцээгүй хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөхгүй гэж заасан. Төслийн 3.3-т энэхүү суурь хуулиар нөлөөлөгдөх бусад хуулийг жагсааж бичих. Учир нь яам, агентлагууд хуулийг өөрөөр тайлбарлах, хуульд нийцээгүй үйлдэл гаргах эрсдэлтэй. Дээрх заалтыг нэмснээр 4, 5 дугаар зүйл илүү ойлгомжтой болно. Мөн төслийн 5.15 дахь хэсэгт заасан хууль, журам зөрчилдвөл хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалтыг баримтлах тухай заалт ойлгомжтой болно. Хуулийг жагсаах нь энэхүү суурь хуулийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.	Энэ хэсгийг хуулийн төслөөс хассан тул тусгаагүй.
8.	Дэлхийн банк (2025.10.01 148/25)	2/Төслийн 9 дүгээр зүйлд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн гомдол гаргах эрхийн талаар заасан. Гэвч хэрхэн гомдол гаргах, хэнд гаргах, хэрхэн хэрэгжүүлэх гэх мэт процессыг дэлгэрүүлэх шаардлагатай. 3/Төслийн 10.3.3-т Эдийн засгийн бодлогын зөвлөл хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэнэ гэж заасан байгаа нь зөвхөн урьдчилан сэргийлэх буюу асуудал гарахын өмнө гаргах гомдлуудыг хамарсан байна. Иймд хуулийн төсөлд Эдийн засгийн бодлогын зөвлөл /Ombudsman/-ийн бүрэн эрх, гомдол гаргах, нөхөн төлбөрийн олгох журам, хяналтын механизм, төсөв болон боловсон хүчнийг бэлтгэх зэрэг хэрэгжилттэй холбоотой заалтуудыг нэмэх. Эдгээр заалт байхгүй тохиолдолд хуулийн	Өөрчлөн найруулах. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан Хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зөвлөлд гомдол гаргахаар хуулийг эшлэх. Өөрчлөн найруулах. Эдийн засгийн бодлогын зөвлөл нь хуулийн хэрэгжилтийн талаар иргэд, аж ахуйн нэгжээс санал, гомдол авна. Иймд нөхөн төлбөр олгохтой холбоотой асуудал орохгүй. Харин аж ахуйн нэгжээс хохирсон талаарх гомдлыг Хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зөвлөлд гаргана.

	төсөл тунхгийн шинтэй, хэрэгжих боломжгүй болох эрсдэлтэй байна.	
	4/Төслийн 5.4-т зөвхөн “түүнтэй адилтгах” нөхөн төлбөр биш, “нөхөн төлбөр нь шуурхай, хангалттай, үр дүнтэй” байх, түүний үнэлгээ нь зах зээлийн үнэлгээнд суурилсан, эсхүл өөр стандартад нийцсэн байхаар тодорхой тусгах. Хөрөнгө хураан авахтай холбоотой олон улсын стандартад нийцүүлэн “хөрөнгийг зөвхөн нийтийн ашиг сонирхлын төлөө, хуулийн дагуу, үл ялгаварлах зарчмын дагуу хураах, нөхөн төлбөр нь “шуурхай, үр дүнтэй, хангалттай” байх Халлын томъёог тусгах. Мөн ямар нэгэн хэлбэрээр ялгаварлаж хөрөнгө хураан авахыг хориглосон заалт оруулах. Нөхөн төлбөр хууль ёсны эсэх, хангалттай эсэхийг шалгуулахаар шүүхэд хандах боломжтой байх заалтыг нэмэх. 5/Хуулийг буцаан хэрэглэхгүй байх: төслийн 5.1.5-д заасан хууль буцаан хэрэглэхтэй холбоотой томъёолол ойлгомжгүй байна. Бизнесийн үйл ажиллагааг доордуулах хуулийг буцаан хэрэглэхгүй гэж заахыг оронд эрх зүйн байдлыг дээрдүүлсэн журмыг батлах гэж заасан нь ойлгомжгүй байна. 5.1.5-ыг дараах байдлаар өөрчлөх: “хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчийн үйл ажиллагааг доордуулах хууль, журам, захиргааны хэм хэмжээний актыг буцаан хэрэглэхгүй. Хэрэв Үндсэн хуульд заасан, эсхүл нийтийн ашиг сонирхлын шаардлагаар, нөхөн төлбөртэй тохиолдолд энэ заалт хамаарахгүй.” - эрх зүйн байдал дээрдсэн тухайлбал, татварын хөнгөлөлт зэрэг тохиолдолд буцаан хэрэглэж болох тухай тодруулж тусгах. - өмнө олгогдсон байсан эрхэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж гэрээ, лицензийг тогтвортой байх талаар тусгах 6/Төслийн 4.1.2-т заасан тэгш эрх нь гадаад, дотоод бизнес эрхлэгчид хамаарахыг тодруулж өгөх; -үндэсний дэглэм, үндэстний нэн тааламжтай нөхцөлийг тусгах; -төрийн өмчит аж ахуйн нэгж зөвшөөрөл авах, зах зээлд нэвтрэх зэрэгт давуу эрх эдлэхгүй байх, шударга өрсөлдөх талаар заалт нэхэх.	Өөрчлөн найруулах. Нөхөн төлбөртэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг ХОТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.
		Энэ заалтыг хассан тул тусгах шаардлагагүй.
		-Хөрөнгө оруулалтын тухай хуулиар хөрөнгө оруулагчийг гадаад, дотоод гэж ангилж ялгаагүй тул ялгах шаардлагагүй. -Шударга өрсөлдөөний зарчмыг тусгасан.

	-Монголын өрсөлдөөний байгууллагад шударга өрсөлдөх буй эсэхэд хяналт тавих эрхийг нэмэх. 7/Төслийн 6.1.4-т эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж, хориглосон хуулийн төслийг олон нийтэд байршуулж, санал авах талаар дурдсан байна. Гэхдээ яагаад эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж, хориглох вэ? Үүний оронд бүхий л хуулийн төслийг олон нийтэд байршуулж, санал авахаар тусгах нь зүйтэй. Өмнө дурдсанчлан 3.2-т энэ хуулийн үйлчлэлд хамаарах, хамаарахгүй хуулийн жагсаалтыг оруулж өгөх нь олон нийтээс санал авах хуулийг илүү ойлгомжтой тодорхой болгоно. 8/Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай заалт байхгүй байна. Иймд хууль тогтоомж, журам боловсруулах, хэлэлцүүлэг явуулах үед ашиг сонирхлын зөрчлийг хэрхэн зохицуулах талаар тодорхой заалт оруулах. 9/Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээг нэвтрүүлэх. Хэм хэмжээний акт боловсруулах, батлах процессыг сайжруулах. Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ нь асуудал, зорилго, сонголтуудыг тодорхойлох, үр ашиг, зардлын үнэлгээ хийх, шийдлийг олох, хянах, үнэлгээ хийхтэй холбоотой бодлогын зорилгод хүрэх системтэй үнэлгээний механизмыг бий болгох. 10/Хуулийн төсөлд хэрэгжүүлэлттэй холбоотой заалт ороогүй байна: -төслийн 4.1.6, 6.1.1, 8.1-т заасан заалтуудын хувьд бүх журам, арга хэмжээг цахим хэлбэрээр 1 портал дээр нийтлэгддэг байхаар тусгах -төслийн 8.2-т заасан төр өөрт байгаа мэдээллийг шаардахгүй гэснийг хэрэгжүүлэхийн тулд төрийн байгууллагууд мэдээллээ хоорондоо шуурхай хуваалцдаг байх эрх зүйн зохицуулалтын бий болгох -төслийн 7.4-т институцийн механизмыг тодорхойлох нь чухал. 11/Хөрөнгө оруулагчийг хамгаалах. Төслийн 5.1.14-т заасан албадлагын арга хэмжээ нь үл ялгаварлах, үйлдлийн шинж чанарт тохирсон, зайлшгүй шаардлагатай тохиолдолд байх зарчмыг тусгах.	Саналыг тусгаж өөрчлөн найруулсан. Агуулгын хувьд туссан. Ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд төрийн байгууллага, албан тушаалтнаас татгалзах эрхийн талаар туссан. Энэ хуулиар зохицуулах харилцаа биш байх тул тусгаагүй. Саналыг тусгасан. Хөрөнгө оруулагчийг хамгаалах механизм Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд туссан.
--	--	--

	12/Төрийн албан хаагчийн хувийн хариуцлагыг нэмэх.	Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлд оруулах
	13/Гомдол шийдвэрлэх механизмыг тусгах.	ХОТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зөвлөл гомдол шийдвэрлэхээр туссан.
	14/Төслийн 4.1.2 эсхүл 5 дугаар зүйлд “үндэсний аюулгүй байдал эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөө хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулагчид Монгол улсад бизнес эрхлэхэд эрх тэгш байна.” гэж нэмэх.	Агуулгын хувьд туссан.
	15/Сөрөг жагсаалт гаргах. Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан, бусад салбарт тэгш эрхтэй оролцохыг тодруулах.	Энэ хуулиар зохицуулах харилцаа биш тул тусгаагүй.
	16/Төрийн албан хаагчийн буруутай үйлдлээс шалтгаалан учирсан хохирлын нөхөн төлбөрийн стандарт, хэрхэн нөхөн төлбөрийг авах талаар заалт байхгүй байна. Нөхөн төлбөрт шууд учирсан хохирол болон олох байсан ашиг орно. Мөн хувь хүний зөрчлийн, иргэний, эрүүгийн хариуцлага тооцох.	Агуулгын хувьд тусгасан. Төрийн албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирол учирсан бол иргэний журмаар шаардах эрх нь нээлттэй. Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
	17/Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд гомдол гаргах механизмыг бий болгох.	Энэ механизм, шүүхэд хохирлоо төлүүлэхээр гомдол гаргах эрх нь одоо үйлчилж буй хуулиудад байх тул саналыг тусгаагүй.
	18/Хариуцлага тооцсон төрийн албан хаагчийн мэдээллийг нээлттэй мэдээлэх тогтолцоог бий болгох.	Энэ хуулиар зохицуулах харилцаа биш тул тусгаагүй.
	19/Хяналт шалгалт, хариуцлага, захиргааны арга хэмжээг шалгах, хууль бус болох нь тогтоогдвол хүчингүй болгох заалт оруулах.	Энэ хуулиар зохицуулах харилцаа биш тул тусгаагүй.
	20/Төслийн 10.1.3-т заасан хууль, журмын төслийг бүх эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой хуулийн төсөлд хамаарахаар тусгах.	Саналыг тусгасан.
	21/Төслийн 10.3.3-т гомдол гаргах механизм, ЭЗБЗ-өөс авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг нарийвчлах.	Тус заалтыг өөрчлөн найруулсан.

	22/ЭЗБЗ-ийн гишүүдийг хэрхэн томилох, хэн томилох, хувийн хэвшлийн төлөөлөл оролцох эсэх, ямар салбарын төлөөллүүд орох, жижиг, орон нутгийн бизнесийн төлөөлөл оролцох эсэх, гишүүдийг чөлөөлөх, хэрхэн шийдвэр гаргах.	Саналыг тусгаж, хараат бус гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгох талаар тусгасан.
	23/Төслийн 7 дугаар зүйлд төр, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн хамтын ажиллагааны талаар заасан ч сонгон шалгаруулах /өрсөлдөөнт сонгон шалгаруулалт, шударга, ил тод байх/ зарчмыг тусгаагүй байна. Мөн хяналт тавих, эргэн мэдээлэх үүргийн талаар тусгаагүй. Мөнгөний үнэ цэнийн үнэлгээ, эсхүл гэрээний ил тод байдлын талаар дурдаагүй. Иймд: -Ил тод сонгон шалгаруулах журмыг нэвтрүүлэх. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд өрсөлдөөнт, ил тод, үл ялгаварлах сонгон шалгаруулалтын дагуу явагдах. Онцгой тохиолдолд л шууд гэрээ хийх нөхцөл олгохоор тусгах. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль: 1/түншлэлийн түншлэлийн гэрээнд тавих хяналтыг сайжруулах. Салбарын яамд, хувийн хэвшлийн хяналтыг жил тутам хийх, том төслийн хувьд хараат бус аудитын байгууллагаар шалгуулах механизмыг бий болгох. 2/Гэрээнд үүрэг гүйцэтгээгүй тохиолдолд торгууль ногдуулах, иргэд ТХХТ-ийн төслийн үйл ажиллагааны тайланг үзэж танилцах, хариуцлагыг нэмэгдүүлэх. 3/2022 оны ТХХТХ-ийг эшлэх. 4/төслийн 4.1.1, 4.1.5, 7.1-т төрийн үйл ажиллагаатай холбоотой заалт оруулсан ч ямар тохиолдолд хэрхэн оролцох талаар тусгаагүй байна. Иймд салбарын хуулиудад тусгах. 5/төслийн 7.2-т төр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гадаадын зээл, тусламж, тухайн шатны жил бүрийн төсөвт тусган шийдвэрлүүлнэ гэж заасан ч хэн тусламж өгөх талаар заагаагүй. төслийн 7.3-т түр болон бүрмөсөн эзэмшүүлэх, ашиглуулах журмыг тогтоох.	-Саналыг агуулгын хувьд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуульд хараат бус гишүүнд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах журам батлахаар тусгасан. Мөн Эдийн засгийн зөвлөл хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахад ашиг сонирхол нь хөндөгдөх аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж болон мэргэжлийн холбоодын саналыг хүлээн авах, холбогдох төрийн байгууллагад саналыг хүргүүлэх, саналыг шийдвэрт тусгасан эсэх талаар эргэн мэдээлэх зэрэг шийдвэр гаргалтад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн оролцоог хангах чиг үүргийг тусгасан. - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулах асуудал тул энэ хуулийн төсөлд тусгаагүй.
	24/төсөлд байгаль орчин, хөдөлмөр, хэрэглэгчийг хамгаалах, жэндер, бус нутгийн эд хөрөнгийн асуудлын талаар тусгаагүй	Эдийн засгийн эрх чөлөөний баталгааг хангах суурь хууль тул саналыг тусгаагүй.

		байна. Хуулийн төсөл нь эдгээр асуудлаар нарийвчилсан зохицуулалт оруулах нь зохимжгүй хэдий ч улсын хэмжээнд зарчмыг тодорхойлж болно. Тухайлбал: -байгаль орчин, тогтвортой байдлын тухайд: бизнес нь Монгол улсын байгаль орчны хууль, байгаль орчин, тогтвортой байдлын зарчмыг баримтлах -Хөдөлмөр, хэрэглэгчийг хамгаалах: эдийн засгийн эрх чөлөө нь бизнесийн байгууллагыг хөдөлмөрийн эрх, ажлын байрны аюулгүй байдал, хэрэглэгчийг хамгаалах хууль дагаж мөрдөх үүргээс чөлөөлөхгүй. -Жэндер, нийгмийн оролцоо: эмэгтэйчүүд, хүүхдүүд, тусгай хэрэгцээт хүмүүсийн бизнесийг дэмжих, -бүс нутгийн эд хөрөнгө: орон нутаг, хөгжил бага бүс нутагт хөрөнгө оруулалтыг дэмжих	
9.	Иргэн Цогтжаргал	1/Хуулийн төсөлд “аж ахуйн үйл ажиллагаа” гэж нэр томъёоны ойлголтыг өгөх шаардлагатай. 2/Хөдөө аж ахуй, мал аж ахуй, жижиг дунд бизнес гээд хуулийг нэг мөр ойлгох ойлголтыг тусгах. Төсөлд туссанаар явбал ирээдүйд хуулийн цоорхой гарах магадлалтай байна.	Саналыг тусгасан. Энэ заалтыг хассан тул тусгаагүй.
10.	Иргэн Шинэгэрэл (Legalinfo.mn)	1/ Ийм хууль гаргаад эдийн засгийн эрх чөлөө хангагдахгүй, хууль олширвол эрх чөлөө л хумигддаг. 2/ “10 дугаар зүйл.Эдийн засгийн зөвлөл, түүний бүрэн эрх” 1/Санхүү, мөнгөний салбарт төлбөр тооцоог түргэн шуурхай явуулахад саад болсон бүх хязгаарлалтыг цуцлах. Жишээ нь улс дотроо валют шилжүүлэхэд заавал төгрөгт хөрвүүлж байж шилжүүлдэг явдлыг цуцлах гэх мэт шилжүүлгийн дүнг хязгаарлах гэх мэт саад тээгийг арилгах.	Эдийн засгийн эрх чөлөөний баталгааг хангаж буй хуулийн төсөл бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн актын хэм хэмжээ нь энэ хуулиар баталгаажуулсан эдийн засгийн эрх чөлөөг хангах хэм хэмжээг дордуулахыг хориглоно.
11.	Иргэн Даалхай (Legalinfo.mn)	2/ Төр бизнесийн салбарт хувийн аж ахуй нэгжүүдтэй зэрэгцэн бизнес хийхгүй байх. Төрийн өмчит ААН-үүдийг татан буулгах,	Тус хуулиар зохицуулах асуудалд хамаарахгүй тул тусгаагүй. Тус хуулиар зохицуулах асуудалд хамаарахгүй тул тусгаагүй.

	хувьчлах. Төр аж ахуйн ажил хийхгүй байх. төр зөвхөн татвараа аваад хууль дүрмийн хэрэгжилтдээ хяналт тавиад явах.	
3/5-р зүйлд: Хил гаалийн нэвтрэх чадварыг асар хурдан болгох талаар өндөр анхаарах, гаалийн хяналт шалгалтыг бүрэн ухаалаг болгож хүний оролцоог багасгах, улс хоорондын хүн болон ачаа тээврийг түргэн шуурхай хилээр нэвтрүүлэх нөхцөлөөр хангах, гаалийн татварыг аль болох бага байлгах талаар анхаарах тухай заалт оруулах.	5.1.3.аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн тэгш эрхийн зарчим; 5.1.4.шударга өрсөлдөөний зарчим;	
4/ 5-р зүйлд: Компани байгуулах, нэр сонгох, хүсэлтээ явуулахаас эхлээд гэрчилгээгээ авах хүртэлх бүх процессыг бүрэн цахимжуулах. Аль болох цааснаас татгалзах, биеэр албан байгууллагуудаар явах явдлыг байхгүй болгох.	Саналыг агуулгын хувьд тусгасан.	
5/ 5.1.1-т: Томоохон ААН үүдийг хэн нэгэн улс төрч, намын дургүйг хүргэснээс болж гэнэтийн шалгалт, нэгжлэг хийж, дансыг нь хаах гэх мэтээр дарамтлах, залхаан цээрлүүлэх шинжтэй улс төрийн нөлөөлөл сүүлийн жилүүдэд их ажиглагдах болсон тул улс төрөөс бизнесийн орчныг хамгаалах шинжтэй заалт нэмж оруулах	Саналыг агуулгын хувьд тусгасан.	
6/ “5.4.Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэйгээс бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эд хөрөнгийг хураан авч болохгүй. Хуульд заасан тохиолдолд улсын хэрэгцээнд зориулан эд хөрөнгийг түүнтэй адилтгах нөхөн олговортойгоор албадан хурааж болно.” ААН-үдийн дансыг хаах царцаах явдал сүүлийн үед түгээмэл болсон. үүнийг таслан зогсоох хэрэгтэй. Данс царцаах явдлыг хэнээс зөвшөөрөл авч хийх ёстойг нарийн заах.	Саналыг тусгасан. Хөрөнгийг хууль бусаар хураан авахгүй байх, хураан авах тохиолдолд олгох нөхөх олговрын талаар тусгасан. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд мөн нарийвчлан тусгасан.	
7/ “5.5.Хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн бие мах бодид халдах, хүчирхийлэл үйлдэх, эд хөрөнгийг сүйтгэх зэргээр хууль бус арга, хэрэгсэл ашиглах, тэдгээрийн энэ хуульд заасан эдийн засгийн эрх чөлөөнд халдах, халдахаар завдахыг хориглоно” Хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр төрд халдах, зохион байгуулалттай гүтгэх, хов цуу яриа үүсгэх явдлаас хамгаалах тал дээр анхаарах	Саналыг тусгасан.	
8/ “6.1.3.аж ахуйн үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, захиргааны шийдвэрээр тогтоох шаардлага нь хөрөнгө оруулагч,	Саналыг тусгаж өөрчлөн найруулсан.	

	аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн бизнесийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх.” Өгүүлбэрийн утга санаа ойлгомжгүй байна.	аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гадаадын зээл, тусламж, тухайн шатны жил бүрийн төсөвт тусган шийдвэрлүүлнэ”	
	10/ Төсөл хөтөлбөрийн үр дүн, зарцуулалтыг нээлттэй ил тод тайлагнадаг байх.	Уг хуулиар зохицуулах харилцаа биш тул тусгаагүй.	Уг хуулиар зохицуулах харилцаа биш тул тусгаагүй.
	11/ “7.4.Төр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалтын давхардлыг арилгах, улсын бүртгэл, зөвшөөрөл, татварын тогтолцоог боловсронгуй болгох санал, хүсэлтийг жилд 1-ээс доошгүй удаа хүлээн авч шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ” Авсан санал хүсэлтүүдийн дагуу авсан арга хэмжээ, шийдвэрүүдийг нээлттэй ил тод мэдээлж тайлагнадаг байх.	Саналыг тусгасан.	
	12/ “10 дугаар зүйл.Эдийн засгийн зөвлөл, түүний бүрэн эрх” Эдийн засгийн бодлогын зөвлөлийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог байх	Саналыг тусгасан	
12.	Иргэн Билэгт-Очир (Legalinfo.mn)	Тус хуулиар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зарчим, хориглох үйл ажиллагааг тусгасан суурь асуудлыг зохицуулна.	
13.	Иргэн Хонгорзул (Legalinfo.mn)	Агуулгын хувьд туссан. Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	
	2/ “5.1.4.төрөөс зарим аж ахуйн нэгжид давуу эрх олгосон хууль тогтоомж гаргах, захиргааны шийдвэр, үйл ажиллагаа явуулахгүй	Тэгш эрхийн зарчмын дагуу зарим аж ахуйн нэгжид давуу эрх олгохгүй байхаар тусгасан.	

	байх” гэж заасан. ЭТТ ХК-н 4-н худалдан авагчид давуу эрхтэйгээр нүүрс борлуулж, тээврийн квотыг өгч байгаа, 4-н худалдан авагч давуу эрхтэйгээр Улс хоорондын С зөвшөөрлийг өөрийн хамаарал бүхий тээврийн байгууллагат авч ажиллаж байна, мөн тус зөвшөөрөлтэй тээврийн байгууллагуудын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэйгээр хилээр гарах хуваарьт тавигдаж ажиллаж байна. Нийт 800-н машины давхар чиргүүлтэй 1600 тэвштэй машин давуу эрхтэй байна. Үүнийг судалж үзэж шийдвэрлэх арга зармыг эрэлхийлэхийг хүсэж байна	
	3/ "5.1.6.хууль тогтоомжид нийцээгүй, эсхүл хуулиар тогтоосон журам зөрчиж баталсан хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоотой шийдвэрийг зохих журмын дагуу хүчингүй болгох” гэж заасан. Байгаль, орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 3-р сарын 20-ны өдрийн 1/71 дүгээр тушаал нь ТТ-ГС чиглэлийн хатуу хучилттай авто замаар явж байгаа хүнд даацын авто тээврийн хэрэгсэл тус бүрээс хураамж авах хэм хэмжээний акт зөрчсөн тушаалыг цуцлах хүсэлтэй байгаа	Тус хуулиар зохицуулах харилцаа биш тул саналыг тусгах боломжгүй.
	4/ "5.1.9.аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай хүсэлтийн талаарх төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргах үйл явцыг цахим хэлбэрээр харах боломжтой, ил тод, нээлттэй байх” гэж заасан. Боомтын зөвлөлөөс гаргасан хилээр гарах экспортын тээврийн нэгдсэн хуваарийг гаргадаг, энэ хуваарь нь ил тод бус хийгддэг, үүнийг цахимжуулж ил тод болгохыг хүсэж байна	Саналыг агуулгын хувьд тусгасан.
	5/ "6.1.1.аж ахуйн үйл ажиллагааны талаар батлах хууль тогтоомж, шийдвэр нь үндэслэл бүхий, тодорхой байх; батлагдсан хууль тогтоомж, шийдвэрийн талаарх мэдээлэл, ил тод нээлттэй байх.” Аж хуйн үйл ажиллагааны талаар батлах хууль, тогтоол, шийдвэрт тухайн салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан олон нийтийн хэлэлцүүлгийг 3-аас доошгүй удаа зохион байгуулж саналыг авах	Саналыг агуулгын хувьд тусгасан.
	6/ "6.1.4.эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлаж, хориглосон хууль тогтоомжийг батлахын өмнө хууль тогтоомжийн төслийг бүрдүүлбэрийн хамт Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем	Хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан.

		(legalinfo)-д хуанлийн 90 хоногоос доошгүй хугацаанд нээлттэй байршуулж, олон нийтээс санал авах” Олон нийтэд мэдээллийг цахимаар, үүрэн холбоогоор хүргэж гэж нэмэх Тавигдсаныг мэдэхгүй өнгөрөх олон тохиолдол байдаг тиймээс утас руу msg зэр ирүүлж мэдээлэл хүргэх боломжтой эсэх.	
		7/ “7.1.3.Дэд бүтцийн үйлчилгээ: Зам, гүүр, ус, цахилгаан, холбоо зэрэг дэд бүтэц, үйлчилгээний хөгжүүлэлт, засвар үйлчилгээ,” Тээврийн нэгдсэн системийн үйлчилгээ, программ хангамж.	Хуулийн төсөлд бусад газраас ирүүлсэн саналыг үндэслэн тус заалтыг хассан.

--oOo--